29. Цэвэр эрх зүйн онол
30. Хууль зүйн позитивизм
31. Прагматик позитивизм
32. Неопозитивизм
33. Марксист эрх зүйн философи
34. Амьд эрх ба позитив эрх
35. Интиутив эрх ба позитив эрх



- 36.Фенеменологи эрх зүйн фиилософи
- 37.Экзистенциалист эрх зүйн философи
- 38.Герменевтика эрх зүйн философи
- 39.Мөнх тэнгэрийг шүтэх үзэл ба төрийг шүтэх үзэл
- 40.Төрийг шүтэх үзэл ба хуулийг дээдлэх үзэл
- 41.Монголчуудын төр ёсны үзэл
- 42.Хоёр ёсны үзэл
- 43.Монголын нууц товчоон дахь төр, эрх зүйн сэтгэлгээ
- 44.Монголын эрх зүйн сэтгэлгээний хөгжил, онцлог
- 45.Сократын эрх зүйн философи
- 46.Платоны эрх зүйн философи
- 47.Аристотелийн эрх зүйн философи
- 48.Ромын хуульчдын эрх зүйн сэтгэлгээ
- 49.Аквины Фомагийн төр, эрх зүйн сэтгэлгээ
- 50.Гуго Гроцийн төр, эрх зүйн сэтгэлгээ
- 51.Монтескьегийн төр, эрх зүйн сэтгэлгээ
- 52.Томас Гоббсын төр, эрх зүйн сэтгэлгээ
- 53.Жон Локкийн төр, эрх зүйн сэтгэлгээ
- 54.Кантын эрх зүйн философи
- 55.Кант: Мөнхийн энхтайваны тухай
- 56.Гегелийн эрх зүйн философи
- 57.Гегель: Эрх зүйн үндэс, ойлголт
- 58.Гегель: Хийсвэр эрх
- 59.Гегель: Зан суртахуун
- 60.Гегель: Ёс суртахуун
- 61.Маркс: Өмч ба эрх зүй
- 62.Эрх чөлөө ба өмч
- 63.Өмч ба гэрээний асуудлыг эрх зүйн философийн үүднээс авч үзэх нь
- 64.Гэмт хэрэг ба ялын асуудлыг эрх зүйн философийн үүднээс авч үзэх нь
- 65.Эрх зүй ба хэл зүй
- 66.Эрх зүй ба мэдээлэл зүй
- 67.Эрх зүй ба плюрализм
- 68.Эрх зүйн танин мэдэхүй ба логик
- 69.Шударга ёсны процедурын онол
- 70.Үнэний онол

1.8. ЭРХ ЗҮЙН ФИЛОСОФИЙН ХИЧЭЭЛЭЭР ГҮЙЦЭТГЭХ АЖИЛБАРЫН УДИРДАМЖ.

Зорилго: Оюутан лекцийн хичээлээр олсон мэдлэгээ бататгаж гүнзгийрүүлэн, бие даан хөдөлмөрлөх явцдаа сурах, судлах арга барилыг хэр эзэмшиж байгааг бодитой үнэлэхэд оршино.

Хугацаа: Дор дурьдсан хувилбаруудаас нэгийг сонгож, улирлын 16 долоон хоногт багтаан гүйцэтгэж хамгаалсан байна.

Үнэлгээ: Сэдвийн агуулгад 7 оноо, боловсруулалтад 7 оноо, шүүмж дүгнэлтэд 6 оноо нийт 20 оноогоор дүгнэнэ.

I хувилбар: Илтгэл

Оюутан хөтөлбөрийн хүрээнд сонирхож сонгосон сэдвийн дагуу эрдэм шинжилгээний илтгэл бичиж хэлэлцүүлнэ. Хэд хэдэн оюутан хамтарч судалгаа хийж, түүний үр дүнг илтгэл тавьж хэлэлцүүлж болно. Илтгэлийг семинарын хичээлээр хэлэлцэнэ. Илтгэл 5-8 хуудас байна. Шалгарсан сайн илтгэлийг оюутны эрдэм шинжилгээний хурлаар хэлэлцүүлж, зохиогчийн нэрээр хэвлүүлнэ.

II хувилбар: Шүүмж

Оюутан бие даан суралцах явцдаа уншиж судалсан нэг ном, өгүүллийг сонгон авч, агуулгыг 1-2 хуудсанд багтаан шүүмж бичнэ. Шүүмж нь зохиогчийн тухай, ном, өгүүллийн агуулга, шинэлэг санаа, ололт дутагдал, дүгнэлт тайлбар гэсэн бүтэцтэй байна. Шаардлага хангасан шүүмжийг хэвлүүлнэ.

III хувилбар: Өгүүлэл

Оюутан сонирхсон сэдвийн дагуу 5-10 хуудсанд багтаан судалгаа, шинжилгээний чанартай өгүүлэл бичнэ. Сэдэв нь тухайлсан ойлголт, категори, асуудалд төвлөрсөн байна. Өгүүлэлийг судалгааны өндөр түвшинд бичиж, шинэлэг санаа дэвшүүлсэн бол эрдэм шинжилгээний хуралд хэлэлцүүлэх буюу зохиогчийн нэрээр хэвлүүлнэ.

IV хувилбар: Эссе

Оюутан хөтөлбөрийн хүрээнд хөндөн хэлэлцэж буй аливаа нэгэн асуудлаар өөрийн үзэл баримтлалыг шинжлэх ухааны үндэслэлтэйгээр тайлбарлаж, уран сайхны хэлбэрээр бичнэ. Эссе 2-5 хуудас байна. Судалгааны өндөр түвшинд бичиж, шинэ санаа дэвшүүлсэн бол хэвлүүлнэ.



V хувилбар: Схем, загвар

Хөтөлбөрийн хүрээнд судалсан нэг сэдэв (дэд сэдэв, өгүүлэл, ном бүтээл байж болно) сонгон авч, агуулгыг бүдүүвчлэн хүснэгтлэх, зураглах зэргээр ерөнхийлэн ойлгомжтойгоор илэрхийлнэ. Схем, загвар нь уг сэдвийн болон ном бүтээлийн агуулгыг бүрэн гаргасан эсэх нь энэхүү хувилбараар гүйцэтгэх ажилбарын үндсэн шаардлага болно.

VI хувилбар: Дүгнэлт

Оюутан хичээлийн хөтөлбөрийн дагуу нэг сэдэв (тодорхой асуудал, өгүүлэл, ном бүтээл байж болно) сонгон авч, шинэлэг санаа, санал, тайлбарт өөрийн байр сууринаас үнэлэлт, дүгнэлт, тайлбар өгнө. Дүгнэлт, тайлбарын шинжлэх ухаанч үндэслэл нь онооны шалгуур үзүүлэлт болно. Хэмжээ 2-3 хуудас.

VII хувилбар: Реферат

Оюутан бие даах ажлын сэдвүүдээс (хөтөлбөрийн дагуу уншиж судалсан нэг ном байж болно) сонгон авч, холбогдох ном материалыг бүрэн ашиглаж, сэдвийн агуулгыг гарган өөрийн дүгнэлтийг өгнө. Рефератыг уншсан хүн уг сэдэв, номыг “уншиж судалсан”-ы адил мэдлэг олж авах нь энэхүү ажилбарын гол шаардлага болно. Шаардлага хангасан рефератыг сургалтад ашиглана. Хэмжээ - 5-12 хуудас

VIII хувилбар: Хөрвүүлэг

Оюутан гадаад хэлээр ашиглаж байгаа сурах бичиг, гарын авлагаас багшийн санал болгосон сэдвийг сонгож, эх хэлээр орчуулна. Ажилбарыг ийм хэлбэрээр гүйцэтгэх нь “Эрх зүйн философи”-н хичээлээр эх хэл дээр ашиглах материал хомс бага байгааг харгалзаж, шаардлага хангасан хөрвүүлгийг сургалтад ашиглах зорилго бүхий болно.

1.9. “ЭРХ ЗҮЙН ФИЛОСОФИ” ХИЧЭЭЛИЙН ҮНЭЛГЭЭ

Үнэлгээний зорилго:

Хичээлээр олж авсан мэдлэг, сэтгэлгээний хандлага, үнэт зүйлийг үнэлэх үнэлэмж, мэдлэгийн чадварыг үнэн зөв үнэлэх явдал болно.

Үнэлгээний шалгуур:

Үнэлэх зүйл	Үнэлэх жишиг шалгуур
Мэдлэг	- Мэдлэгээ тайлбарлах, бусдад ойлгуулж чадаж байгаа эсэх - Асуудалд онолын үндэслэлтэй хандах, тайлбарлаж чадаж байгаа эсэх - Эрх зүйн үзэгдлүүдийн мөн чанар, агуулга, түүний илрэл, тэдгээрийн харилцан хамаарлыг ойлгож, тайлбарлаж чадах эсэх - Эрх зүйн философийн онолын чиг хандлагуудын агуулга, онцлогыг танин мэдэж, тайлбарлаж чадах эсэх
Чадвар	- Эрх зүйн үзэгдлүүдийн мөн чанар, агуулга, түүний илрэл, тэдгээрийн харилцан хамаарлыг онол- арга зүйн үүднээс тайлбарлаж чадах эсэх - Эрх зүйн философийн онолын чиг хандлагуудын агуулга, онцлогын онол- арга зүйн үндэслэлийг тайлбарлаж чадах эсэх - Эрх зүйн философийн мэдлэгийг ашиглан эрх зүйн асуудалд онолын үндэслэлтэй тайлбар, шүүмж хийх чадвар
Сэтгэлгээний хандлага	- Эрх зүйн онолын үндэслэлийг тайлбарлах, шүүмжлэх чадварыг эзэмшсэн эсэх - Эрх зүйн үзэгдлүүдийн агуулга, түүний илрэх хэлбэрийн харилцан хамаарлын логик уялдаа холбоог тайлбарлах чадварыг эзэмшсэн эсэх - Оюутан өөрийн үзэл бодол, байр суурийг илэрхийлэх, үндэслэлээ зөв тайлбарлах чадвартай эсэх
Шинжлэх ухааны онол- арга зүйн чадвар	- Эрх зүйн үзэгдлүүдэд хандах, эрх зүйн асуудлыг шийдвэрлэхдээ холбогдох онол- арга зүйг хэрэглэх чадварыг эзэмшсэн эсэх - Эрх зүйн онолыг хөгжлийн түвшнээр нь болон ялгаатай онолуудыг харьцуулан онол- арга зүйн үүднээс дүгнэлт, шүүмж хийх чадварыг эзэмшсэн эсэх



ХОЁР. “ЭРХ ЗҮЙН ФИЛОСОФИ” ХИЧЭЭЛИЙН АГУУЛГА

А. “ЭРХ ЗҮЙН ФИЛОСОФИ”-Н ҮНДСЭН АСУУДАЛ

I бүлэг

“Эрх зүйн философи”-н ойлголт, шинж, онцлог

Зорилго: “Эрх зүйн философи”-н зорилго, судлагдахуун, судалгааны арга зүйн онцлог болон “Эрх зүйн философи”-н хууль зүйн шинжлэх ухаанд эзлэх байр суурь, эрх зүйг онолын түвшинд судалдаг бусад хичээлүүдээс ялгагдах онцлог, ач холбогдлыг танин мэдэж, үнэлдэг болох.

1. “Эрх зүйн философи”- эрх зүйн танин мэдэхүйн философи-эрх зүйн салбар мөн

“Эрх зүйн философи” нь хүн төрөлхтөний сэтгэлгээний үнэт зүйлсийн нэг юм. Хүн төрөлхтөн өөр хоорондын харилцааг зохицуулах хамгийн зохистой арга, хэлбэрийг эрж хайх эргэцүүллийн үр дүнд эрх зүй бий болсон бөгөөд эрх зүйн хөгжлийн явцад ямар эрх зүйг хамгийн зөв, шударга гэж үзэх вэ? гэсэн эрх зүйн сэтгэлгээний үр дүнд “Эрх зүйн философи” үүссэн юм.

Эрх зүйн санаа нь философи болон хөгжихөд эртний Грекийн сэтгэгчид ихээхэн хувь нэмэр оруулсан. Иймд “Эрх зүйн философи”-г үндэслэгчид нь нэрт сэтгэгч Сократ, Платон, Аристотель нар юм.

“Эрх зүйн философи”-н сэтгэлгээ нь МЭӨ V зууны дунд үеэс хөгжиж байсан эртний түүхэн уламжлалтай боловч “Эрх зүйн философи” гэсэн нэр томъёо нь XVIII зууны сүүлчээр үүсч, энэ үеэс шинжлэх ухааны бие даасан судлагдахуун болж өнөөг хүртэл хөгжиж байна. Германы хуульч Густав Гуго нь “эрхийн тухай сургаалын философийн хэсэг” гэсэн утгаар “Эрх зүйн философи”-н нэр томъёог анхлан бий болгожээ¹.

“Эрх зүйн философи” нь бие даасан судлагдахуун болж хөгжихөд Германы сонгодог философичид, ялангуяа сонгодог философич Г.В.Гегель ихээхэн хувь нэмрийг оруулжээ.

Г.В.Гегель нь “Эрх зүйн философи” номдоо: “Эрх зүйн тухай шинжлэх ухаан нь философийн нэг хэсэг мөн. Иймд энэхүү шинжлэх ухаан нь эрх зүйн өөрийн дотоод хөгжлийг шинжлэх, эсвэл эрх зүйн тухай санааг төсөөлөх эрхийн санааны

¹ 1.HugoG.Bei trage zur civilistischen Bucherkenntnis. Bd.I,Berlin,1829.s.372.

ойлголтоос л хөгжих ёстой”, “Эрх зүйн тухай философийн шинжлэх ухааны судлах зүйл нь эрх зүйн санаа болох эрх зүйн ойлголт, түүний хэрэгжилт” юм² гэжээ. “Эрх зүйн философи”-н судлагдахууны тухай Германы нэрт сэтгэгч Гегелийн үзэл санаа өнөөдөр ач холбогдлоо алдаагүй байна.

Оросын “Эрхийн философи”-н томоохон төлөөлөгч, эрдэмтэн В.С.Нерсесянц: “Эрх зүйн философи”-ийг эрх зүйг танин мэдэх оюуны дээд хэлбэр гэж тодорхойлоод, “Эрх зүйн философи нь төрийн хүсэл зориг, дур зоргоос үл хамааран эрх зүйн бодит агуулга, мөн чанарын тухай санаанаас эхэлдэг. Энэхүү эрх зүйн санаа нь эрхийн нэгдэл ба түүний дотоод харилцаа, эрх чөлөө ба шударга ёс, хүний эрх ба эрх чөлөө, эрх зүйн ноёрхол, эрх зүйт хууль ба эрх зүйт төрийн тухай өнөөгийн үзэл санааны үндэс нь болсон. Эрх зүйн тухай энэхүү санаанууд нь өнөөдөр бүх нийтээр хүлээн зөвшөөрөгдөж, орчин үеийн нийгмийн үнэт зүйлс болсон бөгөөд энэ бол “Эрх зүйн философи”-н гавьяа мөн. Энэ бүхэн бол нийгмийн шинжлэх ухаанд болон хууль зүйн шинжлэх ухаанд “Эрх зүйн философи”-н эзлэх байр суурь, түүний ач холбогдлыг тодорхойлж байна гэжээ³.

Хүн төрөлхтөн үүссэн цагаасаа эхлэн юу үнэн, юу шударга, юу сайн, юу муу вэ гэдгийг эрж хайж ирсэн. Хүний оюун ухааны энэхүү эрхэм зорилгыг шийдвэрлэгч нь “Эрх зүйн философи” юм.

Эрх зүйг тогтоогдсон хэм хэмжээний хүрээнд позитив эрхийн нэгэн адил ойлгож болох боловч Оросын эрдэмтэн В.С.Нерсесянцын хэлсэнчлэн: позитив эрхийн тухай энгийнээр эргэцүүлэхэд хариулт нь позитив эрхийн хүрээнээс хальсан олон асуулт гарч ирдэг. Тухайлбал, Ер нь эрх зүй гэж юу вэ? Түүний утга учир, мөн чанар, онцлог хийгээд түүний онцгойлох шинжүүд юу вэ? Эрх зүйн болон нийгмийн бусад хэм хэмжээний харьцаа ямар вэ? Чухам яагаад зөвхөн эрх зүйн хэм хэмжээнд л албадлага хэрэглэх боломж бүрддэг вэ? Эрх зүйн үнэ цэнийг юугаар хэмжих вэ? Эрх зүй л шударга уу? Шударга бол тэр нь юугаар илрэх вэ? Хууль л бол эрх зүйд тооцогдох уу? Эрх зүйд харш хууль тогтоох үйл ажиллагаа байж болох уу? Эрх зүйн ноёрхол тогтоох ямар арга зам байна вэ? гэсэн позитивизмын хүрээнээс хальсан олон асуулт гарч ирдэг. Энэхүү олон асуултын утга учрыг онолын хувьд эрх зүй ба хуулийн ялгаа, харьцааны асуудал гэж томъёолдог бөгөөд уг асуудал нь эрх зүйн философийн судлах зүйлийг бүрдүүлэгч ач холбогдолтой⁴.

“Эрх зүйн философи”-н зорилгыг Германы сонгодог философич Г.В.Гегель: “эрх зүйн бодит агуулга, түүний мөн чанарыг танин мэдэх явдал” гэж үзсэн.


2 Гегель.Философия права.М.1990.с 59- 60.

3 Нерсесянц.В.С.Философия права.М.1997.с.5.


4 Нерсесянц.В.С.Философия права.М.1997.с.8-9.



“Эрх зүйн философи” нь эрх зүй гэж юу бэ? Ямар эрх зүйг үнэн зөв, шударга гэж үзэх бэ? Гэж эрх зүйд үнэний хайгуул хийдэг “Шударга ёсны онол” учраас түүний зорилго нь эрх зүйд үнэний хайгуул хийх явдал юм.



“Эрх зүйн философи” нь мөн чанар, эрх зүйн агуулга, түүний хууль зүйн илрэлийн харилцаа хамаарал, тэдгээрт нөлөөлөх хүчин зүйлсийг нийгмийн үнэт зүйлсийн үүднээс танин мэдэх, тайлбарлах, эргэцүүлэхэд чиглэгдсэн философи-эрх зүйн мэдлэгийн салбар юм.



2. “ЭРХ ЗҮЙН ФИЛОСОФИ”-Н СУДЛАХ ЗҮЙЛ, СУДАЛГААНЫ АРГА ЗҮЙН ОНЦЛОГ

Орчин үед “Эрх зүйн философи”-н судлагдахууны асуудалд эрдэмтэн судлаачид янз бүрээр хандаж байна.

Германы сонгодог философич Г.В.Гегель: “Эрх зүйн тухай философийн шинжлэх ухааны судлах зүйл нь эрх зүйн санаа болох эрх зүйн ойлголт, түүний хэрэгжилт”⁵ гэж “Эрх зүйн философи”-н судлах зүйлийг анхлан гаргаж тавьсан. Орчин үед Оросын эрдэмтэн В.С.Нерсесянц: “Эрх зүйн санаа, түүний мөн чанар, ойлголт, түүний үндэслэл, эрх зүйн нийгэмд эзлэх байр суурь, хүн төрөлхтөн, ард түмний хувь тавилан, нийгэм, төр, хүний амьдрал дахь эрх зүйн гүйцэтгэх үүрэг, эрх зүйн үнэт зүйл, ач холбогдол”⁶ гэж “Эрх зүйн философи”-н судлах зүйлийг өргөн хүрээгээр тодорхойлсон бол Италийн эрх зүйн философич Н.Боббио “Шударга ёс бол эрх зүйн философийн үндсэн асуудал, түүний судлах зүйл”⁷ гэж явцуу утгаар авч үзжээ. Харин Югаславийн эрх зүйн онолын төлөөлөгч Р.Лукич: “Эрх зүйн философи нь тусгай /салбар/ философи учир нийгэм, бүх байгаа зүйлийг бүхэлд бус, нийгмийн нэг хэсэг болох эрх зүйг л зөвхөн судална. Гэвч эрх зүйн философи нь гүн ухаан учраас /хэдийгээр салбар философи ч гэсэн/ түүнд ерөнхий философийн бүхий л шинжүүд зүй ёсоор байдаг. Энэ нь түүний судлагдахуун нь философийн судлагдахуунтай адил гэсэн үг юм”⁸ гэснийг Оросын эрдэмтэн О.Г.Данильян хүлээн зөвшөөрч, И.Кантын арга зүйг⁹ ашиглан “Эрх зүйн философи”-н судлагдахуун нь:

1. Би эрх зүйн тухай юу мэдэж болох бэ?
2. Эрх зүйн шаардлагатай нийцүүлэн би юу хийж болох вэ? Яагаад?
3. Эрх зүйн шаардлагуудыг сахисан болон зөрчсөн тохиолдолд би юунд найдаж болох вэ? асуултуудаар илэрч болох юм¹⁰ гэжээ.

Иймд “Эрх зүйн философи”-н олон зуун жилийн хөгжлийн явц дахь судлагдахуунд үндэслэвэл, түүний судлагдахуун нь **“эрх зүйн санаа, эрх зүйн мөн чанар, агуулга, түүний илрэн гарах хэлбэр, тэдгээрийн харилцан хамаарал”** болно.

5 Гегель.Философия права.М.1990.с 59-.60.

6 Нерсесянц.В.С.Философия права.М.1997.с.7.

7 Данильян. О.Г. Философия права. М. 2005. С 10

8 Лукич Р. Методология права. М. 1981. С-69

9 Германы сонгодог философийг үндэслэгч И. Кантын гүн ухааны сэтгэлгээ нь эхэн үедээ “Би юу мэдэж болох вэ? Би юу хийж болох бэ? Би юунд найдаж болох бэ?” гэсэн 3 асуултад төвлөрч байсан юм.

10 Данильян. О.Г. Философия права. М. 2005. С 11



Эрх зүйн философийн судалгааны арга зүйн онцлог:

- Эрх зүйг танин мэдэхүйн сэтгэлгээний түвшинд судалдаг
- Эрх зүйг зонхилон агуулга талаас нь судалдаг
- Эрх зүйн үзэгдлүүдийн мөн чанар, агуулга, түүний илрэн гарах хэлбэр, тэдгээрийн харилцан хамаарлыг судлахдаа философийн категориудыг ашигладаг
- Эрх зүйн тогтолцооноос хальж судалдаг
- Эрх зүйг байх ёстой зүйлийн хүрээнд судалдаг
- Практик асуудлыг шийдвэрлэдэггүй

“Эрх зүйн философи” нь эрх зүйг судалдаг бусад судлагдахуунаас (эрх зүйн онол, эрх зүйн социологи) ялгагдах гол ялгаа нь философийн категориудын тусламжтайгаар эрхийн бодит агуулга, мөн чанар, түүний хууль зүйн илрэх хэлбэр, үндсийг судалж, гносеологи, онтологи, аксеологийн асуудлыг хөндөж, хууль зүйн шинжлэх ухааны тулгуур асуудлыг шийдвэрлэх явдал юм.

3. “ЭРХ ЗҮЙН ФИЛОСОФИ”-Н ХУУЛЬ ЗҮЙН ШИНЖЛЭХ УХААНД ЭЗЛЭХ БАЙР СУУРЬ

“Эрх зүйн философи” нь төр, эрх зүйн үзэл сургаал, онолуудыг нэгтгэсэн арга зүйн шинжтэй бие даасан судлагдахуун болохын хувьд хууль зүйн шинжлэх ухааны суурь шинжлэх ухааны нэг нь болно. Иймд “Эрх зүйн философи” нь эрх зүйг онолын түвшинд судалдаг судлагдахуунуудтай холбоо хамааралтай болно.

Эрх зүйг онолын түвшинд судалдаг хууль зүйн шинжлэх ухааны чиг хандлага, түвшин:

Эрх зүйн философи

- Эрх зүйг танин мэдэхүйн сэтгэлгээний түвшинд судалдаг

Эрх зүйн онол


- Эрх зүйг хэм хэмжээний хүрээнд судалдаг

Эрх зүйн догматик

- Эрх зүйг тогтолцооны хүрээнд судалдаг

Эрх зүйн социологи

- Эрх зүйг нийгмийн амьдралд хэрэгжиж буй байдлаар нь судалдаг



Эрх зүйн философи ба Эрх зүйн онол

	Ижил талууд	Ялгаатай талууд
1	Эрх зүйг танин мэдэхүйн сэтгэлгээний түвшинд судалдаг	Гарал үүслийн хувьд “Эрх зүйн философи” нь эртний Грекээс, “Эрх зүйн онол” нь эртний Ромоос үүсэлтэй
2	Эрх зүйг байх ёстой зүйлийн хүрээнд судалдаг	Судалгааны арга зүйн хувьд “Эрх зүйн философи” нь философийн категориудад, “Эрх зүйн онол” нь хууль зүйн шинжлэх ухааны арга зүйд голлон тулгуурлана
3	Эрх зүйг эрх зүйн тогтолцооноос хальж судалдаг	Эрх зүйн философи нь эрх зүйг агуулга талаас нь, эрх зүйн онол нь хэлбэр талаас нь голлон судалдаг

“Эрх зүйн философи” нь хууль зүйн шинжлэх ухааны:

- Хууль зүйн шинжлэх ухааны суурь салбар
- Арга зүйн шинжтэй судлагдахуун

“Эрх зүйн философи”-н ач холбогдол, үүрэг:

- Танин мэдэхүйн үүрэгтэй
- Арга зүйн үүрэгтэй
- Аксеологийн үүрэгтэй
- Эрх зүйн сэтгэлгээг хөгжүүлэх үүрэгтэй

“Эрх зүйн философи” нь философийн категориудын тусламжтайгаар эрх зүйн бодит агуулга, мөн чанар, түүний хууль зүйн илрэх хэлбэр, үндсийг танин мэдэхүйн сэтгэлгээний түвшинд судалж, гносеологи, онтологи, аксеологийн асуудлыг хөндөж, хууль зүйн шинжлэх ухааны тулгуур асуудлыг шийдвэрлэх явдал юм.

Хяналтын асуулт:

1. Эрх зүйн философи гэж юу вэ?
2. Эрх зүйн философийн зорилго нь юу вэ?
3. Эрх зүйн философийн судлах зүйл, түүний онцлог нь юу вэ?
4. Эрх зүйн философи нь эрх зүйг судалдаг хууль зүйн шинжлэх ухааны онолын судлагдахуунуудаас судлах зүйл, судалгааны аргаараа ямар ялгаатай вэ?
5. Эрх зүйн философийг судлахын ач холбогдол нь юу вэ?

Ном зүй:

1. Kaufmann.A. Rechtsphilosophie.1997.
2. The Philosophy of law (Oxford Readings in Philosophy) by Ronald M. Dworkin (Jan 6, 1977)
3. В.С. Нерсесянц. Философия права. М. 1997.
4. Данильян. О.Г. Философия права. М. 2005
5. Лүндээжанцан. Д. Жалбажав. Н. Отгонтуяа. Д. Эрх зүйн философи. УБ. 1998
6. Jules Coleman and Scott Shapiro. Jurisprudence and Philosophy of Law. Oxford. 2002.
7. “Эрэгцүүлэл” сэтгүүл. УБ. 2000 он. 12 сарын дугаар.
8. Х. Сэлэнгэ. Эрх зүйн философийн талаар хэдэн үг. "Эрх зүй " сэтгүүл, УБ, 2001, 4-5



Эрх зүйн онтологийн асуудал

II бүлэг

Эрх зүйн мөн чанар

Зорилго: Эрх зүйн уг сурвалж, эрх зүйн мөн чанар, агуулга, зорилгын гүн ухааны үндсийг илрүүлж, эрх зүйг философи- эрх зүйн үүднээс ойлгож танин мэдэх

1. ЭРХ ЗҮЙН УГ СУРВАЛЖ

Эрх зүйн мөн чанарын тухай асуудал нь нийгмийн үзэгдэл болох эрх зүйн дотоод талд хамаарагдах асуудал тул түүний уг сурвалжийг авч үзэхгүйгээр эрх зүйн мөн чанарыг тодорхойлох боломжгүй юм.

Эрх зүйн онолын чиг хандлагууд нь эрх зүйн уг сурвалжийг янз бүрээр авч үздэг.

Эрх зүйн позитив чиг хандлага	Эрх зүйн социологийн чиг хандлага	Эрх зүйн шашны чиг хандлага
• Тор	• Нийгэм	• Эзэн тэнгэр

Орчин үед хууль зүйн шинжлэх ухааны хөгжингүй эрх зүй судлалын үүднээс эрх зүйн гүн ухааны үндсийг илрүүлэн, эрх зүйг бодгаль хүнээс үүсмэл хэмээн үзэх болсон байна.




Нийгэм, төр гэдэг бол бүтээгдсэн эрх зүйн амьдрах орчин болохоос эрх зүйн уг сурвалж нь биш юм. Иймд хүний мөн чанарыг танин мэдэхгүйгээр эрх зүйн мөн чанарыг танин мэдэх боломжгүй.

Украины Хууль Зүйн хүрээлэнгийн эрдэмтэн док. Л.В.Петрова: “Хөгжингүй эрх зүй судлалын үүднээс эрх зүйн мөн чанарын асуудал нь философийн асуудал болохоос, цэвэр хууль зүйн асуудал биш”, Оросын “Эрх зүйн философи”-н төлөөлөгч Г.Ф.Шершеневич: “Эрх зүй нь бүхэлдээ социологийн ойлголт болохоос, хууль зүйн ойлголт биш. Хэрвээ эрх зүй нь хүн төрөлхтний бүтээл мөн бол түүний мөн чанарыг хүний мөн чанарыг танин мэдэхгүйгээр танин мэдэх боломжгүй. Иймд эрх зүйн онол нь антропологоос буюу хүн судлалаас эхлэх ёстой” гэжээ.

2. ХҮН БА БАЙГАЛИЙН ХУУЛЬ


Хууль зүйн шинжлэх ухаан нь хүн судлалаас эхлэх ёстой бөгөөд хүний мөн чанарыг танин мэдэхгүйгээр эрх зүйн мөн чанарыг танин мэдэх боломжгүй юм. Хүний амь нас, эрүүл мэнд, өмч хөрөнгийг хохироож болохгүй гэсэн эрх зүйн зарчим, хэм хэмжээ нь зөвхөн хуулийн зүйл заалтад тусгагдсанаар бүрэн хэрэгждэггүй бөгөөд энэ нь аливаа хуулиас илүүтэй хүний хүсэл зоригоос шалтгаалж байдаг билээ. Иймд нэрт сэтгэгч Сократ “Хэрвээ хүн ертөнцийг танин мэдье гэвэл юуны өмнө өөрийгөө танин мэдэх ёстой” гэж хэлсэн байна.

Хүн гэж хэн бэ? гэсэн асуултад эрдэмтэн судлаачид, онолын чиг хандлагууд янз бүрийн хариултуудыг өгдөг боловч юуны өмнө хүн бол байгалийн амьтан болохыг хүлээн зөвшөөрдөг юм.



Хүн байгалийн амьтан болохын хувьд юуны өмнө байгалийн хуульд захирагдаж байдаг байна.

Байгалийн дээд хуулийг сэтгэгч Бенедикт Спиноза нь “аливаа амьд амьтан ахуйд өөрийгөө хадгалах хууль” гэж үзжээ.



Байгалийн дээд хуульд үндэслэн аливаа хүн төрөлхөөсөө аминч шинжийг агуулж байдаг юм.



Аминч шинж гэж юу вэ?

Хүний аминч шинжийг амин хувиа хичээх, хувийн ашиг сонирхлыг дээдлэх гэх мэт явцуу утгаар ойлгож болохгүй. Хүний аминч шинжийг өргөн утгаар ойлговол хүний ахуйд өөрийгөө хадгалах хүсэл эрмэлзлэл буюу амьдрах хүсэл эрмэдлэл болно. Иймд хүний зан үйлийг өөрийгөө хамгаалах, амьд явах, ахуйд хадгалах хүсэл эрмэлзлэл жолоодож байдаг.



Хүний ахуйд өөрийгөө хадгалах хүсэл эрмэлзлэл нь хүч чадал, хүсэл зориггүйгээр хэрэгжих боломжгүй. Иймд хүн бүр байгалиас заяасан хүч чадалтай байхын зэрэгцээ хүний зан үйлийг өөртөө ашиг гаргах, өөрийгөө хамгаалан ахуйд хадгалах хүсэл эрмэлзлэл жолоодож байдаг байна. Хүний аминч шинж нь хүсэл зоригоор илрэн гардаг тул хүн хүсэл зоригтой субъект болно.



3. ХҮСЭЛ ЗОРИГ БА АШИГ СОНИРХОЛ


Германы сонгодог философийг үндэслэгч И.Кант: “Хүний хүсэл зориг нь эерэг, сөрөг гэсэн хоёрдмол шинжийг агуулж байдаг. Хүсэл зоригийн эерэг тал нь ёс суртахуунд захирагдаж байдаг бол, сөрөг тал нь дур зоргод захирагддаг” гэжээ.

Хүсэл зоригийн сөрөг шинж нь хувийн ашиг сонирхлыг дээдлэх, амин хувиа хичээх гэсэн аминч үзлээр илэрдэг. Гэвч объектив бодит байдалд нийтийн ашиг сонирхлыг дээдлэхгүйгээр хүн өөрийгөө ахуйд хадгалах боломжгүй юм. Ийнхүү хүний объектив, субъектив байдал нь хоорондоо зөрчилдөж байдаг байна.

Хүний хүсэл зориг нь гадаад ертөнцөд буюу нийгмийн харилцаанд ашиг сонирхлоор илэрдэг.

Ашиг сонирхол нь хүний үйлдэл, объектив зүй тогтлын хоорондын харилцаа холбоогоор илэрдэг нийгэм, хууль зүйн үндсэн категори юм. Ашиг сонирхол нь субъектын үйл ажиллагааг чиглүүлж, хүний зан үйл, үйлдлийн шалтгааныг тодорхойлдог байна.

Хүн нийгэмд амьдардаг тул тодорхой субъектүүдийн материаллаг болон материаллаг бус хэрэгцээг илэрхийлэх хувийн ашиг сонирхлоос гадна бусдын ашиг сонирхлыг хүлээн зөвшөөрөх, нийтлэг ашиг сонирхлыг илэрхийлэх нийтийн ашиг сонирхол гэж байна.



Хувийн болон нийтийн ашиг сонирхол нь субъектив, объектив байдлын улмаас хоорондоо зөрчилдөх боловч нэгж, ерөнхийн категориор салшгүй холбоотой юм.

Хүн хувийн ашиг сонирхлын үүднээс өөрийн ашиг сонирхол, эрхийг дээдлэх субъектив шинжийг агуулах боловч нийгэмд амьдарч, нийгмийн харилцаанд оролцож, ахуйд өөрийгөө хадгалах хүсэл эрмэлзлэлийн үүднээс объектив бодит байдалд нийтийн ашиг сонирхлыг хүлээн зөвшөөрөх шаардлага зүй ёсоор тавигддаг. Иймд хүн өөрийн хүсэл зориг, нийтийн болон хувийн ашиг сонирхолыг зохистой байлгах нөхцөл нь бусадтай зохицох буюу бусдын эрхийг хүлээн зөвшөөрч, хүний эрхийг хүндэтгэх явдал юм. Өөрөөр хэлбэл, хувийн ашиг сонирхлыг хангах үүднээс бусдын эрх, ашиг сонирхлыг хүлээн зөвшөөрөх ёстой байна.



4. АШИГ СОНИРХОЛ БА ХҮНИЙ ЭРХ

Хүн хүсэл зориг, ашиг сонирхолтой байхаас гадна оюун ухаантай амьтан. Мөн хүн практик оюун ухаантай болохын хувьд сэтгэх чадвартай, үйлдэх чадвартай субъект юм.


Хүн оюун ухаантай, үйлдлийнхээ үр дагаврыг ухамсарлах чөлөөт хүсэл зоригтой субъект тул өөрийн эрх ашиг, сонирхолыг хангах нөхцөл, боломжийг ухамсарлан ойлгох ёстой. Гэвч хүн бүр өөрийн үйлдэл, түүний үр дагаврыг ухамсарлан ойлгож чаддаггүй бөгөөд энэ нь хүний зан суртахууны төлөвшил, хүмүүжил, нийгмийн аливаа асуудалд хандах хандлага, бие даах чадвар, нийгэмшлээс илүүтэй хамаарч байдаг юм. Иймд зарим хүн өөрийн болон бусдын эрх зөрчигдөхөөс хамгаалж, өөрийн үйлдлийн хэмжээ, хязгаарыг ухамсарлаж байдаг. Харин зарим хүн өөрийн үйлдлийн хэмжээ, хязгаарыг ухамсарлан ойлгож чаддаггүй бөгөөд дур зорго, хүч чадлаар аливаа асуудлыг шийдвэрлэх гэж оролддог бөгөөд үүний үр дүнд өөрийнхөө эрхийг хязгаарлаж байдаг юм.

Аливаа хүн бүр байгалийн хууль, хүний мөн чанарын үүднээс амьд явах, эрх, эрх чөлөөтэй байх, тэгш эрхийг эдлэх, өмч хөрөнгийг эзэмших гэх мэт жам ёсны халдашгүй дархан эрхтэй. Энэхүү эрхийг хэрэгжүүлэх, өөрийн оршихуйг бүрдүүлэх нөхцөл нь бусдын эрх, эрх чөлөөг хүлээн зөвшөөрч, бусадтай зохицох явдал болно. Өөрөөр хэлбэл, хүн ахуйд өөрийгөө хадгалах үүднээс нийтийн болон хувийн ашиг сонирхлын зохицлыг хангаж, бусдын эрх, эрх чөлөөг хүлээн зөвшөөрөх явдал юм.

5. ХҮНИЙ ЭРХ БА ЭРХ ЗҮЙ

Хүн оюун ухаантай, сэтгэх чадвартай субъект учир хувийн болон нийтийн ашиг сонирхлын зохицлыг хангаж, өөрийнхөө үйлдлийн хүрээ хязгаарыг танин мэдэх, ухамсарлах ёстой. Германы сонгодог философич Г.В.Гегель “Хүн эрх чөлөөтэй байна гэдэг нь хүн өөрийн үйлдлийн хүрээ хязгаар, зайлшгүй шинжийг ухамсарлах явдал” гэжээ. Гэвч хүний эрхийг хүлээн зөвшөөрч, бусадтай зохицох явдал нь тухайн хүний нийгэмшлээс шалтгаалдаг. Өөрөөр хэлбэл, нийгэмд хүн иргэншин төлөвшиж, нийтээр хүлээн зөвшөөрсөн хэм хэмжээг дагаж мөрдөх чөлөөт хүсэл зоригтой байна уу, эсвэл байгалийн шинжээрээ аливаа асуудалд дур зорго, хүч чадлаараа хандаж байна уу гэдгээсээ шалтгаалж байдаг байна. Ийнхүү нийгэмшлээс шалтгаалан хүний зан үйл янз бүр байдаг байна. Иймд нийгмийн хөгжлийн явцад хүний зан үйлийг зохицуулах нийгмийн хэм хэмжээнүүд болох зан заншлын, шашны, ёс суртахууны, эрх зүйн хэм хэмжээнүүд бүрэлдэн бий болсон юм.

Хүний нийгэмшлийн үр дүнд эрх зүй бий болж, эрх зүйн хэм хэмжээ улам боловсронгуй болж байна.



Иймд эрх зүйн мөн чанарыг хүнээс гадуур, нийгэм, төр, ангиас эрвэл, жинхэнэ мөн чанарыг танин мэдэх боломжгүй.

Нийгэм, төр - бүтээгдсэн эрх зүйн амьдрах орчин.

Хяналтын асуулт:

1. Хөгжингүй эрх зүй судлалын үүднээс эрх зүйн уг сурвалжийг хэрхэн үздэг вэ?
2. Байгалийн дээд хууль, түүний шинжийг тодорхойлно уу?
3. Аминч шинж, түүний илрэн гарах хэлбэрийг тодорхойлно уу?
4. Хүний хүсэл зориг, түүний хөгжлийн үе шатыг Германы сэтгэгч Гегель хэрхэн үзсэн бэ?
5. Хүсэл зориг, сэтгэхүйг нэгдмэлээр авч үзэж болох уу? Яагаад?
6. Хүсэл зоригийн илрэн гарах хэлбэр юу вэ?
7. Нийтийн болон хувийн ашиг сонирхол, тэдгээрийн харилцан хамааралыг тодорхойлно уу?
8. Ямар нөхцөлд нийтийн болон хувийн ашиг сонирхлын зохицлыг хангах вэ?
9. Хүний эрх, эрх чөлөөг хэрэгжүүлэх нийгмийн үндсэн арга юу вэ?

Ном зүй:

1. Бердяев.Н.А.Философия свободы.Истоки и смысл русского коммунизма.М., 1997.
2. Гегель.Г.В.Философия права.М., 1990.
3. Геллнер.Э.Условия свободы.Гражданское общество и его исторические соперники.М., 1995.
4. Кант.И.В метафизике в нравов.Соч.Т-6.М., 1994.
5. Ницше.Ф.Воля к власти.М., 1994.
6. Шершеневич.Г.Ф.Общая теория права.т-1, 2.М., 1995.
7. Х. Сэлэнгэ. Хүн ба эрх зүй. “Эрх зүй” сэтгүүл. УБ, 2000, '2-3



III бүлэг

Эрх зүйн онтологи

Зорилго: Эрх зүйн ахуйн ойлголт, шинж, онцлог, түүний илрэх хэлбэрүүдийг танин мэдэх


1. ЭРХ ЗҮЙН АХУЙН /ОНТОЛОГИ / МӨН ЧАНАР, БОДИТ БАЙДЛЫН ФИЛОСОФИ

Эрх зүйн ахуйн /эрх зүйн онтологи / тухай асуудлыг авч үзэхийн өмнө ахуйн /онтологи/ ойлголтыг танин мэдэх хэрэгтэй.

Ахуй /онтологи/ гэдэг нь хууль зүйн ойлголт биш, философийн ойлголт юм. Хүн байгаль, нийгмийн үзэгдлүүдийн үүсэл, мөхлийг ажиглах явцад орших, эс оршихуйн асуудал, бодит ахуйн тухай асуудал байнга үүсч байсны үр дүнд философийн ахуйн /онтологи/ тухай сургаал бий болжээ.

Ахуйд өргөн утгаараа байгаа зүйлийн тухай, оршихуйн тухай ерөнхий ойлголт хамаарагдаж байдаг.

Ахуй /онтологи/ гэдэг нь “бодит байдал” гэсэн ойлголттой ойролцоо утгатай бүхнийг хамарсан ойлголт юм. Ахуй бол байгаа бүх юм¹¹



“Эрх зүйн философи”-н үндсэн нэг асуудал нь хамгийн түгээмэл хуулийн ахуй нь нийгмийн хуультай, ялангуяа, эрх зүйн хуулиудтай ямар холбоотой вэ? Хамгийн түгээмэл хууль нь хүмүүсийн нийгмийн ахуйд зохицуулах үр нөлөөг ямар замаар, хэрхэн үзүүлэх вэ? гэсэн асуудал болно.

Энэхүү философи эрхийн асуудал нь эрх зүй нь нийгмийн хүрээнээс ангид биш болохыг тодорхойлж байна. Нөгөө талаар эрх зүйн бодит орон зай болох хүмүүсийн соёлтой оршихуйн бүх орон зайг хамаардаг.

¹¹ Данильян. О.Г. Философия права. М. 2005. С 212

Иймд эрх зүйн бодит байдлын ойлголт, агуулга, утга санаа, эрх зүйн ахуйн мөн чанар, эрх зүйн ахуйн үндсэн хэлбэрийг танин мэдэхгүйгээр эрх зүйн феномен \ухамсрын үзэгдэл\ийг бүхэлд нь ойлгох боломжгүй.

Эрх зүйн онтологи асуудал нь практикийн болон онолын хуульчдаас хамаагүй хол хөндий асуудал шиг санагдаж болох боловч “Эрх зүй гэж юу вэ?” гэсэн үндсэн суурь асуулт тодорхой хэрэг маргааныг шийдвэрлэх нөхцөл бүрд тавигдаж байдгийг санах хэрэгтэй. Энэхүү асуулт нь түүний “үл шийдвэрлэгдэх”, “мөнхийн” болохыг гэрчилж байгаа тул философийн шинжтэй юм. Үүнтэй холбогдуулан Германы сонгодог философийг үндэслэгч И.Кант: “Хуульчид одоог хүртэл эрх зүйн өөрийнх нь ойлголтыг эрж хайсаар байна”, Гюстава Флюбер: “Эрх зүй. Энэ юу болох нь тодорхойгүй” гэжээ. Иймд эрх зүй нь өнөөдөр бидний өмнө танин мэдэгдээгүй, өвөрмөц объект юм.

“Эрх зүй гэж юу вэ?”, “Эрх зүй хаана оршдог вэ?”, “Тадаад ертөнцөд үү? Эсвэл хүн төрөлхтний туршлагад уу?” өөрөөр хэлбэл “Эрх зүй бодит байдалаар ямар хэв маягаар оршдог вэ?” гэсэн асуултууд тавигдсаар ирсэн ба эдгээр асуултууд нь эрх зүйн онтологийн судлагдахуун юм.

Эрх зүй нь бодит байдалд ямар хэлбэртэй вэ? гэсэн асуулт нь хүнд хэцүү асуулт биш юм. Учир нь хүн төрөлхтөн нийгэмшиж ирсэн цаг үеэс өнөөг хүртэл эрх зүй нь бодитой оршиж, судлагдаж ирсэн. Иймд Оросын философич хуульч Евгений Спекторскийн хэлсэнчлэн: “Хуульчид өөрсдөө ямар бодит байдалтай ажиллаж байгаагаа тэд мэддэг. Тэр тухай маргадаггүй. Хэрвээ тэд энэ талаар маргадаг, маргаантай байдаг бол хүндхэн асуудлын нэг болох танин мэдэхүйн онолыг шийдвэрлэх ёстой болно”¹².

Германы “Эрх зүйн философи”-н гол төлөөлөгч А.Кауфман эрх зүйн онтологийн асуудлыг: Эрх зүй нь ямар замаар ахуйтай холбогдох вэ? Өөрийн онтолог бүтцээрээ эрх зүй гэж юу вэ? Түүний мөн чанар юу вэ? гэдгийг эрх зүйн ахуйн /онтологийн / хүрээнд авч үзэх ёстой¹³ гэжээ.

2. ЭРХ ЗҮЙН АХУЙН ШИНЖ, ТҮҮНИЙ ТАЛААРХ ҮЗЭЛ БАРИМТЛАЛ

Аливаа хүн хүрээлэн буй орчинг баримжаалахдаа тухайн орчны бодит байдлыг мэдэрдэг. Энэ мэдрэмж нь тухайн орчныг онолын үүднээс тодорхойлох болон практик туршлагаар дамжин мэдрэгдэх бөгөөд энэ нь юу хийх хэрэгтэй, тухайн объекттой юу болоод байгааг ойлгох, ухамсарлахад тусладаг. Эрх зүйн бодит байдлын хэлбэрийг тогтоох, нийгмийн харилцааны явцад эрх зүй нь хэрхэн оршин

¹² Данильян. О.Г. Философия права. М. 2005. С 213

¹³ Максимов С. Онтологическая природа права. Проблемы законности. Вип.48.С-186




байдаг тухай асуудал нь ХХ зууны эхэн үеэс “Эрх зүйн философи”-н нэг чухал судлагдахуун болжээ.

Эрх зүйн бодит байдал нь өргөн утгаар эрх зүйн үзэл баримтлал, эрх зүйн харилцаа, институтууд, эрх зүйн хэм хэмжээ гэх мэт эрх зүйн үзэгдлүүдийн нийлбэр цогц юм.

Хууль зүйн шинжлэх ухаанд эрх зүйн плюрализм хөгжиж байгаа орчин үед “эрх зүй гэж юу вэ? хаана оршдог вэ?” гэсэн эрх зүйн ахуйн буюу эрх зүйн бодит байдлын тухай асуултуудад онолын чиг хандлагууд нь өөр өөрийн арга зүй, онолын үүднээс янз бүрийн үзэл баримтлалтай байна. Тухайлбал,

1. Позитив үзэл баримтлалтай нийцдэг догматик хууль зүйн шинжлэх ухааны аналитик арга зүй нь эрх зүйг төрийн захирамжлах үзэгдэл
2. Социологийн арга зүй нь эрх зүйг нийгмийн харилцааны хэлбэр
3. Психологийн арга зүй нь- психологийн ойлголт
4. Норматив арга зүй нь- эрх зүйн аксеологи ойлголт

Эрх зүйн бодит байдлын талаар эрх зүйн онолын янз бүрийн үзэл баримтлал байгаа ч, орчин үед эрх зүйн бодит байдлыг “эрх зүйн ухамсарт оршин төсөөлөгдөж буй эрх зүйн дүр төрхийг гаргах” гэж үзэж байна.



3. ЭРХ ЗҮЙН АХУЙН ИЛРЭХ ХЭЛБЭРҮҮД

Эрх зүйн ахуйн илрэх хэлбэр нь эрх зүйн танин мэдэхүйн үр дүн юм. Хүний нийгэмшил, эрх зүйн сэтгэлгээний хөгжлийн явцад бодит ахуйд эрх зүй нь үнэт зүйл, онол сургаал, хэм хэмжээ, хууль зүйн туршлагаар илрэн гарч, улам боловсронгуй болж хөгжиж ирсэн билээ.

Эрх зүйн бодит байдлын үзэл баримтлал нь эрх зүйн ухамсарт оршин төсөөлөгдөж буй эрх зүйн дүр төрхийг гаргаж тавихад чиглэгдэж байгаа бөгөөд энэ нь хоорондоо харилцан хамааралтай дараах нөхцөлд бүрэлдэн тогтдог. Үүнд:

- Онолын янз бүрийн түвшинд ялангуяа философи, эрх зүйн үзэл суртлын үед (үүнд Үндсэн хуулийг хамааруулаад)
- Норматив актад
- Ердийн туршлагаар (эрх зүйн амьдралын явцад, тухайлбал эрх зүйн зөрчил, хүний эрхийг хамгаалах практик, гэрээ хэлцэл г.м)

Ийнхүү эрх зүй нь субъектын эрх зүйн танин мэдэхүйн хүрээнд бүрэлдэн тогтож, нийгмийн амьдралд хэрэгжиж байдаг юм.



Хүн оюун ухаантай, эрх чөлөөтэй амьтан боловч мөн хуульд захирагдмал субъект.

Хяналтын асуулт:

1. Эрх зүйн ахуй гэж юу вэ?
2. Эрх зүйн ахуйн талаар онолын чиг хандлагууд ямар үзэл санааг баримталдаг вэ? Яагаад?
3. Орчин үед эрх зүйн ахуйн ямар үзэл хандлага хөгжиж байна вэ?
4. Эрх зүй нь бодит байдалд ямар хэлбэрээр илэрдэг вэ?
5. Эрх зүй нь байгалийн үзэгдэл үү, эсвэл нийгмийн үзэгдэл үү?

Ном зүй:

1. Данильян. О.Г. Философия права. М. 2005.
2. Kaufmann.A. Rechtsphilosophie.1997.
3. Кант.И.В метафизике в нравов.Соч.Т-6.М., 1994.
4. Тихонравов.Ю.В.Основы философии права.М., 1997.
5. Нерсесянц.В.С.Философия права.М., 1997



IV бүлэг

Эрх зүйн аксеологи

Зорилго: Эрх зүйн үнэт зүйл, тэдгээрийн агуулга, философи үндсийг илрүүлэн, улмаар орчин үеийн эрх зүйн үнэт зүйлийн онол- арга зүйн чиг хандлагыг танин мэдэх

1. ҮНЭТ ЗҮЙЛ БА ЭРХ ЗҮЙ

Хүн төрөлхтний эрх зүйн сэтгэлгээний хөгжлийн явцад эрх зүйн үнэт зүйлийн сэтгэлгээ, онол хөгжсөн юм.

Эрх зүй яагаад үнэт зүйлтэй холбогдож байна вэ?

Юуны өмнө үнэт зүйлийн арга зүйг хэрэглэхгүйгээр эрх зүйн мөн чанар, агуулга, зорилгыг бүрэн тодорхойлох боломжгүй юм. Нөгөө талаар эрх зүйн хэм хэмжээ үнэлэмжийн объект бөгөөд үнэт зүйлийг агуулснаар эрх зүйн шинжтэй болдог. Иймд эрх зүй- эрх зүйн үнэт зүйлийн тодорхой хэлбэр бөгөөд эрх зүйн хэм хэмжээ нь үнэт зүйлийн ач холбогдолтой юм.

Эрх зүйн үнэт зүйлийг тодорхойлж хэлэх нь амар байж болох ч тэдгээрийг үндэслэх нь тийм ч амар зүйл биш. Ялангуяа, үнэт зүйл өөрчлөгдөн шинэчлэгдэх хандлагатай болж байгаа үед энэхүү асуудал нэлээд хөндөгдөж байдаг. Үнэт зүйлийн чөлөөт сонголт хийхийн тулд тэдгээрийн үндэслэлийг тодорхойлох шаардлагатай.

Үнэт зүйлийг үндэслэх нь нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчмуудтай холбоотой юм. Нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчмууд нь нийгмийн хүрээнд хүлээн зөвшөөрсөн нийгэм - соёлын бодитой үндэс суурьтайгаас гадна нийгмийн харилцааны болон амьдралын хэв маягийг тогтворжуулан хөгжүүлдэг.


Нийтээр хүлээн зөвшөөрсөн үнэт зүйлийн шалгуур хэрхэн бий болов?

Нийгмийн харилцааны явцад тодорхой субъектүүд хоорондоо амьдралынхаа чиг баримжааны тухай санал зөрөлдсөн, эсвэл ямар нэгэн шийдвэр гаргах нөхцөлд юуны түрүүнд нийгмийн нийтлэг чиг баримжаа, оршихуйн үндсийг тодорхойлж, мөн бодит амьдралд нийцэж байхаар тийм нийтээр хүлээн зөвшөөрсөн үнэт зүйлийг тодорхойлон гаргадаг байна. Иймд хүн ямар нэгэн үйлдэл хийх юм уу, эсвэл шийдвэр гаргах үед нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчим, нөхцөлүүдэд нийцүүлэх шаардлага зайлшгүй гардаг. Хэрвээ нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчим, үнэт зүйлийг баримтлахгүй бол тодорхой бие хүний болон нийгмийн ашиг сонирхлыг шууд хөндөж, өөрсдийхөөрөө амьдрах оршихуйд сөрөг нөлөө үзүүлдэг байна. Иймд үнэт зүйл нь эрх зүйтэй салшгүй холбоотой юм.

Эрх зүйн үнэт зүйлийг онолын олон урсгал, чиг хандлагууд өөр өөрийг арга зүй, онолын үүднээс янз бүрээр авч үздэг. Тухайлбал, позитив эрх зүйн философи

нь зөвхөн хуулийн үнэт зүйлийн асуудлыг авч үздэг бол реалист онол нь эрх зүйг хэрэглэх үйл ажиллагааны хэлбэр, хууль зүйн техник хэр хөгжсөнөөс эрх зүйн үнэт зүйл шалтгаална гэж үздэг.

Гэхдээ орчин үеийн эрх зүйн үнэт зүйлийн үзэл баримтлал нь эрх зүйн үнэт зүйлийг зөрчлийг шийдвэрлэх арга хэрэгсэл (инструмент) гэж үзэх болсон.



Эрх зүйн үнэт зүйл нь гадаад ахуйд дараах үндсэн хэлбэрээр илэрдэг. Үүнд:

- Нийгмийн зорилгот үнэт зүйл- эрх зүйн ухамсрын үр дүнд бий болох бөгөөд янз бүрийн нийгмийн хүрээнд эрх чөлөө, тэгш байдал, шударга ёсны үзэл санааны хэлбэрээр илрэнэ
- Бодитой биелсэн үнэт зүйл- Үндсэн хууль, хууль, норматив актад бэхжиж, эрх зүйн хэм хэмжээний зарчим болдог
- Бие хүний буюу экстенциал үнэт зүйл- бие хүний болон бусдын эрх чөлөө, ашиг сонирхол

Эрх зүйн үнэт зүйл гэдэг нь хүний оршихуйн үндэс, объектив ахуйн шаардлагын илрэлийг хүн төрөлхтний оюун ухаанаар үнэлсэн үнэлэмжийн нийлбэр цогц юм.

Үнэт зүйлсийг шүүмжлэх дээд шалгуур бол бодит байдал болон ухаалаг зохистой шийдвэрийг шаардах явдал юм. Эрх зүйн талаас нь ойлговол өөрийгөө танин мэдэх боломж бүхий эрх зүйн ухамсар нь эрх зүйн үнэт зүйлийн үндэслэл болдог. Иймд эрх зүйн үнэт зүйлийг бие хүний ойлголтоос үүдэлтэй хэмээн үздэг бөгөөд эрх зүйн үнэт зүйлийн шалгуур нь өөрөө хөгжих бие хүн юм.

Эрх зүйн үнэт зүйлийн онцлог нь:


- Бие хүний ойлголтоос үүдэлтэй байдаг.
- Эрх зүйн үнэт зүйлийн шалгуур нь өөрөө хөгжих бие хүн юм.



- Эмпирик үндэслэлд үл суурилагддаг буюу эмпирик үндэслэл шалгуургүй болно.
- Бие даасан шинжтэй
- Нийгмийн харилцааг зохицуулахад социал бүлэглэлийн хэрэгцээг хангах оюуны үнэт зүйлийн нэг юм.
- Эрх зүйн үнэт зүйлийн үндсэн болон тусгай үүрэг нь зохицуулах үүрэг бүхий шинжтэй
- Эрх зүйн үнэт зүйл нь нийгмийн хэвийн үйл ажиллагаа, ёс журам, зарчмыг бүтээж бататгах, хамгаалахад чиглэгддэг
- Эрх зүйн үнэт зүйл нь нийгмийн социал удирдлагын системн элемент мөн
- Эрх зүйн үнэт зүйл нь деонточески буюу байх ёстой зүйлийн хүрээнд судлагддаг
- Төрөөс хамгаалагдаж, хуульчилагдан баталгааждаг

Эрх зүйн сэтгэлгээний хөгжлийн явцад эртнээс өнөөг хүртэл эрх зүйн санаа, эрх зүйн хэм хэмжээ, бодгалийн эрх зүйн ухамсрын аль ч түвшинд эрх зүйн үнэт зүйл нь дараах үндсэн зарчмууд болохыг хүлээн зөвшөөрч байна. Үүнд:

- Эрх чөлөө
- Тэгш байдал
- Шударга ёсны зарчим болно.



Эрх зүйн хэм хэмжээ нь эрх чөлөө, тэгш байдал, шударга ёсны зарчмуудын илрэл учраас үнэт зүйлийн ач холбогдолтой бөгөөд үнэлэмжийн объект юм.

2. ЭРХ ЧӨЛӨӨ БА ТЭГШ БАЙДАЛ

Аливаа хүнд хамгийн анхдагч үндсэн шаардагдах зүйл бол эрх чөлөөний шаардлага байдаг. Гэхдээ энэ нь тодорхой үнэт зүйлийг сонгоогүй нөхцөлд ч байж болдог. Үүнийг үнэлэхүй (абсолютный) үнэт зүйл гэж үздэг.

Эрх чөлөө нь бие хүнийг тодорхойлох, оршихуйн үндэс бөгөөд хүний аливаа эрхийн үндэс юм. Хүний эрхийн талаар амьд явах эрхтэй, өмч эзэмших эрхтэй, эрүүл аюулгүй орчинд амьдрах эрхтэй гэх мэтчилэн ярьж, тунхаглан бичиж болох боловч эдгээр хүний эрхүүд нь эрх чөлөөгүйгээр хэрэгжих боломжгүй. Өнгөрсөн түүх рүү эргэн харвал, боолын нийгмийн үед боол ямар ч эрх чөлөөг эдэлдэггүй байсан учраас хүн биш, ярьдаг адгуус хэмээн нэрлэгдэж, эд юмсын нэгэн адил эрх зүйн харилцааны субъект бус, объект хэмээн тооцогдож ирсэн. Иймд эртнээс өнөөг хүртэл нэрт сэтгэгчид хүний эрхийн үндсийг “эрх чөлөө” хэмээн хүлээн зөвшөөрч ирсэн билээ. Өөрөөр хэлбэл эрх чөлөө нь хүний оршихуйн үндэс, объектив ахуйн шаардлагын илрэл, эрх зүйн үнэт зүйл юм.

Эрх чөлөө гэж юу вэ?

Эрх чөлөөний тухай үзэл, санаануудаас авч үзвэл: Английн сэтгэгч Джон Локк: эрх чөлөөг “жам ёсны эрх чөлөө ба нийгэм дэх эрх чөлөө” хэмээн хоёр ангилан, “Жам ёсны эрх чөлөө гэдэг нь хүн бусдын дур зорго, эрх чөлөөнөөс хараат бус, гагцхүү байгалийн хуульд захирагдах явдал юм”, харин “Нийгэм дэх эрх чөлөө нь хүн өөрийн хүлээн зөвшөөрч итгэл хүлээлгэсэн хууль тогтоох засаглалаас өөр засаглалд үл захирагдахыг хэлнэ” гэж үзсэн бол Германы сэтгэгч Гегель: “Эрх чөлөө бол дур зорго бус. Хүн эрх чөлөөтэй байна гэдэг нь хийж байгаа зүйлийнхээ хүрээ хязгаар, зайлшгүй шинжийг ухамсарлах явдал”¹⁴ гэсэн байна. Харин Монтескье: “...эрх чөлөө гэдэг нь хүссэнийгээ хийж болно гэсэн үг биш. Эрх зүйт нийгэмд эрх чөлөө нь хүсэх ёстой зүйлийг хийх, хүсэх ёсгүй зүйлийг албадан хийлгэхгүй байлгахад оршино... Эрх чөлөө гэдэг нь хуулиар зөвшөөрөгдсөн зүйлийг хийх эрх” гэжээ. Ийнхүү сэтгэгчид эрх чөлөөг олон талаас тайлбарлаж ирсэн тул Францын соён гэгээрүүлэгч Монтескьегийн хэлсэнчлэн: “Эрх чөлөө гэдэг үгнээс өөр олон утгатай үг ертөнцөд үгүй мэт. Үзэл санааг нь үүн шиг олон талаар татсан үг өөр байдаггүй”¹⁵ аж.

14 Гегель.Г.В. *Философия права*. М.1990. стр- 44-48

15 Монтескье. *Ш. Избранные произведения*. М. 1955. стр- 288




Харин орчин үед эрх чөлөөний дараах хоёр үзэл баримтлал зонхилж байна. Үүнд:

1. Хүний боломж, сэтгэхүй танин мэдэхүйн үндэс, танигдсан зайлшгүй байдал
2. Түүхэн дэх хувь хүний өөрийн хөгжлийн амь амьсгал, пульс буюу эрх чөлөөний өөрчлөлтийн процесс

Эрх чөлөө, эрхийн ойлголтыг хэрхэн авч үзэх вэ?

Эрх, эрх чөлөөний ойлголт нь хоорондоо синоним төсөөтэй ойлголтууд боловч энэ хоёр ойлголтыг ялгаж ч авч үздэг.

Эрх чөлөө нь хүний эрхийн хэмжүүр ба хүний субъектив эрх юм.




Нөгөө талаар энэ нь эрхийг эрх чөлөөнөөс хэт ялгаж байна. Эрх чөлөө, эрх нь хоорондоо холбоотой бөгөөд “Эрх чөлөө” гэсэн нэр томьёо нь тодорхой үр дүнг заахгүйгээр бие даасан сонголт хийх өргөн боломжийг илэрхийлэх бөгөөд энэ нь эрхийг олгож буй хэрэг юм. Өөрөөр хэлбэл, эрхийг илэрхийлж байна.

Иймд Н. Бердяев эрх чөлөөний философийг гүнзгийрүүлэн: “Эрх чөлөөний тодорхойлолт нь сонголт болохын хувьд эрх чөлөөний формаль тодорхойлолт мөн...жинхэнэ эрх чөлөө нь хүн сонголт хийх ёстой үед бус, харин хүн сонголт хийсэн үед байна. Эндээс эрх чөлөөний шинэ тодорхойлолт бодит эрх чөлөөний ойлголт руу шилжиж байна. Эрх чөлөө хүний дотоод бүтээлч энерги. Хүн эрх чөлөөгөөр дамжуулан нийгмийн шинэ амьдрал, амьдралын шинэ хэлбэрийг бүтээн

хэрэгжүүлэх боломжтой”¹⁶ гэжээ. Мөн Ханс Петер Ренник: “эрх чөлөө нэг талаар бие даан шийдвэр гаргах боломж, нөгөө талаар бие даан үйл ажиллагаа явуулах болон гаргасан шийдвэрийнхээ хариуцлагыг хүлээх үүргийг агуулна” гэж үзжээ.

Энэ үндсэнд “эрх чөлөө бол өөрөө сонголт хийх, сонгосон зорилгоо мөрдөх эрх” болно.



Эрх зүйн эрх чөлөөний шинжийг тодорхойлбол:

- Өөрийгөө хязгаарлах эрх чөлөө
- Хүлээн зөвшөөрөгдсөн үйл ажиллагаа
- Бусдын эрх чөлөөг хүлээн зөвшөөрч хамтран аж төрөх чадвар
- Хүн орших нийгмийн формаль нөхцөл

¹⁶ Бердяев. Н.А. Царство духа и царство кесаря. М.1995. стр- 325



Эрх зүйн эрх чөлөөний талууд нь:

Дотоод эрх чөлөө - жам ёсны нийгмийн харилцаа /хүнийг өөрөөс нь субъектив байдлаас чөлөөлөх эрх чөлөө/


Гадаад эрх чөлөө - тогтоогдсон нийгмийн харилцаа /хязгаарлалтын хэлбэр, арга, хэлбэр- үүрэг, хариуцлага, хэм хэмжээ, хууль/

Позитив эрх чөлөө - сонголт, хариуцлага буюу хүсэл зориг, нөхцөлөөр дамжин биелэнэ.

Негатив эрх чөлөө - дур зорго буюу нөхцөл байдал, хүслээр дамжин биелэдэг.

Германы сэтгэгч Гегель: “Хэрвээ хүн бусад хүмүүстэй харилцах нийгмийн харилцаа, бусдын эрх чөлөөний санааг агуулахгүйгээр өөрийн эрх чөлөөний санааг агуулдаггүй. Мөн ямар ч хүн өөрийн эрх чөлөөний тодорхой санааг агуулахгүйгээр эрх чөлөөний харилцан холбоо хамаарал, бусдын эрх чөлөөний тодорхой санааг агуулж чадахгүй”¹⁷ гэжээ. Энэ үндсэнд аливаа хүн чөлөөт хүсэл зоригтой субъект болохын хувьд эрх, эрх чөлөөг эдлэх боловч энэхүү эрх, эрх чөлөө нь гагцхүү нийгмийн харилцааны явцад илрэн хэрэгждэг. Иймд хүний эрх чөлөө нь дур зорго бус, ухамсарласан зайлшгүй байдал болохын хувьд гагцхүү эрх зүйн хэм хэмжээгээр илрэн гарч, эрх зүйн хэм хэмжээний хүрээнд хэрэгжиж байдаг.

Дээрхээс үндэслэн эрх чөлөө нь эрх зүйн хэм хэмжээний агуулгыг тодорхойлж байдаг байна. Иймд Джон Локк “Эрх чөлөө хаана байна, тэнд хууль байна. Хууль хаана байна, тэнд эрх чөлөө байна. Хууль үгүй бол эрх чөлөө үгүй...Хуулийн зорилго нь эрх чөлөөг үгүйсгэх буюу хязгаарлахад бус, харин эрх чөлөөг хадгалах, өргөтгөхөд оршино”¹⁸ гэжээ. Ийнхүү эрх чөлөө нь эрх зүйн агуулгыг илэрхийлдэг тул эрх чөлөөг эрх зүйн үнэт зүйл хэмээн үздэг бөгөөд үнэт зүйлийн арга зүйг хэрэглэхгүйгээр эрх зүйн мөн чанар, агуулга, зорилгыг бүрэн тодорхойлох боломжгүй байна.



17 Гегель. Г.В. Энциклопедия философских наук. Т-3. М. 1997. стр- 241

18 Локк.Дж.Сочинения в трех томах. М.1988.т-3.Два трактата о правлении.стр.293

Эртний Грекийн нэрт сэтгэгч Платон хэлэхдээ: “Хууль тогтоогч хуулийг /эрх чөлөөний хэмжээ, хязгаарыг/ тогтоохдоо хүний эрхийг хооронд нь зөрчилдүүлэхгүй, адил тэгш, нарийн нягт, зөв, бүрэн дүүрэн тогтоох ёстой” гэжээ. Эртний Грекийн нэрт сэтгэгч Платоны үзэл санааг нягтлан үзвэл, эрх чөлөөний хэмжээ, хязгаар нь эрх чөлөөний тэгш байдал байх ёстой бөгөөд энэхүү эрх чөлөөний тэгш байдал нь эрх зүйн хэм хэмжээгээр илэрдэг тул эрх чөлөөний тэгш байдал бол эрх зүйн тэгш байдал гэсэн дүгнэлтийг хийж болох юм.

3. ТЭГШ БАЙДАЛ БА ШУДАРГА ЁС


Эрх чөлөөний хүрээ, хязгаар нь эрх зүйн хэм хэмжээгээр буюу хуулиар илрэхдээ хүний эрх, эрх чөлөөг хооронд нь зөрчилдүүлэлгүй адил тэгш илрэх ёстой тул эндээс хүний тэгш эрх, эрх чөлөөний тэгш байдлын ойлголт бий болж байна.

Хүн байгалиасаа харилцан адилгүй төрдөг боловч гагцхүү эрх зүй л адил бус хүмүүсийг “хүн бүр амьд явах эрхтэй, өмч эзэмших эрхтэй” гэж адил авч үздэг билээ. Иймд зөвхөн эрх зүйн хүрээнд хүний тэгш эрхийн зарчим хэрэгжиж байдаг. Эртний Ромын сэтгэгч Цицерон: “хэрвээ хүмүүс эд баялгийг тэгшитгэхийг зөвшөөрөхгүй байсан ч, харин хүн бүрд ижилхэн ухаан, авьяас заяагаагүй учраас ядаж нэг нийгэм, төрд харьяалагддаг бүх иргэд хууль зүйн адил тэгш эрхийг эдлэх учиртай” гэж формаль тэгш эрхийн зарчмыг үндэслэсэн юм. Иймд МУ-ын Үндсэн хуулийн 14-д: “Монгол улсад хууль ёсоор оршин суугаа хүн бүр хууль шүүхийн өмнө эрх тэгш байна”, “ Хүнийг үндэс, угсаа, арьсны өнгө, нас, хүйс, нийгмийн гарал, байдал, хөрөнгө чинээ, эрхэлсэн ажил, албан тушаал, шашин шүтлэг, үзэл бодол, боловсролоор нь ялгаварлан гадуурхаж үл болно” гэж хүний тэгш эрхийн зарчмыг баталгаажуулж өгсөн байна.

Тэгш эрх гэдэг бол хүн бүрт яг адил буюу эрх тэгш хандах зарчим бөгөөд хууль зүйн шинжлэх ухааны хувьд тэгш эрх гэдэг нь формаль тэгш эрхийн ойлголт болно. Иймд тэгш эрхийг хэрэгжүүлэхийн тулд тэгш байдлын зарчмыг ойлгож, хэрэгжүүлэх ёстой юм.

Тэгш байдлын зарчим гэж юу вэ?

Тэгш байдлын үзэл санааны үндсийг эртний Грекийн нэрт сэтгэгч Аристотель: “Тэгш эрх гэдэг нь адил тэгш хүмүүст адил тэгш хандах, адил тэгш бус хүмүүст адил бус хандахыг хэлнэ” гэж гаргажээ.



Грекийн нэрт сэтгэгч Аристотелийн хэлсэнчлэн адил тэгш хүмүүст адил, адил бус хүмүүст адил бус хандана гэдэг нь эрх зүйн хүрээнд гарааны тэгш боломжийг олгох явдал юм. Учир нь хүний амьдралд эрх тэгш гараа байх хэрэгтэй ч бариа нь тийм ч гол биш бөгөөд бариа нь угаасаа тэгш байх боломжгүй.

Тэгш байдлын зарчим нь хүний амжилтад хүрэхийн гол нөхцөл болдог бол тэгш эрхтэй байна гэдэг хүний амьдралын тулгуур багана юм.

4. ШУДАРГА ЁС БА ЭРХ ЗҮЙ

Хүний эрх чөлөөний тэгш байдлын зарчим нь шударга ёсны санааг бий болгодог. “Шударга ёсны онол” болох “Эрх зүйн философи”-н хөгжлийн явцад шударга ёсны тухай хөндөөгүй нэг ч сэтгэгч, онолын чиг хандлага байхгүй гэж хэлж болно.

Шударга ёс гэж юу вэ?

Шударга ёс гэдэг ойлголтыг өргөн утгаар авч үзвэл хүний амьдралын бүхий л зорилго багтана. Харин явцуу утгаар ойлговол шударга ёс гэдэг нь тэгш эрхийг хүндэтгэх явдал юм.

Шударга ёсны ойлголтын үндсийг эртний Грекийн сэтгэгч Платон: “Хүн өөрийн үйл ажиллагааг хэрэгжүүлэхдээ бусдад саад болохгүй байх явдал” гэжээ. Өөрөөр хэлбэл, хүн өөрийн эрхийг хэрэгжүүлэхдээ бусдын эрхийг хүндэтгэх явдал юм.

Дээрх шударга ёсны агуулга нь ёс зүйн үүргийг илүүтэй илэрхийлж байна. Иймд О.Хёффе: “Шударга ёс нь мөн чанараараа ёс зүйн үүрэг. Үүрэгтэй илүү ойрхон байдаг. Шударга ёсны хэм хэмжээ нь дистрибутив (хуваарилах) ашигтай байх өөрөөр хэлбэл, хүн бүрт ашигтай байх” гэжээ.

Эрх зүй нь эрх чөлөөний тэгш байдлыг илэрхийлж байдаг тул шударга ёсны ойлголттой агуулгаараа давхцаж байдаг. Иймд эрх зүйд нийцэж, эрх зүйг дагадаг зүйл л шударга байдаг байна.

Эрх зүй нь агуулгаараа шударга ёстой нийцэж байдаг тул эртнээс “Эрх зүй нь

шударга ёсны илэрхийлэл”, “Эрх зүй нь шударга ёсны урлаг” үзэж ирсэн үзэл өнөөг хүртэл хэвээр байна.

Ийнхүү эрх чөлөө, тэгш байдал, шударга ёс нь эрх зүйн агуулгыг тодорхойлж, эрх зүйн үнэт зүйлийн илрэл болж байдаг тул эрх зүйн тогтолцооны үндэс юм.



Хяналтын асуулт:

1. Эрх зүй яагаад нийгмийн үнэт зүйлтэй холбоотой байдаг вэ?
2. Эрх зүйг үнэт зүйлийн онол арга зүйгээс гадуур танин мэдэж болох уу?
3. Эрх зүй нь үнэлэмжийн объект мөн үү?
4. Эрх зүйн үнэт зүйлийг ямар түвшинд ойлгож, танин мэдэх боломжтой вэ?
5. Орчин үед эрх зүйн үнэт зүйлийн ямар үзэл баримтлал байна вэ?
6. Эрх зүйн үнэт зүйлийн илрэн гарах ахуйн хэлбэрүүдийг тодорхойлно уу?
7. Эрх чөлөө гэж юу вэ?
8. Орчин үеийн эрх чөлөөний үзэл баримтлалын чиг хандлагуудыг тодорхойлно уу?
9. Бодит эрх чөлөө ба эрх зүйн эрх чөлөөний ялгаа, онцлогийг тодорхойлно уу?
10. Эрх чөлөөний хязгаар, түүний илрэн гарах хэлбэрийг тодорхойлно уу?
11. Эрх чөлөөний тэгш байдал ба эрх зүйн тэгш байдлын хамаарлыг тодорхойлно уу?
12. Тэгш эрх, тэгш байдлын ялгааг тодорхойлно уу?
13. Тэгш байдлын шинжийг тодорхойлно уу?
14. Эрх зүй яагаад шударга ёстой агуулгаараа давхцдаг вэ?



Ном зүй:

1. Бердяев.Н.А.Философия неравенства.М., 1990.
2. Бердяев.Н.А.О правдании неравенства.М., 1990.
3. Бердяев.Н.А.Философия свободы.Истоки и смысл русского коммунизма.М., 1997.
4. Бердяев.Н.А.Философия свободного духа.М., 1994.
5. Гегель.Г.В.Философия права.М., 1990.
6. Геллнер.Э.Условия свободы.Гражданское общество и его исторические соперники.М., 1995.
7. Гоббс.Соч.т-1, 2.М., 1994.
8. Кант.И.В метафизике в нравов.Соч.Т-6.М., 1994.
9. Локк.Ж.Избранные философские произведения.М., 1960.
10. Локк.Ж.Соч.т-1-3.1993.
11. Монтескье.Ш.О духе законов.С-Пб.1990.
12. Немецкая классическая философия.т-1-2.М., 2000.
13. Нерсесянц.В.С.Философия права.М., 1997.
14. Тихонравов.Ю.В.Основы философии права.М., 1997.
15. Хеффе.О.Политика, право, схаведливость.М., 1994.
16. Шершеневич.Г.Ф.Общая теория права.т-1, 2.М., 1995.
17. The theory of justice by Rudolf Stammler (1969)
18. The Theory of Justice (Modern Legal Philosophy Series) by Rudolf Stammler (Jan 10, 2000)
19. A Theory of Justice: Original Edition by John Rawls (Mar 31, 2005)
20. A Theory of Justice Revised Edition edition by John Rawls (1999)
21. The Philosophy of law (Oxford Readings in Philosophy) by Ronald M. Dworkin (Jan 6, 1977)
22. Sovereign Virtue: The Theory and Practice of Equality by Ronald Dworkin (Mar 1, 2002)
23. A Matter of Principle by Ronald Dworkin (Oct, 1985)
24. Freedom's Law: The Moral Reading of the American Constitution by Ronald Dworkin (Apr 25, 1997)

V бүлэг Эрх зүйн гносеологи

Зорилго: Эрх зүйн танин мэдэхүйн ойлголт, зорилго, чиг хандлага, тэдгээрийн арга зүйн ялгаа онцлогийг танин мэдэх, эрх зүйн үнэн мэдлэгийг олж авах

Эрх зүйн философийн нэг үндсэн асуудал нь эрх зүйн танин мэдэхүйн / гносеология/ асуудал болно.

Эрх зүйн танин мэдэхүйн зорилго нь эрх зүйн мөн чанар, бодит нөхцөлийг судалж, эрх зүйн тухай үнэн мэдлэгт хүрэх явдал юм. Эрх зүйн танин мэдэхүй нь эрх зүйн онтологи, аксеологитой шууд холбоотой.

Эрх зүйн танин мэдэхүйн хувьд эрх зүйн агуулга, түүний хэлбэр, тэдгээрийн харилцан хамаарлын тухай асуудал чухал байр суурь эзэлдэг бөгөөд эрх зүйн философийн хөгжлийн явцад өнөөг хүртэл эрх зүйн танин мэдэхүйн хоёр чиг хандлага байсаар байна. Үүнд:

1. Хууль зүйн (Легистский буюу Lex-хууль гэсэн латин үгнээс гаралтай) буюу позитивист чиг хандлага

2. Эрх зүйн (Юридический буюу Ius-Эрх зүй гэсэн латин үгнээс гаралтай) буюу позитивист бус чиг хандлага

Эрх зүйн танин мэдэхүйн энэхүү хоёр чиг хандлагууд нь эрх зүйд хандах хандлага, онол- арга зүйн хувьд ялгаатай юм.

1. ЭРХ ЗҮЙН ТАНИН МЭДЭХҮЙН ПОЗИТИВ /ХУУЛЬ ЗҮЙН/ ЧИГ ХАНДЛАГА

Эрх зүйн танин мэдэхүйн позитив /хууль зүйн/ чиг хандлага нь “Эрх зүй ямар байх ёстой вэ?” гэдэг бол бодит эрх зүй биш, хийсвэр санаа учраас “эрх зүйг ямар байна вэ?” гэсэн байгаа зүйлийн хүрээнд судлах ёстой хэмээн үзэж, эрх зүйн агуулгыг бус, хэлбэрийг судалдаг юм.

Эрх зүйн танин мэдэхүйн позитивист /легист/ чиг хандлага нь арга зүйн үүднээс:



“Эрх зүй ямар байна вэ?”

Эрх зүйг байгаа зүйлийн хүрээнд судалдаг

Эрх зүйг хэлбэр талаас нь судалдаг

Эрх зүйн танин мэдэхүйн позитивист /легист/ чиг хандлага нь эрх зүйг хууль тогтоогчийн хүсэл зоригийн үр дүн, албадлагын хэм хэмжээ хэмээн үзэж, хууль эрх зүйг адилтгадаг. Энэ үндсэнд бүх хууль, захиргааны акт, шүүхийн шийдвэр буюу төрийн засаглалын бүх актуудыг эрх зүй хэмээн ойлгодог юм.

Хууль болон бусад актууд нь төрөөс хамгаалагдаж, төрийн албадлагаар хангагдаж, нийгэмд албадлагын журмыг бүрдүүлж байдаг. Энэхүү албадлагын журмыг зөрчвөл хууль зүйн хариуцлага оногдуулдаг. Иймд эрх зүйн танин мэдэхүйн позитивист чиг хандлага нь **эрх зүй гэдэг нь бүх нийтээр заавал биелүүлэх, албадлагын хүчээр хангагдсан, албан ёсны хуулийн хэлбэрээр нийтлэгдсэн хэм хэмжээ** гэж тодорхойлдог байна. Дээрхээс үндэслэн позитивист чиг хандлага нь эрх зүйг агуулгаасаа огт хамааралгүй оршдог хэмээн үзэж, хуулиас гадуурхи эрх зүйн тухай асуудлыг авч үздэггүй юм. Позитивистүүд хууль, эрх зүйг адилтган үзэж, ёс суртахуун, шашин, танин мэдэхүйн онолын үзэл баримтлалын үүднээс эрх зүйд сайн муу, зөв буруу, шударга шударга бус гэсэн үнэлэлт дүгнэлт өгөх нь эрх зүйн ойлголтонд огт хамааралгүй гэж үздэг байна.

Эрх зүйн танин мэдэхүйн позитивист /легист/ чиг хандлага нь агуулгын үүднээс :

1. Эрх зүй агуулгаас ангид оршдог
2. Эрх зүй төрөөс үүсмэл
3. Эрх зүйн мөн чанар- албадлага
4. Эрх зүй бол хууль
5. Эрх зүй хуульд тусгагдсан бол үнэн
6. Эрх зүйн үнэлэмж эрх зүйн ойлголтонд хамаарахгүй

Легизмын танин мэдэхүйн онолын ашиг сонирхол нь позитив эрхэд төвлөрч байдаг учир позитив эрхийн хүрээнээс гарсан эрх зүйн мөн чанар, эрх зүйн санаа, эрх зүйн үнэт зүйлс гэх мэт эрх зүйн санаануудыг үгүйсгэдэг. Ийнхүү позитивист танин мэдэхүй нь үндсэндээ эрх зүйн онолыг үгүйсгэж, гагцхүү хууль зүй судлал, хуулийн тухай сургаал байх ба хууль зүй судлалын судлагдахуун нь позитив эрх байна. Хууль зүй судлалын зорилго нь эрх зүйн догма /позитив эрхийн тухай үзэл санаа, чиг хандлага, позитив эрхийг судлах арга зүй, позитив эрхийн тухай тайлбар, ангилал, системчлэл г.м./ гэжээ.

Позитивист танин мэдэхүйн хувьд үйлчилж буй эрх зүйг /хуулийг/ танин мэдэх гэдэг нь хуульд тусгагдаагүй шинэ мэдлэгийг олж авах, хуулийн мөн чанарыг танин мэдэх асуудал биш юм. Учир нь эрх зүйн тухай бүх мэдлэг нь позитив эрхэд, түүний текстэд байгаа учраас гагцхүү хуулийн текстийг зөв тайлбарлах явдал гэж үздэг байна. Үүнтэй уялдан позитивистүүд лингвист философитой холбогддог.

Үнэт зүйлсийн хүрээнд легизм нь эрх зүй, хууль хоёрыг адилтгадаг учир эрх зүйн үнэт зүйлсийг үгүйсгэж, хуулийн үнэт зүйлсийг л хүлээн зөвшөөрдөг. Гэхдээ хууль тогтоох явцад хууль нь үнэт зүйлсийн агуулгаасаа гаждаг юм.

Эрх зүйн танин мэдэхүйн позитивист /легист/ чиг хандлага нь:

1. Танин мэдэхүйн онол нь - хууль зүйн судлал

2. Үнэт зүйлийн хүрээнд хуулийн үнэт зүйлийн авч үздэг

3. Онтологийн үүднээс хууль эрх зүйн үзэгдэл болохыг үгүйсгэж, хууль эрх зүйн илрэн гарах хэлбэр бус, харин хууль эрх зүйг бий болгодог

Эрх зүйн танин мэдэхүйн позитивист /легист/ чиг хандлага нь дараах хоёр эмперик фактыг авч үздэг. Үүнд:

- Албадлагын хэм хэмжээг тодорхойлж, түүнийг системчлэх, ангилах асуудлыг,
- Хууль тогтоогчийн үзэл хандлагыг тодорхойлох гэсэн 2 эмперик фактыг авч үздэг.



2. ЭРХ ЗҮЙН ТАНИН МЭДЭХҮЙН ПОЗИТИВИСТ БУС /ЭРХ ЗҮЙН/ ЧИГ ХАНДЛАГА

Эрх зүйн танин мэдэхүйн позитивист бус /эрх зүйн/ чиг хандлага нь танин мэдэхүйн хүрээнд эрх зүйн үнэнд хүрэхийг эрмэлздэг тул эрх зүйг ямар байх ёстой? гэсэн байх ёстой зүйлийн хүрээнд, эрх зүйн мөн чанар, агуулгыг судалдаг юм.

Эрх зүйн танин мэдэхүйн позитивист бус /эрх зүйн/ чиг хандлага нь арга зүйн үүднээс:

1. “Эрх зүй ямар байх ёстой вэ?”

2. Эрх зүйг байх ёстой зүйлийн хүрээнд судалдаг

3. Эрх зүйг агуулга талаас нь судалдаг

Эрх зүйн танин мэдэхүйн позитивист бус /эрх зүйн/ чиг хандлага нь эрх зүй хууль хоёрыг ялгаж, эрх зүйг хуулийн өмнө байсан гэж үздэг. Энэ үндсэнд эрх зүй зөв байна гэдэг нь хууль тогтоомжийн хэлбэрээр илэрч хуульд тусгагдсанаараа бус, харин агуулгаасаа шалтгаална. Хууль эрх зүйн байх ёстой боловч зарим тохиолдолд бодит байдалд хууль агуулгаараа эрх зүйн бус, дур зоргын байх тохиолдол байна. Иймд Германы сонгодог философич Г.В. Гегель: “хууль тогтоох явцад хууль агуулгаасаа гажих тохиолдол байдаг учраас хууль бүхэн эрх зүй биш” гэжээ.

Хүний эрх, эрх чөлөөний хязгаар, хэмжээ нь гагцхүү эрх зүйн хэм хэмжээгээр тодорхойлогдож, эрх зүйн харилцааны хүрээнд л хэрэгждэг билээ. Энэ үндсэнд эрх зүй нь “эрх чөлөөний хэмжүүр”, “нийгэмд амьдарч буй хүмүүсийн удирдлага болгож буй хүний зан үйлийн шаардлага, эрх чөлөөний хэм хэмжээ” болохын хувьд түүний мөн чанар нь хүний эрх, эрх чөлөөгөөр тодорхойлогддог байна. Иймд төрийн албадлага нь эрх зүйн шаардлага, объектив шинжийн үр дагавар болохоос эрх зүйн мөн чанарыг тодорхойлох хүчин зүйл биш юм.

Эрх чөлөөний шаардлага, хэм хэмжээ нь хуулиар илэрч, хуулийн хүч чадлаар бэхжин, төрийн албадлагын хүчээр хамгаалагдаж байдаг тул хууль нь эрх чөлөөнд үйлчлэх ёстой. Иймд Английн нэрт сэтгэгч Ж.Локк: “хуулийн зорилго нь эрх чөлөөг үгүйсгэх буюу хязгаарлах явдал бус, харин эрх чөлөөг хадгалах, өргөтгөхөд оршино”¹⁹ гэжээ.

Эрх чөлөө
агуулга



Хууль
хэлбэр

Эрх зүйн танин мэдэхүйн позитивист бус /эрх зүйн/ чиг хандлага нь агуулгын үүднээс:

1. Эрх зүйг агуулгаас нь салгаж үл болно

2. Эрх зүй нь төр, хуулиас өмнө байсан

3. Эрх зүйн мөн чанар - хүний эрх, эрх чөлөө

4. Хууль бүхэн эрх зүй биш

5. Хууль эрх зүйн илрэн гарах хэлбэр

6. Эрх зүй нь ёс зүйн үнэлэмж, шударга ёстой холбоотой

Эрх зүйн танин мэдэхүйн позитивист бус /эрх зүйн/ чиг хандлага нь:

1. Танин мэдэхүйн онолын үүднээс эрх зүйн мөн чанар агуулгыг тодорхойлж, эрх зүйн үнэнд хүрэхийг эрмэлздэг
2. Үнэт зүйлийн үүднээс эрх зүйн объектив мөн чанар, үнэт зүйлийг илрүүлж, түүний зорилго, ач холбогдлыг тодорхойлж өгдөг
3. Онтологийн үүднээс эрх зүй оршин буйг нотолж, эрх зүйн объектив шинж, үүрэг зорилгыг илрүүлж, эрх зүйн илрэн гарах хэлбэр хууль болохыг тодорхойлдог

¹⁹ Локк.Дж.Сочинения в трех томах. М.1988.т-3.Два трактата о правлении.стр.293.



Хяналтын асуулт:

1. Эрх зүйн танин мэдэхүйн зорилго юу вэ?
2. Эрх зүйн танин мэдэхүйн позитив чиг хандлагын арга зүйн зарчим, түүний онцлогийг тодорхойлно уу?
3. Эрх зүйн танин мэдэхүйн позитив чиг хандлага нь эрх зүйн мөн чанарыг яагаад төрийн албадлага гэж үздэг вэ?
4. Эрх зүйн танин мэдэхүйн позитив чиг хандлага яагаад эрх зүйг хууль гэж үздэг вэ?
5. Орчин үед эрх зүйн танин мэдэхүйн позитив чиг хандлага нь эрх зүйн ямар хоёр эмперик фактад анхаарал хандуулдаг вэ?
6. Эрх зүйн танин мэдэхүйн позитив бус чиг хандлагын арга зүйн зарчим, түүний онцлогийг тодорхойлно уу?
7. Хууль бүхнийг эрх зүй гэж үзэж болох уу?
8. Эрх зүйгээс гадуур хууль байж болох уу?
9. Эрх зүйн танин мэдэхүйн позитив бус чиг хандлагын либертари онолын үүднээс дур зорго, эрх зүйн ялгааг тодорхойлно уу?
10. Эрх зүйн танин мэдэхүйн позитив бус чиг хандлага нь эрх зүй, хуулийн хамаарлыг хэрхэн үздэг вэ?

Ном зүй:

1. Kaufmann.A. Rechtsphilosophie.1997.
2. The Philosophy of law (Oxford Readings in Philosophy) by Ronald M. Dworkin (Jan 6, 1977)
3. В.С. Нерсесянц. Философия права. М. 1997.
4. Лүндээжанцан. Д. Жалбажав. Н. Отгонтуяа. Д. Эрх зүйн философи. УБ. 1998
5. Jules Coleman and Scott Shapiro. Jurisprudence and Philosophy of Law. Oxford. 2002.
6. Данильян. О.Г. Философия права. М. 2005.
7. Тихонравов.Ю.В.Основы философии права.М., 1997.
8. Лүндэндорж. Н. Эрх зүйн сэтгэлгээний хөгжлийн чиг хандлага УБ.2003.
9. Лүндэндорж. Н. Jurisprudence. Эрх зүй судлал: философи, онол.УБ.2011.
10. Нарангэрэл. С. Монголын ба дэлхийн эрх зүйн тогтолцоо. УБ. 2001
11. Сэлэнгэ Х. Эрх зүйн танин мэдэхүй: онолын үндэслэл. "Эрх зүй" сэтгүүл, УБ, 2002, №8-9


Б. “ЭРХ ЗҮЙН ФИЛОСОФИ”-ИЙН ОНОЛЫН ЧИГ ХАНДЛАГА

VI бүлэг Жам ёсны эрхийн онол


Зорилго: Жам ёсны эрхийн ойлголт, шинж, онцлог, түүнийг хэрэгжүүлэх нөхцөл, арга зам болон жам ёсны эрхийн онолын сэтгэлгээний хөгжил, арга зүйн онцлог, орчин үеийн чиг хандлагыг танин мэдэх

1. ЖАМ ЁСНЫ ЭРХИЙН ОНОЛЫН ҮҮСЭЛ, ОНЦЛОГ

МЭӨ V зууны үед эртний Грекийн ертөнцийг үзэх үзлийн нөлөөгөөр софистууд /Протагор, Гипсий, Алкидам, Антифонт гэх мэт/ ёс суртахууны сэтгэлгээнд үндэслэн шударга ёсонд хүрэхийн тулд жам ёсны эрхийн үзэл санааг анх гаргасан юм.



Энэ ертөнцөд байгалийн болон нийгмийн гэсэн хоёр харилцаа зэрэгцэн оршиж байгаа бөгөөд хамгийн шударга хууль нь байгалийн хууль юм хэмээн софистууд үзсэн. Учир нь Зевс, Прометей хэнийг ч боол байхаар төрүүлээгүй, хүн бүр байгалиасаа заяасан тэгш эрх, эрх чөлөөтэй юм. Гэтэл нийгмийн хууль болох позитив хууль нь энэхүү эрхийг зөрчиж байна хэмээн шүүмжилж, хамгийн шударга хууль бол жам ёсны хууль юм хэмээн үзэж, жам ёсны эрхийг позитив эрхийн эсрэг сөргүүлэн тавьсан байна. Ийнхүү байгалийн хууль нь хамгийн шударга хууль учраас позитив эрх нь жам ёсны эрхэд үндэслэх ёстой гэж үзээд, эрх зүйг жам ёсны эрх ба позитив эрх гэж ангилж байв²⁰.




20 Нерсесянц, В.С. Философия права. М.1997. с 405-407



Софистуудын жам ёсны эрхийн үзэл санааг Сократ, Платон, Аристотель нар уламжлан хөгжүүлсэн байна.

Эртний Грекийн сэтгэгчдээс Аристотель нь жам ёсны эрх, позитив эрхийн ойлголт, тэдгээрийн ялгааг гаргасан нь өнөөг хүртэл ач холбогдлоо алдаагүй байгаа бөгөөд орчин үеийн жам ёсны эрхийн онолын үндэс нь болж байна.

Аристотель жам ёсны эрхийг: **хүлээн зөвшөөрсөн ч, эс зөвшөөрсөн ч хаана ч хэзээ ч үл өөрчлөгдөн, мөнх оршиж, дээд хүчин чадалтай байдаг эрх** юм хэмээн тодорхойлж, жам ёсны эрх нь ёс суртахууны шаардлагуудтай агуулгаараа нийцэж байдаг тул позитив эрхийн үндэс болно гэжээ. Харин **позитив эрх нь улс бүрд харилцан адилгүй байж, байнга өөрчлөгдөж байдаг эрх** гэж тодорхойлжээ. (Аристотель. Этика.Ү.10)



Эртний Грекийн жам ёсны эрхийн үзэл санааны онцлог нь:

- Жам ёсны эрхийг позитив эрхийн эсрэг сөргүүлэн тавьж байсан явдал юм. Тухайлбал, софистууд тухайн үеийн Грекийн төр, эрх зүйг шүүмжлэн позитив эрх нь агуулгаасаа гажиж, жам ёсны эрхийг зөрчиж байна хэмээн үзэж, позитив эрхийн эсрэг жам ёсны эрхийг сөргүүлэн тавьж байв.
- Эртний Грекийн сэтгэгчид позитив эрх үйл дуугарч, үйлчлэхгүй байгаа цагт жам ёсны эрх нь үйлчилнэ гэж үзэж байв. Иймд нэг талаас жам ёсны эрхийг позитив эрх үл дуугарах үед нөлөөлөх, эрх зүйн нэг хэсэг гэж үзэх боловч, нөгөө талаас жам ёсны эрхийг эрх зүйн дээр орших эрх гэсэн зөрчилтэй ойлголт байжээ гэж дүгнэж болно.
- Ёс суртахууны сэтгэлгээнд үндэслэн жам ёсны эрхийн үндсийг шударга ёс гэж үзсэн.
- Байгаль, нийгмийн хуулийг төдийлөн сайн ялгаж зааглаж байсангүй бөгөөд жам ёсны эрхийг байгалийн хууль хэмээн үзэж байсан.

2. ЖАМ ЁСНЫ ЭРХИЙН ОНОЛЫН ХӨГЖИЛ

Жам ёсны эрхийн үзэл сэтгэлгээ нь МЭӨ V зууны үеэс өнөөг хүртэл хөгжиж байна. Дундад зууны үед Европод шашны сэтгэлгээ зонхилон хөгжиж байсан хэдий ч жам ёсны эрхийн үзэл сэтгэлгээ үргэлжлэн хөгжиж байсан юм. Дундад зууны үед ч позитив эрхийн эсрэг жам ёсны эрхийг сөргүүлэн тавьж байв. Энэ үед жам ёсны эрхийн сэтгэлгээг хөгжүүлж байсан гол төлөөлөгч нь католог шашны хутагт Аквины Фома байв.

Аквины Фома нийгэм нь эзэн тэнгэрийн шатлан захирах ёсонд үндэслэгдэж, дараах хуулиудаар зохицуулагдаж байдаг гэж үзсэн²¹. Үүнд:

- Эзэн тэнгэрийн оюун санааны ерөнхий зарчим, дээд хэм хэмжээ болох мөнхийн хууль,
- Мөнхийн хуулийн хүний оюун санаанд тусгагдан илрэх жам ёсны хууль,
- Жам ёсны хуулийг бодитой болгох үүднээс үйлчлэх төрөөс тогтоосон позитив хууль. Жам ёсны хуулиас ялгагдах позитив хуулийн ялгаа нь нүглийг цээрлүүлж, буян үйлдэхийг албадах албадлагын шинжийг агуулж, байнга өөрчлөгдөж байдаг онцлогтой гэж үзсэн.
- Позитив хууль нь нүглийг бүрэн арилгаж чаддаггүй бөгөөд хүний ухамсрын түвшин дээшилж чадаагүй нөхцөлд Библийн судар болох эзэн тэнгэрийн хууль байна.

Мөнхийн хуулиас бусад хуулиуд үүснэ. Ийнхүү жам ёсны эрхийн үндсийг эзэн тэнгэр хэмээн үзэж шашны талаас нь тайлбарлаж байв.

XVII-XVIII зууны үед жам ёсны эрхийн үзэл сэтгэлгээ нь дундад зууны хамжлагат ёс, абсолютизмын эсрэг ардчилсан хувьсгалын уриа, үзэл суртлын зэвсэг болж хөгжсөн байна. Энэ үеийн жам ёсны эрхийг хөгжүүлж байсан гол төлөөлөгчид болох Г.Гроций, Т.Гоббс, Б.Спиноз, Ж.Локк, Ш.Л.Монтескье, Ж.Ж.Руссо нар нь рационализмд үндэслэн жам ёсны эрхийг хөгжүүлж байсан.

XVII-XVIII зууны сэтгэгчид жам ёсны эрхийг төр, позитив хуулиас өмнө байсан эрх гэж үзэж байлаа. Ялангуяа Английн сэтгэгч Т.Гоббс жам ёсны эрхийг зөвхөн жам ёсны байдалд үйлчилж байсан эрх гэж үзжээ.


Жам ёсны байдал гэж юу вэ?

Английн сэтгэгч Т.Гоббс: “Хүн бүр байгалаасаа биеийн болон оюуны чадвараар тэгш төрсөн. Энэхүү тэгш байдал нь хүний мөн чанараас үүдэн өрсөлдөх, үл итгэх, эрх мэдэлд дурлах шинжийн улмаас дайсагналыг бий болгож, жам ёсны байдалд хүргэдэг. Жам ёсны байдалд нийтийн засаглал үгүй тул хууль үгүй, хууль үгүй тул шударга ёс байхгүй байсан” гэжээ.

21 Нерсеянц, В.С. Философия права. М.1997. с 405-407



Мөн жам ёсны байдалд хүн байгалийн дээд хуулийн дагуу амьд явах эрхээ хадгалах үүднээс өөрийн хүчийг ашиглаж буй эрх чөлөө буюу жам ёсны эрх үйлчилнэ. Иймд жам ёсны байдлыг “бүгдийн эсрэг бүх нийтийн дайн байсан үе” гэж тодорхойлжээ. Харин жам ёсны байдлаас гарч, хүн төрд нэгдсэн үед хүний амьдралыг ахуйд хадгалах үүднээс амьдралын эсрэг үйлдлийг хориглосон “өөртөө хүсэхгүй зүйлийг бусдад бүү хий” гэсэн хүний оюун санааны шаардлага болох жам ёсны хууль үйлчилнэ гэж жам ёсны эрх, жам ёсны хуулийг ялгаж авч үзсэн байна.



XVII - XVIII зууны сэтгэгчид жам ёсны байдлаас гарах нь зайлшгүй гэж үзэж байсан ба жам ёсны эрхийг хэрэгжүүлэх гол нөхцөл бол төр гэж үзэж байв. Тухайлбал, Ж. Локк: Жам ёсны байдалд хүний эрх, эрх чөлөөг хязгаарласан хууль, ямар нэгэн байгууллага байхгүй байсан тул байгалийн хууль л үйлчилж байв. Жам ёсны байдалд хүн бүр засаглалын дээд эрх эдэлдэг учраас өөрийн эрхийг зөрчсөн

буруутай этгээдийг шүүх эрхтэй байлаа. Энэ үед хүний эрхийн хязгаарлал байхгүй байсан боловч эрхээ эдлэх нь найдвартай бус, бусдын халдлага заналхийлж байсан тул жам ёсны байдлыг тэвчих боломжгүй. Иймд жам ёсны байдлаас гарах нь зайлшгүй²² гэжээ.

Төрд жам ёсны эрхийг хэрэгжүүлэх арга замыг Т.Гоббс²³ үзэхдээ: “бусдын эрх, эрх чөлөө зөрчигдөх нөхцөлийг үгүйсгэх үүднээс жам ёсны зарим эрхээс татгалзах, эсвэл жам ёсны зарим эрхээ бусдад /төрд/ шилжүүлэх” нь зүйтэй гэж үзсэн.

Төрд жам ёсны эрхийг хэрэгжүүлэх нөхцөл:

Жам ёсны зарим эрхээс татгалзах

Жам ёсны зарим эрхээ бусдад буюу төрд шилжүүлэх

Харин Т.Гоббсын энэхүү үзлийг Ж. Локк шүүмжлэж “хүн бүр халдашгүй дархан эрхтэй тул жам ёсны эрхээсээ татгалзаж болохгүй” гэж үзэж байв. Энэ үндсэнд Ж. Локк нь: “хуулийн зорилго бол эрх чөлөөг үгүйсгэх буюу хязгаарлах явдал биш, харин эрх чөлөөг өргөтгөх, хадгалах явдал юм. Иймд хууль байхгүй газар эрх чөлөө байдаггүй²⁴ гэжээ.

XVII - XVIII зууны жам ёсны эрхийн үзэл сэтгэлгээний онцлог нь жам ёсны эрхийг улс төр, эрх зүйн идеал гэж үзэж, позитив эрх нь хаана хүний оюун санаатай зөрчилдөж, үйлчлэхгүй байна, тэнд л жам ёсны эрх үйлчилнэ гэж үзэж байсанд оршино²⁵.

22 Нерсесянц. В.С. Философия права. М.1997. с 405-407

23 Гоббс. Т. Сочинения в двух томах. М.1991. т 2. Левиафан, или материя, форма и власть государства церковного и гражданского. С 93-100.

24 Локк. Дж. Сочинения в трех томах. М. Т 3. Два трактата о правлении. С 293.

25 Шершеневич.Г.Ф. Общая теория права. М. 1995. т 1. с 30



3. Сэргэн мандсан жам ёсны эрхийн онол, онцлог


ХИХ зууны үед хууль зүйн шинжлэх ухаанд позитивизм ноёрхсоноор жам ёсны эрхийн үзэл сэтгэлгээ нь хямралд орсон.

МЭӨ V зуунаас ХИХ зуун хүртэл удаан хугацаанд эрх зүйн сэтгэлгээнд ноёрхож байсан жам ёсны эрхийн онол яагаад хямралд оров?

Позитивизм нь нийгмийн амьдралыг хуульчилж, хүний эрх, эрх чөлөөг хуулиар баталгаажуулснаараа жам ёсны эрхийн онолоос давуу байсан юм. Иймд жам ёсны эрхийн үзэл сэтгэлгээг “хоосон утопи номлол, сэтгэлгээний аюултай төөрөгдөл, жам ёсны эрхийг хууль зүйн шинжлэх ухаанаас авч хаях нь зүйтэй” гэж шүүмжилж байв. Гэвч нийгмийн хөгжлийн явцад төрөөс тогтоогдсон позитив хууль нь хуучирснаар үзэл номлол сэргэн мандах болсон. Иймд ХХ зуунд жам ёсны эрх нь сэргэн мандаж өнөөг хүртэл хөгжиж байна.

Позитивизм нь “хууль бол хууль” гэсэн зарчим баримталж, эрх зүй хуулийг адилтгаж үздэг учраас хууль нь эрх зүйн шинжтэй эсэх, ямар хуулийг зохистой, шударга хууль гэж үзэх, эрх зүй, хуулийн шалгуур нь юу вэ? гэсэн асуултад хариулт өгдөггүй бөгөөд харин үүнд л жам ёсны эрхийн мөн чанар оршиж байдаг болно.

Сэргэн мандсан жам ёсны эрхийг баримтлагчид өмнөх сэтгэгчдийн нэгэн адил позитив эрхээс өмнө оршиж, түүний агуулгыг тодорхойлох шалгуур нь болох жам ёсны эрх байна хэмээн үзэхээс гадна жам ёсны эрхийг хүн төрөлхтний үнэт зүйл гэж тодорхойлжээ. Мөн “жам ёсны эрх бол хүний объектив ахуйн шаардлага, үнэт зүйлсийн илрэл бөгөөд хаана ч, хэзээ ч мөнх оршиж байдаг, нөхцөлгүй эрх” хэмээн тодорхойлоод, жам ёсны эрх ба позитив эрхийн ялгааг гаргасан.



Хэдийгээр энэхүү хоёр эрх нь хоорондоо ялгаатай боловч салшгүй холбоотой юм. Учир нь позитив эрх нь жам ёсны эрхтэй нийцсэнээр эрх зүйн шинжийг агуулж байдаг. Өөрөөр хэлбэл, эрх зүйн шинжийг агуулах үүднээс позитив эрх нь жам ёсны эрхтэй нийцэж байх ёстой байна. Харин жам ёсны эрх нь эрх зүйн тодорхой

шаардлагуудтай нийцэж байх үүднээс өөртөө үнэт зүйлийг агуулж байдаг тул эрх зүйн үндэс, шалгуур нь болж байдаг. Жам ёсны эрх нь аливаа объектив, субъектив эрхийн үндэс болохынхоо хувьд түгээмэл шинжтэй. Иймд жам ёсны эрхийг “эрх зүйн дотоод дүрэм” гэж үздэг.

Сэргэн мандсан жам ёсны эрхийн үзэл хандлагын гол онцлог нь:

Сэргэн мандсан жам ёсны эрхийг баримтлагчид тодорхой зорилгоос түдгэлзэж, гагцхүү жам ёсны эрхийн абсолют үндсийг эрэх болсон.

Уламжлалт жам ёсны эрхийн онолчид жам ёсны эрхийг байх ёстой зүйлийн хүрээнд авч үздэг байсан бол орчин үед байгаа зүйлийн хүрээнд авч үзэх болсон байна.

Жам ёсны эрх гэсэн идеал үзэл сэтгэлгээнээс бодит позитив эрхэд хандах хандлага биш, харин бодит объектив жам ёсны эрхийн үүднээс байгаа позитив эрхэд хандах хандлага хэмээн үзэх болсон.

4. Жам ёсны эрхийн онолын орчин үеийн чиг хандлага

Сэргэн мандсан жам ёсны эрхийн үзэл хандлага нь ХХ зуунаас дараах үндсэн хоёр урсгалаар хөгжиж байна. Үүнд:

Христос шашны чиглэлээр

Либерализмын чиглэлээр

Христос шашны чиглэлээр жам ёсны эрх нь хөгжихдөө түүний хоёр үндсэн урсгалаар хөгжиж байгаа болно.

Католог шашны чиглэлээр жам ёсны эрхийг хөгжүүлэгчид (неотомизмын төлөөлөгчид болох Ж.Маритен, Ж.Дабен, В.Катрайн) Аквины Фомагийн үзэл сургаальд үндэслэж, “жам ёсны эрх нь эзэн тэнгэрийн ёс журмын илрэл, хүний зан



үйлийн төгс журам учраас позитив эрхийн үндэс, шалгуур” гэж үздэг. Энэ үндсэнд жам ёсны эрх нь хүний оюун ухаанаар илэрч, эзэн тэнгэрийн хүсэл зоригт хүрэхийн тулд хүний үйл ажиллагааны явцад чөлөөт хүсэл зоригийн тусламжтайгаар хэрэгжиж байдаг байна.

Харин протестант шашны чиглэлээр жам ёсны эрхийг хөгжүүлэгчид (К.Барт, Э.Вольф, Ф.Хорст нар Августины сургаалд үндэслэдэг) нь мөн жам ёсны эрхийг эзэн тэнгэрийн хүсэл зоригийн илрэл хэмээн үздэг боловч марксизмын нэгэн адил огцом өөрчлөлт хийх үзлээрээ ялгаатай юм.

Либерализм нь XVII зуунд Европод үүсч, нийгэм, төрийн үндсийг бие хүний эрх, эрх чөлөө гэж үздэг бие даасан урсгал бөгөөд дэлхийн II дайны дараа жам ёсны эрхийн онолын хүрээнд хөгжиж байна.

Либерализм нь аливаа нийгмийн оршин тогтнох үндсийг хүний эрх, эрх чөлөө буюу үндсэн эрх хэмээн үздэг.

Үндсэн эрх, үндсэн хэмжээ хоёр ямар ялгаатай байх вэ? гэсэн асуултад либерализм нь “үндсэн эрх бол үндсэн хэм хэмжээ” гэж хариулдаг бөгөөд үндсэн эрхийг нийгэм, төрөөс дээгүүрт авч үздэг.

Ийнхүү МЭӨ V зууны дунд үед үүссэн жам ёсны эрхийн үзэл сэтгэлгээний агуулга нь улам баяжиж, онолын түвшинд хүрч эрх зүйн үзэл хандлага болж дэлгэрчээ. Тийм ч учраас жам ёсны эрхийн үзэл хандлага нь улс төр, эрх зүйн баримт бичигт тусгалаа олж, амьдралд бодитой хэрэгжих болсон байна. Үүний нэг илрэл нь Монгол улс нь хүний үндсэн эрхийг 1992 оны Үндсэн хуулиар баталгаажуулж, түүний хэрэгжих боломж нөхцөлийг хангахад өнөөгийн төрийн бодлого чиглэгдэж байгаа явдал болно.

Иймд эцэст нь дүгнэхэд жам ёсны эрх нь эрх зүйн үнэт зүйл, үндсэн хэм хэмжээний түвшинд үнэлэгдэх болсон байна.

Хяналтын асуулт:

1. Жам ёсны байдал гэдгийг хэрхэн ойлгох вэ?
2. Жам ёсны эрх гэдгийг хэрхэн ойлгох вэ?
3. Жам ёсны эрх, жам ёсны хуулийн ялгааг гаргаж, тодорхойлно уу?
4. Жам ёсны эрх нь ямар нөхцөлд хэрэгжих вэ?
5. Жам ёсны эрх, позитив эрхийн ялгаа, тэдгээрийн хамаарлыг тодорхойлно уу?
6. Уламжлалт жам ёсны эрхийн онолчдын жам ёсны эрхийг судлаж ирсэн арга зүй, түүний үндсийг тайлбарлана уу?
7. Сэргэн мандсан жам ёсны эрхийн онолчдын арга зүй, түүний үндсийг тайлбарлана уу?

8. Уламжлалт жам ёсны эрхийн онол, сэргэн мандсан жам ёсны эрхийн онолын онол- арга зүйн ялгааг тайлбарлана уу?
9. Орчин үеийн жам ёсны эрхийн онолын онцлог, шинжийг тодорхойлно уу?
10. Орчин үед жам ёсны эрх, түүний ач холбогдлыг хэрхэн үнэлж байна вэ?

Ном зүй:

1. Дэвид Боаз. Либертарианизм. УБ. 2005.
2. Лүндэндорж. Н. Эрх зүйн сэтгэлгээний хөгжлийн чиг хандлага УБ.2003.
3. Лүндэндорж. Н. Jurisprudence. Эрх зүй судлал: философи, онол.УБ.2011.
4. Нарангэрэл. С. Монголын ба дэлхийн эрх зүйн тогтолцоо. УБ.2001.
5. Нарангэрэл. С. Эрх зүйн эх толь бичиг. УБ. 2007
6. Хенри Ж.Стайнер Филип Элстон.Хүний эрх.1-2-р дэвтэр.
7. Хууль зүйн салбарын залуу багш, судлаач, оюутны Эрдэм шинжилгээний бага хурлын илтгэлийн эмхэтгэл. УБ. 2005.
8. Аристотель.Политика.Соч.т-4.М., 1978.
9. Аристотель.Соч.в-4-х томах.М., 1983.
10. Бердяев.Н.А.Философия неравенства.М., 1990.
11. Бердяев.Н.А.О правдании неравенства.М., 1990.
12. Бердяев.Н.А.Философия свободы.Истоки и смысл русского коммунизма.М., 1997.
13. Бердяев.Н.А.Философия свободного духа.М., 1994.
14. Боргош.Ю.Фома Аквинский.М., 1975.
15. Верцман.И.Ж.Ж.Руссо.М., 1976.
16. Гегель.Г.В.Философия права.М., 1990.
17. Гоббс.Т.Левиафан или материя, форма и власть государства церковного и гражданского.М., 1936.
18. Гоббс.Соч.т-1, 2.М., 1994.
19. Кант.И.В метафизике в нравов.Соч.Т-6.М., 1994.
20. Керимов.Д.А.Основы философии права.М., 1992.
21. Керимов.Д.А.Философские проблемы права.М., 1972.
22. Локк.Ж.Избранные философские произведения.М., 1960.
23. Локк.Ж.Соч.т-1-3.1993.
24. Монтескье.Ш.О духе законов.С-Пб.1990.
25. Нерсесянц.В.С.Философия права.М., 1997.



26. Червернин.В.А.Основные концепции естественного права.М., 1988.
27. Jeffrie G. Murphy and Jules L. Coleman. Philosophy of Law. USA. 1990.
28. Jules Coleman and Scott Shapiro. Jurisprudence and Philosophy of Law. Oxford. 2002.
29. Kaufmann.A. Rechtsphilosophie.1997.
30. Natural Law and Natural Rights (Clarendon Law) by John Finnis (May 26, 2011)
31. Law's Empire by Ronald Dworkin (Jan 1, 1986)
32. The Philosophy of law (Oxford Readings in Philosophy) by Ronald M. Dworkin (Jan 6, 1977)

VII бүлэг

Эрх зүйн түүхэн онол

Зорилго: Эрх зүйн үүсэл, хөгжил, түүний бодит байдлыг түүхэн онолын арга зүйн үүднээс танин мэдэх

1. ЭРХ ЗҮЙН ТҮҮХЭН ОНОЛЫН ҮҮСЭЛ, АРГА ЗҮЙН АСУУДАЛ

Нийгмийн хэм хэмжээнүүд хоорондоо холбоотой, харилцан бие биендээ нөлөөлж байдаг бөгөөд зан заншил, шашин, ёс суртахууны хэм хэмжээ нь эрх зүйд хувирч байсан. Ёс суртахууны хэм хэмжээ эрх зүйд хувирсны үр дүнд жам ёсны эрхийн номлол үүсч хөгжсөн бол заншлын хэм хэмжээ эрх зүйд хувирсны үр дүнд эрх зүйн түүхэн онол үүссэн юм²⁶.

XVIII зууны сүүлч, XIX зууны эхэн үед Германд эрх зүйн түүхэн онолыг Карл Фридрих Сабиньи, Густав Гуго, Георг Пухта нар үндэслэжээ.

Эрх зүйн түүхэн онол нь эрх зүйн мөн чанарын асуудлыг бус, эрх зүйн үүсэл, түүхэн асуудлыг судалдаг онцлогтой.

Эрх зүйн түүхэн онолыг баримтлагчид эрх зүйн үүсэл, хөгжлийн тухай авч үзэхээс гадна хууль зүйн шинжлэх ухааны арга зүйн асуудлыг товойлгон гаргаж, түүхийн нилээд хугацаанд шинжлэх ухааны түүхэн аргын ач холбогдлыг үл хэрэгсэж байгааг шүүмжлэн, түүхэн уламжлал, өнгөрсөн ирээдүйн амьд холбоог хүлээн зөвшөөрч, өнгөрсөн түүхийг танин мэдэхгүйгээр орчин үеийн эрх зүйн сэтгэлгээний мөн чанарыг ойлгох боломжгүй тул хууль зүйн шинжлэх ухаанд эрх зүйн түүхийг бий болгож, түүхэн аргыг хэрэглэх нь зайлшгүй²⁷ гэж үзсэн юм.

2. ЭРХ ЗҮЙН ТҮҮХЭН ОНОЛЫН АГУУЛГА


Эрх зүйн түүхэн онолыг баримтлагчид нь ард түмэн, үндэсний хэл яриа төрөөс тогтоогддоггүйн нэгэн адил, эрх зүй нь хууль тогтоогчийн үзэмжээр тогтоогддоггүй, хүмүүсийн хоорондын харилцааны явцад аажмаар аяндаа үүсч, нийгмийн хөгжлийн явцад ард түмний оюун санаатай барьцалдан нуугдмал байдалтай байдаг. Энэхүү нэгэнт бий болсон бэлэн эрх зүйг илрүүлэх үүрэг нь хууль тогтоогч, эрх зүй судлаачдад оноогдох зүй тогтолтой. Хууль тогтоогч, эрх зүй судлаачид нь судалгааныхаа үр дүнд “бэлэн эрх зүй байна” гэж хэлэхээс хэтэрдэггүй юм. Учир нь эрх зүй нь зан заншил уламжлалд хэдийнээ нэвтэрч шингэсэн байдаг юм. Зан заншил нь ард түмний оюун санаа ухамсраас үүдэлтэй.

²⁶ Тихонравов. Ю.В. Основы философии права. М. 1997. с 502

²⁷ Friedrich Carl von Savigny. System des heutigen romischen Rechts. Berlin. 1840. s 8-9



Эрх зүй нь хөгжлийнхөө эхний шатанд заншлын хэлбэртэй байх бөгөөд хоёр дахь шатанд хууль тогтоогч, эрх зүй судлаачид эрх зүйн үндсийг алдагдуулахгүйгээр боловсруулалт хийдэг. Ийнхүү позитив эрх нь нэгэнт бий болсон амьд үйлчилж буй эрхийг гагцхүү баяжуулахаас хэтэрдэггүй бөгөөд нийгмийн харилцааг зохицуулах тэрхүү бодит эрхийг бүрэн тогтоож чаддаггүй. Позитив эрх нь сайндаа л заншлын хэм хэмжээг журамлан тогтоодог ба нийгмийн амьдралын сөрөг үзэгдэлтэй бүрэн тэмцэл явуулж чаддаггүй гэжээ. Иймд хууль тогтоогч нь ард түмний оюун санааг аль болох бодитой тусгаж чадвал позитив эрх нь хүч чадалтай, бодитой, үнэ цэнтэй байна гэж үздэг юм.



Эрх зүйн түүхэн онолын төлөөлөгч Георг Пухта үзэхдээ: “Нийгмийг зохиомлоор зохицуулж болохгүй. Ямар нэг санаачилсан эрх зүйн тогтолцоо нь ямар ч ашиггүй, үр дүнгүй байдаг. Учир нь ард түмний оюуны хөгжил, бодит амьдралаас гадуур бий болсон эрх зүй нь хэрэгжих боломжгүй”²⁸ гэжээ. Германы сэтгэгч Гегель нь эрх зүйн түүхэн онолыг шүүмжилдэг боловч “ард түмний оюун санаа хөгжлийн тодорхой өндөр түвшинд хүрэхээр өмнөх үеийн төрийн байгуулал, эрх зүйн тогтолцоо тогтвортой шинжээ алдаж, ямар ч хүч чадалгүй болж нуран унадаг”²⁹ гэжээ. Харин ард түмний оюун санаа хөгжлийн тодорхой түвшинд хүрээгүй байхад түүхээс бүтээгдээгүй (зохиомол) төрийн хэлбэр, түүнд тохирсон эрх зүйн хэм хэмжээг тулган хүлээлгэж болохгүй юм.

Эрх зүйн түүхэн онол нь XIX зууны эхний хагаст ноёрхож, “эрх зүй бол нийгмийн хөгжлийн явцад аажмаар аяндаа үүсдэг заншлын хэлбэржсэн хэм хэмжээ, ард түмний оюун санааны бүтээгдэхүүн” гэж үздэг.

3. ЭРХ ЗҮЙН ТҮҮХЭН ОНОЛД ХАНДАХ ХАНДЛАГА

Эрх зүй зан заншлаас үүдэлтэй юу? Эрдэмтэн судлаачид энэхүү онолд хэрхэн хандаж байна вэ?

Эрх зүйн түүхэн онолд эрдэмтэн судлаачид янз бүрээр хандаж байна. Тухайлбал, Германы эрдэмтэн П.Кошакер, Ф.Викер нар нь эрх зүйн түүхэн онолыг эрх зүйн сэтгэлгээг системтэй хөгжүүлэхэд ач холбогдолтой гэж үздэг. Ф.Викер: “эрх зүйн түүхэн онол нь Европын хувийн эрх зүйн үндсийг алдагдуулаагүй бөгөөд

28 Тихонравов. Ю.В. Основы философии права. М. 1997. с 502
29 Гегель. Г.Ф. Философия права. М. 1990. с 379

харин түүнийг гүнзгийрүүлэн хөгжүүлсэн юм”³⁰ гэжээ. Харин АНУ-ын социологийн онолын төлөөлөгч Р.Паунд: “Эрх зүйн түүхэн онол нь эрх зүйн тогтвортой байдлыг тайлбарлахад сайн нөлөөтэй, ач холбогдолтой боловч, эрх зүйг өөрчлөн боловсронгуй болгоход сөрөг нөлөөтэй”³¹ гэж шүүмжилж байна. Мөн Германы социологийн онолын төлөөлөгч Ё.Эрлих, Г.Канторович нар нь эрх зүйн түүхэн онолыг шүүмжлэн: “жам ёсны эрхийн үзэл сэтгэлгээнээс салж чадаагүй, шүүгч эрх зүйг хэрэглэхээс, бүтээдэггүй гэж үзсэн нь учир дутагдалтай”³² гэжээ.

Эрх зүйн түүхэн онолыг баримтлагчид нь шүүгч эрх зүйг бүтээх, эс бүтээх асуудлыг авч үзээгүй бөгөөд энэхүү асуудал нь хууль зүйн шинжлэх ухааны маргаантай асуудлын нэг болно.

Ер нь эрх зүйн түүхэн онолын үүднээс эрх зүйд хандах арга зүйг үгүйсгэх аргагүй. Учир нь Англо-саксоны эрх зүйн тогтолцооны түүх, Монголын эрх зүйн түүх рүү эргэж харвал зан заншлаас эрх зүй үүссэн байна. Нөгөө талаар эрх зүй бүр зан заншлаас үүсдэг үү? Бас тийм биш бөгөөд өнгөрсөн түүхийг эргэн харвал ихэнхдээ хүчирхийлэлийн болон хувьсалын замаар үүссэн байна. Тухайлбал, Мусульманы эрх зүй, 1921 оны ардын хувьсгалын дараа Монгол улсад эрх зүйн тогтолцоо нь хувьсгалын замаар бүрэлдэн тогтсон билээ.

Эрх зүй ба зан заншил нь хоорондоо салшгүй холбоотой боловч механикаар нийлж байдаггүй бөгөөд зарим үед позитив эрх нь ард түмний зан заншил, шашин, соёлын эсрэг байх тохиолдол түүхэнд нилээд байдаг. Тухайлбал, Монгол улс нь социализмыг улс орны чиг баримжаа болгон хөгжиж байх үеэс уламжлалт зан заншлыг орхигдуулан үгүйсгэж, түүний эсрэг хууль тогтоомж гаргах болжээ. 1960 оны 1 дүгээр сарын 22-ны өдрийн БНМАУ-ын Их Хурлын Тэргүүлэгчдийн 7 дугаар зарлигаар “Цагаан сар”-ыг бүх нийтээр тэмдэглэхийг хориглож, жил бүрийн хаврын тэргүүн сарын шинийн нэгнийг “Нэгдэлчдийн өдөр” болгохоор тогтоосон байна. Энэ нь эрх зүй, зан заншил хоёрын хоорондын зөрчлийг харуулах боловч тухайн улс үндэстний эрх зүйн соёлоос ихээхэн хамааралтай юм.

Зарим эрдэмтэн судлаачид эрх зүй, хууль, зан заншлыг нийлүүлж, “нэгдмэл бүрдэл” гэж үзэх явдал ч байна. Тухайлбал, Хёбель эрх зүйд хүй нэгдлийн нийгмийн үеийн зан заншлыг хамааруулан “Хууль тогтоох үйл явцаас гадуур эрх зүй бүтээгддэг. Хүй нэгдлийн нийгмийн эрх зүйн ихэнхи хэсэг нь хууль тогтоох үйл явцаас гадуур бий болсон. Орчин үеийн социологийн болон реалист онол нь өнөөгийн үед эрх зүйн ихэнхи хэсэг нь хууль тогтоогчийн үйл ажиллагааны үр дүнд буй болдоггүй болохыг маш тодорхой харуулж байна”³³ гэжээ. Зан заншил, позитив эрхийг механикаар

30 Franz Wieacker. *Privatrechtsgeschichte der Neuzeit*. Göttingen, 1952. s 230

31 Roscoe Pound. *Interpretations of Legal History*. Cambridge, 1923. P. 11

32 Eugen Ehrlich. *Grundlegung der Soziologie des Rechts*. München und Leipzig. 1913. s 12

33 Hoedel.E.A. *The Law of Primitive Man. A Study in Comparative Legal Dynamics*. Cambridge, Massachusetts., 1954.P. 438



нийлүүлж, позитив эрхийн эх сурвалжийг зөвхөн зан заншил гэж үзэх үзлийг Оросын эрдэмтэн Э.А.Поздняков шүүмжлэн: “Позитив эрх нь төрийн байгууллын хэлбэрээс шууд хамааралтай бөгөөд түүнийг дагаж өөрчлөгдөж байдаг. Хэрвээ позитив эрхийн эх сурвалж нь зан заншил мөн бол төрийн байгууллын хэлбэрээс хамааралгүйгээр хэдэн зуун жил үл өөрчлөгдөн, хэвээр оршин байх байсан”³⁴ гэжээ.

Заншлын хэм хэмжээ нь эрх зүй үүсэхээс өмнө үүсч, өнөөг хүртэл устаж үгүй болоогүй байгаа бөгөөд өөрийн хөгжлөөр эрх зүйтэй зэрэгцэн хөгжиж, эрх зүйд нөлөөлж, эрх зүйн нэг чухал хэсэг нь байсаар байна. Энэ тухай эртний Грекийн философич Аристотель: “Оршин буй зан заншлаас гадуурх хууль бол ямар ч хүчгүй байдаг”³⁵ гэжээ.


4. Эрх зүйн түүхэн онолын орчин үеийн чиг хандлага

Орчин үед эрх зүйг түүхэн аспектаар судлах чиг хандлага нь хэд хэдэн чиглэлээр хөгжиж байна. Тухайлбал,

- Англи-Америкийн прагматик хууль зүйн шинжлэх ухааны чиглэлээр,
- Сэргэн мандсан жам ёсны онолын чиг хандлагаар,
- Эрх зүйн түүхэнд тулгуурлан Европын нэгдмэл эрх зүйг бий болгохыг эрмэлзсэн харьцангуй онолын чиг хандлагаар хөгжиж байна.

Англи-Америкийн прагматик хууль зүйн шинжлэх ухаанд түүхэн хандлага нь эрх зүйн хөгжлийн ерөнхий чиг хандлагыг танин мэдэхэд чиглэгдэж байна. Английн сэтгэгч Г.Мэн эрх зүйн хөгжлийг “Дүрэм журмаас гэрээ рүү” гэсэн чиг хандлагаар хөгжиж байна гэж үзсэн.

Эрх зүйн хөгжлийн чиг хандлага:



Мөн Англи-Америкийн прагматик хууль зүйн шинжлэх ухаанд түүхэн хандлага нь эрх зүйн прагматик социологийн чиг хандлагаар хөгжиж байна. Энэхүү чиг хандлага нь “социологийн нэг үндсэн хэсэг нь түүхэн хандлага” хэмээн үзэж, эрх зүйн социологид түүхэн арга хэрэглэгдэх нь зайлшгүй гэж үзсэн. Энэ үеэс эрх зүйн түүх, эрх зүйн онол салж хөгжсөн бөгөөд эрх зүйн түүх нь эрх зүйг он дараалан

34 Поздняков. Э.А. *Философия государства и права*. М. 1995. с 209 – 210.

35 Аристотель. *Политика*. Ү. 14.

судалдаг бол эрх зүйн түүхэн онол нь арга зүйн шинжтэй болохыг хүлээн зөвшөөрчээ. Нөгөө талаар түүх бол үзэл санааны илрэл. Үзэл санаа фактад хэрэгждэг, харин фактад материаллаг хүч, хэрэгцээ нөлөөлдөг тул эрх зүйн хөгжил нь түүх болон материаллаг нөхцөлөөс хамаардаг гэж үздэг.

Эрх зүйг түүхэн аспектээр судлах чиг хандлага нь Англи-Америкийн прагматик хууль зүйн шинжлэх ухаанд социологийн аргатай хослон хөгжсөн бол Европод сэргэн мандсан жам ёсны эрхийн онолын хүрээнд хөгжсөн. Энэхүү чиг хандлагын төлөөлөгч В.Дильтей үзэхдээ “түүхэн үзэгдлийг танин мэдэх явдал бол хүнийг чөлөөлөх сүүлчийн алхам мөн. Түүхийг танин мэдснээр хүний ертөнцийг танин мэдэх хийсвэр, догматик сэтгэлгээнээс ангижруулж, бодит үнэнийг танин мэдэх боломжтой болгож байна” гэжээ. В.Дильтей хүний оюун ухааныг чөлөөлөх асуудлыг ярихын хамт танин мэдэхүйг иррационализмтай / иррационализм гэдэг нь оюун ухааныг танин мэдэх бололцоо хязгаартай тул, мэдлэгийн үндсэн зүйл бол билэг совин, инстинкт гэж үздэг философийн урсгал/ холбож, “бодит байдал бол санамсаргүй тохиолдол, сохор хүчинд захирагддаг, зүй тогтолгүй гэж үзсэн. Иймд түүхийн тусламжтайгаар аливаа саадыг давж болно. Саад гэдэг бол харьцангуй ойлголт гэж үзжээ.

Харин Г. Коинг В.Дильтейн адил хууль зүйн шинжлэх ухааныг позитивизмаас чөлөөлөх асуудлыг гаргаж “эрх зүй бол хүний оюун санааны бүтээгдэхүүн” юм. Иймд нийгмийн шинжлэх ухааны аргуудын тусламжтай эрх зүйг судлаж, оюуны хүч чадлыг илрүүлэх ёстой гэжээ. Г. Коингийн түүхэн хандлагын ойлголт нь нийгмийн шинжтэй юм. Тэрээр үзэхдээ хүн төрөлхтний сэтгэлгээ нь тодорхой эрин зуунаас, соёлоос шалтгаалдаг. Иймд аливаа эрх зүй, эрх зүйн сэтгэлгээ нь түүхийн болон улс төр, нийгэм, эдийн засгийн хүчин зүйлсээс шалтгаалдаг. Хууль зүйн шинжлэх ухааны судлах зүйл нь позитив эрх мөн боловч, позитив эрх нь хүний оюуны бүтээгдэхүүн, түүхийн үзэгдэл гэж үзжээ.

Эрх зүйн түүхэн онолчид нь үзэхдээ эрх зүйн түүх нь үйлчилж буй эрх зүйг танин мэдэхэд гол үүрэг гүйцэтгэдэг. Түүхэн аргыг харьцуулсан болон социологийн арга нийлээд хавчин шахаж байна. Эрх зүйн хэм хэмжээний агуулгыг тодорхой нийгмийн хүчин зүйлсийг судлахад түүхэн арга шаардлагагүй гэж үү? Харьцуулсан эрх зүй судлал нь түүхэн аргыг хэрэглэхгүйгээр тухайн улс орнуудын түүхэн хөгжлийг судлахгүйгээр зөв дүгнэлт гаргах боломжгүй. Түүхийг сайн танин мэдээгүйгээс түүх, онолын холбоо тасарсан байна гэж дүгнэсэн. Эрх зүйн түүхийн шаардлага нь:

- Эрх зүйн түүх нь түүхэн хөгжлийг харгалзан үйлчилж буй эрх зүйг танин мэдэх үндэс болох ёстой. Жишээ нь: Либерализмын хөгжлийн түүхийг танин мэдэхгүйгээр Герман, Францын иргэний хуулийг танин мэдэх боломжгүй.
- Эрх зүйн түүх нь эрх зүйн янз бүрийн маргааныг шийдвэрлэсэн шүүхийн шийдвэрүүдийг харьцуулан судлах ёстой.



- Эрх зүйн түүх нь нийгэм, соёлын хөгжилтэй холбож эрх зүйг судлах ёстой. Эрх зүйн түүх нь эрх зүйн ерөнхий онолд их ач холбогдолтой юм.

Европын эрх зүйд үндсэн элементүүд бий бөгөөд энэ нь түүхийн баримтууд юм. Үүний үндэс нь Ромын эрх зүй болно.

Хяналтын асуулт:

1. Зан заншил, ёс суртахуун, шашны хэм хэмжээний онцлог, ялгааг тодорхойлно уу?
2. Зан заншил эрх зүйд хэрхэн хувирч байсныг түүхэн үүднээс тайлбарлана уу?
3. Эрх зүйн түүхэн онолын үүслийг тайлбарлана уу?
4. Эрх зүйн түүхэн онолын эрх зүйг судлах онол- арга зүйн онцлогийг тайлбарлана уу?
5. Эрх зүйн түүхэн онол эрх зүйн хөгжлийг хэрхэн үздэг вэ?
6. Эрх зүйн түүхэн онол эрх зүйн бодит байдал, хүч чадлыг хэрхэн үздэг вэ?
7. Эрх зүйн түүхэн онолд хэрхэн хандах вэ?
8. Эрх зүй болон зан заншлын хамаарлыг тайлбарлана уу?

Ном зүй:

1. Сэлэнгэ. Х. Эрх зүйн түүхэн онол. Эрх зүй. МУИС-ийн ХЗС-ийн сэтгүүл. УБ.2000.¹
2. Мартышин.О.В и др.История политических учений.М., 1996.
3. Нерсесянц.В.С.История политических и правовых учений.М., 1996.
4. Тихонравов.Ю.В.Основы философии права.М., 1997
5. Нарангэрэл. С. Эрх зүйн эх толь бичиг. УБ. 2007
6. Нарангэрэл. С. Монголын ба дэлхийн эрх зүйн тогтолцоо. УБ. 2001.

VIII бүлэг

Шинэкантч эрх зүйн философи

Зорилго: Эрх зүйн санаа, түүний илрэн гарах хэлбэр, эрх зүйн үнэт зүйл, Үндсэн хэм хэмжээний агуулгыг танин мэдэхийн зэрэгцээ эрх зүй, эдийн засгийн харилцан хамаарал, эрх зүйн нийгмийн өмнө хүлээх хариуцлагыг ойлгож танин мэдэх

1. Шинэкантч эрх зүйн философийн гүн ухааны үндэс

Германы сонгодог философийг үндэслэгч И.Кантын материализм, идеализмын аль алинд хальтирч байсан хоёрдмол үзлийг арилгах үүднээс XIX зууны II хагаст Германд шинэкантач философи үүссэн нь нийгмийн сэтгэлгээнд, ялангуяа эрх зүйн сэтгэлгээний хөгжилд ихээхэн нөлөөлсөн юм.

Шинэкантач эрх зүйн философи нь эрх зүйн түүхэн онол, хууль зүйн позитивизм, марксизмыг шүүмжлэн гарч ирж, XIX зууны II хагаст Германд, төдийгүй Европын эрх зүйн сэтгэлгээнд ноёрхож байсан билээ.


Арга зүйн үүднээс шинэкантач эрх зүйн философи нь И.Кантын материализм руу хальтирч байсан дуализмыг шүүмжилж, танин мэдэхүйн судлагдахуун бол объектив ахуй бус, харин субъектив ахуй хэмээн үзэж байв. Өөрөөр хэлбэл, танин мэдэхүйн судлах зүйл нь хүний сэтгэхүйн үр дүнд бүтээгддэг³⁶ гэж үзсэн. Шинэкантач эрх зүйн философийн гүн ухааны үндэс нь субъектив идеализм юм.

Шинэкантач эрх зүйн философи нь байгаль, нийгмийн шинжлэх ухааныг сөргүүлэн тавьж байлаа³⁷. Байгаль бол шалтгаан үр дагаврын нийлбэр. Байгальд аливаа өөрчлөлт нь өмнөх өөрчлөлтийн үр дагавар байдаг. Иймд байгалийн шинжлэх ухаан нь учир шалтгааны хуульд үндэслэгддэг. Харин нийгэм бол хүний хүсэл зоригийн биелэл юм. Нийгмийн шинжлэх ухаан нь зүй ёсны хуульд үндэслэгдэх ёстой хэмээн үзэж байв.


Нийгмийн үзэгдэл болох төр, эрх зүй нь хүний хүсэл зориг гэсэн априор шинжтэй зорилгыг өөртөө багтаадаг тул учир шалтгааны хуульд захирагддаггүй. Төр, эрх зүй нь нийгмийн шинжлэх ухаанд хамаарагдах бөгөөд байх ёстой зүйлийн хүрээнд, априор түвшинд судлагдана хэмээн үзжээ.

36 Под,ред. В.С.Нерсисянца. История политических и правовых учений.М.1988. стр-603

37 Орчин үед экосоциосистемын онолын үүднээс байгаль, нийгмийн шинжлэх ухааныг сөргүүлэн тавихыг больсон билээ.




Шинэкантач эрх зүйн философи нь хоёр чиг хандлагаар хөгжсөн.



2. Шинэкантач эрх зүйн философийн Бадены буюу Фрейбургийн чиг хандлага

Фрейбургийн чиг хандлага чиг хандлагын гол төлөөлөгч Г.Радбрух (1878-1949) юм. Түүний үзлээр априор санааны үүднээс эрх зүйг ойлгох ёстой бөгөөд энэ нь эрх зүйн зорилгыг тодорхойлж өгдөг. Эрх зүйн априор санаа нь өөрийн дотоод агуулгадаа эрх зүйн тогтвортой чанар, тодорхой зорилго, шударга ёс гэсэн үнэт зүйлийн шинжтэй гурван элементийг агуулдаг байна. Энэ чиг хандлага нь эрх зүйг анх удаа эрх зүйн үнэт зүйлтэй холбож, “эрх зүй бол үнэт зүйлтэй холбогдсон бодит байдал” гэж үзсэн юм.

Эрх зүйн зорилго нь үнэт зүйлийг хэрэгжүүлэх явдал. Үнэт зүйлийн эрэгцүүлэл нь эргэн тойрон буй бодит байдал буюу объектив ахуйгаас бий болдоггүй. Харин дедуктив замаар бий болдог. Иймд эрх зүйн үнэт зүйл нь нийгмийн бүтэц, зөрчлөөс хамааралгүй юм.



Эрх зүйн хамгийн гол үнэт зүйл бол шударга ёс. Шударга ёс нь априор шинжтэй ойлголт. Эрх зүй өөрийн зорилгоороо шударга ёсонд үйлчилж байдаг. Хэрэв эрх зүй шударга ёсноос салчихвал “зохистой”, “зөв” эрх зүй байж чадахгүй. Иймд шударга ёсноос салсан эрх зүйгээс татгалзах ёстой гэж үзсэн. Энэ тухай “хэрэв хууль нь хүний эрхийг баталгаажуулахаас татгалзаж, шударга ёсыг үгүйсгэсэн бол тийм хуулиуд нь үйлчлэхгүй бөгөөд ард түмэн түүнийг дагаж мөрдөх шаардлагагүй юм. Энэ тохиолдолд хуульчид эрх зүйн бус хуулийн эрх зүйн шинжийг үгүйсгэх эр зоригтой байх ёстой” гэж Г.Радбрух үзжээ³⁸.

Ийнхүү шинэкантач эрх зүйн философийн Фрейбургийн чиг хандлага нь анх удаа “эрх зүйт хууль”, “эрх зүйн бус хууль”-ийн асуудлыг гарган тавьсанаараа онол, арга зүйн ихээхэн ач холбогдолтой байна.

Энэ чиг хандлага нь эрх зүйн агуулгыг үнэт зүйлтэй холбож, эрх зүйн үнэт зүйлийг хөгжүүлэн, эрх зүйт хуулийн үзэл санааг гаргаснаараа эрх зүйн сэтгэлгээний хөгжлийн шинэ үе шатыг бий болгосон юм.

Дээрхи үзэл санааны үүднээс Г.Радбрух хууль зүйн позитивизмыг шүүмжлэн “хууль бол хууль” гэсэн энэхүү үзэл санаа нь төрөөс тогтоосон хууль тогтоомжийг сохроор дагаж мөрдөх хуульчдыг бэлтгэж байна. Энэ нь тоталитар төрийг хүлээн зөвшөөрч найр тавьж буй явдал хэмээн шүүмжилж, эрх зүйд шинэчлэл хийх хэрэгтэй байна гэж үзэж байлаа. Үүний тулд өмнөх олон зуун жил хөгжиж ирсэн өнгөрсөн үеийн эрх зүйн сэтгэлгээ рүү эргэн харах шаардлагатай гэж үзсэн³⁹.

38 Radbruch G. *Gesetzliches Unrecht und ubergesetzliches Recht (1946)*//Radbruch G. *Rechtsphilosophie. Heidelberg, 1983. S 336*

39 Radbruch G. *Gesetzliches Unrecht und ubergesetzliches Recht (1946)*//Radbruch G. *Rechtsphilosophie. Heidelberg, 1983. S 352*



3. ШИНЭКАНТЧ ЭРХ ЗҮЙН ФИЛОСОФИЙН МАРГБУРГИЙН ЧИГ ХАНДЛАГА

Шинэкантач эрх зүйн философийн Маргбургийн чиг хандлагын гол төлөөлөгч нь Рудольф фон Штаммлер (1856-1938) юм.

Маргбургийн чиг хандлагынхан үзэхдээ аливаа хүн санаа зорилгоо ухамсарлана гэдэг нь цэвэр хүсэл /Р.Штаммлер/, хүсэл зоригийн /Г.Коген/ илрэл юм. Хүний санаа зорилгыг хэрэгжүүлэх онцгой арга бол эрх зүй. Эрх зүй нь хүний “хүсэл”⁴⁰ /Р.Штаммлер/, “хүсэл зориг”-ийн /Г.Коген/ формаль шинж юм. Иймд Р.Штаммлерийн үзлээр эрх зүй нь сэтгэхүйн ертөнцөд хамаарагдах бөгөөд байх ёстой зүйлийн хүрээнд, априор түвшинд судлагдана. Эрх зүй нь ёс суртахуун, зан заншил, шашны гэсэн нийгмийн бусад хэм хэмжээнээс албадлагын шинжээрээ ялгаатай байдаг бөгөөд “Эрх зүй бол үл зөрчигдөх, заавал биелүүлэх хүсэл”⁴¹ юм.

Р.Штаммлер нь эрх зүйн ойлголт, эрх зүйн санааг ялгаж зааглан авч үзсэн. Эрх зүйн санаа нь позитив эрх зүйд үнэлэлт өгөх шалгуур болохын хувьд жам ёсны эрхийн нэгэн адил үүргийг гүйцэтгэдэг байна.


Дур зорго нь ихэнхдээ зан үйлийн ёс журмуудтай хөрш зэргэлдээ оршин байдаг учраас соёл иргэншилд хүрсэн хүмүүс байх ёстой хэм хэмжээг төгс боловсроогүй ахуйгаас гарган авах боломжгүй байдаг. Иймд байх ёстой зан үйлийн ёс журам нь ахуйгаас бус, харин байх ёстой хэм хэмжээнээс бий болно гэж үзсэн. Энэхүү үзэл санаа нь ХХ зуунд шинэчлэгдсэн позитивизм, юснатурализмын философи сэтгэлгээний хөгжлийн үндэс болсон.

Р.Штаммлер нь ХХ зуунд анх удаа “хууль яагаад эрх зүй вэ?”, хууль тогтоогч яагаад дур зорго төдийгүй, “зөв”, “үнэн” эрх зүйг тогтоох чадвартай вэ?, “үнэн, зөв эрх зүй” гэж юу вэ? гэсэн асуудлыг дэвшүүлсэнээрээ жам ёсны эрхийн онол сэргэн мандахад нөлөөлсөн. Гэхдээ Р.Штаммлерын үзэл санаа нь эрх зүйн танин мэдэхүйн хувьд жам ёсны эрхийн онолоос зарчмын өөр ялгаатай төдийгүй, түүний эсрэг байсан юм. Тэрээр жам ёсны эрхийг үгүйсгэж, позитив эрхийн зэрэгцээ онцгой төгс эрх гэж үгүй. Учир нь эрх зүй байнга өөрчлөгдөж байдаг бөгөөд хэзээ ч эрх зүй төгс боловсруулагдаж чаддаггүй хэмээн үзсэн байна. Иймд позитив эрхийн үндэс, шалгуур нь эрх зүйн санаа гэж үзжээ.

40 Р.Штаммлер нь “эрх зүйн хүсэл” гэдгийг сэтгэл зүйн утгаар бус, харин сэтгэхүйн “цэвэр хэлбэр” гэсэн утгаар авч үзсэн бөгөөд Г. Когений “хүсэл зориг”-той үзэл санааны зөрөөгүй байсан юм.

41 Под.ред. В.С.Нерсесянца. История политических и правовых учений.М.1988. стр-604

Р.Штаммлерын үзэл, жам ёсны эрхийн онолын ялгаа:



Р.Штаммлер эрх зүйн зохистой байдлыг хууль тогтоогчоос тогтоогдоно гэдгээс илүүтэй, харин хууль тогтоогдохдоо дур зоргоор бус, “зөв” тогтоогддог гэж үздэгийг олж харсан явдал юм.

Р.Штаммлерын дээрхи тавьсан асуултдаа хариулсан хариулт маш энгийн байсан бөгөөд энэ нь “эрх зүйн ямар нэгэн зарчим”, эсвэл “эрх зүйн санаа”, эсвэл “шударга ёс” оршдог гэсэн хариулт байлаа. Хууль тогтоогч эрх зүйг бүтээхдээ энэхүү зарчмыг удирдлага болгохыг эрмэлзэнэ. Иймд хууль тогтоогч эрх зүйн шийдвэрийг “зөв” гаргах чадвартай хэмээн үзсэн байна.

Р.Штаммлер эрх зүйн зарчмыг цэвэр формаль шинжтэй, өөрөөр хэлбэл хууль тогтооход агуулгын шалгуур үнэлэмжийг өгөхгүй, харин эрх зүйн тухай эрэгцүүлэх нэгдмэл формаль арга байж болох юм гэж үзсэн⁴². Энэхүү аргын утга санаа нь эрх чөлөөний ойлголтоор илрэн гардаг. Эрх зүй бол “заавал биелүүлэх хүсэл”, харин эрх зүйн нэгдэл бол “чөлөөт хүсэл зоригтой хүмүүсийн нэгдэл”. Эрх зүйн нэгдлийг бүх нийтийн эрх чөлөөний хуулийн үүднээс нэг субъектийн дур зорго, нөгөө субъектийн дур зорготой нийцэх зохицол хэмээн үздэг И.Кантын зайлшгүй дагаж мөрдөх хэм хэмжээний дагуу /категорический императив/ Р.Штаммлер нь эрх зүйн хүсэл гэдэг бол бүдүүлэг дур зорго бус, харин бусад хүмүүсийн чөлөөт хүсэлтэй нийцсэн “хүсэл” юм⁴³ гэжээ.

Эрх зүйн санаа, эрх зүйн зарчим нь чөлөөт хүсэл зоригтой хүмүүсийн нэгдлийг устгах бус, харин шударга “хүсэл” байна. Иймд шударга ёс нь хүмүүсийн мөнхийн хүсэл эрмэлзлэл. Дур зорго бус, эрх зүйн санааг удирдлага болгосноор байх ёстой “үнэн” эрх зүйд тэмүүлнэ. Эрх зүйн хэм хэмжээ идеалд ойртох албадлагын хүчийг агуулж, зөв эрх зүйг мөрдөхөөс зайлсхийж болохгүй. Төгс эрх зүйд хүрэхийг эрмэлзэх ёстой боловч түүнд бүрэн хүрч чадахгүй гэж үзсэн. Гэвч Р.Штаммлер нь

42 Отв.ред. В.С. Нерсесянца. История политических и правовых учений XXв. М. 1995. стр.118

43 Stammler R. Die Lehre von dem richtigen Rechte. Berlin. 1902 (2AufI, 1926)



хууль тогтоох явц дахь дур зорго, эрх зүйг ялгах шалгуурын тухай асуултад хариулт өгөөгүй орхисон.

Ийнхүү Р.Штаммлер нь эрх зүйн үндсийг материаллаг харилцаа, материаллаг ашиг сонирхол бус, харин эрх зүйн санаа буюу хийсвэр ерөнхий зарчим хэмээн үзсэн. Тэрээр ёс суртахуун, эрх зүйн ялгааг гүнзгийрүүлэн, ёс суртахууны хэм хэмжээ, шаардлага нь бие хүний дотоод амьдралд хамаарагддаг бол эрх зүй нь хүмүүсийн гадаад харилцааг зохицуулдаг хэмээн үзэж, эрх зүйг нийгмийн шинжтэй болохыг үгүйсгээгүй боловч, эрх зүйг эдийн засгийн харилцаанаас хамааралгүй хэмээн үзэж, марксист эрх зүйн философийн эсрэг⁴⁴ үзэл санааг гаргасан байна.

Р.Штаммлер үзэхдээ: нийгэм нь нийгмийн харилцааг зохицуулж байгаа хэлбэр буюу эрх зүй, зохицуулагдаж байгаа матер буюу эдийн засаг гэсэн хоёр хэсэгт хуваагддаг. Эрх зүй, эдийн засаг хоёр нь хоорондоо генетик холбоогүй, харин априор логик байдлаар холбогдсон. Эрх зүйгээс шалтгаалж эдийн засгийн хөгжил тодорхойлогддог. Гэхдээ эрх зүйг эдийн засагтай холбохдоо материйн гадаад бүрхэвч мэт ойлгож болохгүй. Өөрөөр хэлбэл вино аягалсан стакан гэж ойлгож болохгүй. Харин эрх зүй нь нийгмийн материаллаг амьдралын үзэл сэтгэлгээнд логик шалтгаалсан элемент юм. Эдийн засгийг эрх зүй буюу хэлбэрээс шалтгаалах хоёрдогч элемент гэж үзжээ. Иймд материаллаг эдийн засгийн харилцаа эрх зүйг тодорхойлохгүй, харин эрх зүй эдийн засгийн харилцааг тодорхойлно. Эрх зүй материаллаг харилцааг тодорхойлдог учраас эдийн засгийн өмнө хариуцлага хүлээх ёстой гэж үзжээ.

Эрх зүй  Эдийн засаг

Ийнхүү Р. Штаммлер: “хүмүүсийн нийгмийн амьдралын зүй тогтол бол эрх зүйн хөгжлийн зүй тогтол”⁴⁵ хэмээн үзэж, эрх зүйн хөгжлөөс нийгмийн хөгжлийн зүй тогтол шалтгаална гэж эрх зүйн нийгэмд гүйцэтгэх үүргийг тодорхойлж өгсөн байна.

Шинэкантач эрх зүйн философи, шинэчлэгдсэн позитивизм, юснатурализм нь эрх зүйн танин мэдэхүйн хувьд зарчмын өөр ялгаатай ч, шинэкантач эрх зүйн философийн байгаа болон байх ёстойг сөргүүлэн тавьсан үзэл санаа нь Герман, Австрид шинэчлэгдсэн позитивизм үүсч, жам ёсны эрхийн онол сэргэн мандахад таатай нөхцөлийг бүрдүүлсэн юм. Цаашилбал, шинэкантач эрх зүйн философи нь хууль зүйн шинжлэх ухааныг формализмаас ангижруулж, эрх зүйн сэтгэлгээнд үнэт зүйлийн онол хөгжих үндсийг бүрдүүлжээ.

44 Марксист эрх зүйн философи нь эрх зүйг эдийн засгийн суурийн шалтгаан биш, үр дагавар, эдийн засгаас шалтгаалж эрх зүй үүсдэг гэж үздэг.

45 Штаммлер Р. Хозяйство и право с точки зрения материалистического понимания истории. СПб. 1899. стр-169

4. ЦЭВЭР ЭРХ ЗҮЙН ОНОЛ

XX зуунд шинкантч эрх зүйн философийг хөгжүүлсэн гол төлөөлөгч бол Австрийн хуульч, философич Ханс Кельзен /1881-1973/. Х.Кельзен “Цэвэр эрх зүйн онол”-ыг үндэслэгч юм.

Х.Кельзен XIX-XX зууны эрх зүй судлалын уламжлалт сэтгэлгээг шүүмжлэн, өөрийн цэвэр эрх зүйн онолыг сөргүүлэн тавьж, “эрх зүй ямар байх ёстой вэ?, хэрхэн бий болох вэ? гэсэн асуултад хариу өгддөггүй, харин эрх зүй гэж юу вэ?, эрх зүй ямар байна вэ? гэсэн асуултад хариулт өгөхийг оролдсон.

Х.Кельзен нь Рудольф Карнапын удирдаж байсан неопозитивизм буюу логикийн позитивизмын Венийн дугуйланд хамрагдаж байсан тул түүний эрх зүй судлалын судалгааны арга зүйн үндэс нь логикийн позитивизм ⁴⁶ болно.

Цэвэр эрх зүйн онол нь норматив эрх зүй судлалын онол юм. Х.Кельзен нь ёс зүйн үнэлэмжийн асуудлыг бус, логик бүтэц бүхий цэвэр эрх зүйн байх ёстой зүйлийг л судалдаг. Тийм учраас “аргачлалын цэвэр ариун чанар” нь хамгийн дээд постулат юм. Иймд “Цэвэр эрх зүйн онол”-ын эхэнд нь: “Цэвэр эрх зүйн онол гэж нэрлэсэний учир нь гагцхүү эрх зүйд чиглэсэн танин мэдэхүйг баталгаажуулж, эрх зүйд үл хамаарах бусад бүх зүйлийг уг танин мэдэхүйгээс шахаж гаргахад оршино. Энэ нь юу гэсэн үг вэ? гэвэл эрх зүйн шинжлэх ухааныг түүнд үл хамаарах бүх элементээс чөлөөлөх явдал юм” гэжээ⁴⁷. Кельзен үүнд сэтгэл зүй, нийгэм судлал, ёс зүй, улс төрийн онолыг хамааруулжээ⁴⁸. Өөрөөр хэлбэл, эрх зүй цэвэр байна гэдэг нь:

Үзэл суртлаас ангид байх

Нам, улс төрөөс ангид байх

Нийгмийн үзэгдлүүдээс ангид байх

⁴⁶ Логикийн позитивизм нь логикийн үндсэн дээр нотлож болох зүйл л учир утгатай ба ойлгох боломжтой гэж үздэг бөгөөд энэхүү санаа нь өнөө үед аналитик философид оршин байдаг юм. Иймд үнэлэмж, хэм хэмжээний тухай метафизик шинж чанартай тодорхойлолтуудыг ямарч утгагүй гэж үздэг. Үнэлгээ өгөх нь зөвхөн сэтгэлгээний илэрхийлэл гэж үздэг болно.

⁴⁷ Ханнс - Зайделийн сан. “Эрэгцүүлэл” сэтгүүл. УБ. 2000 оны 12 сар. Др.др. проф. Артур Кауфман. “Эрх зүйн философийн мөн чанар, зорилго ба системчилсэн байр суурь”. 139-р тал

⁴⁸ H.Kelsen, *Reine Rechtslehre*, 1 Aufl. 1934, S. 1 (hier wird noch die Biologie genannt); 2. Aufl. 1960 (Neudruck 1976), S. 1.



Х.Кельзен шинжлэх ухааны эсрэг үзэл суртлыг сэргүүлэн тавьж, эрх зүйн онол нь ямарч үзэл суртлаас ангид, чөлөөтэй байгаа үед шинжлэх ухаан гэсэн өөрийн утгаараа байж болох юм. Түүний үзлээр эрх зүйн мөн чанар, шударга ёс, үнэт зүйл гэдэг нь метафизик асуудалд хамаарагдах бөгөөд эдгээр асуудлыг эрх зүйн онол нь авч үзвэл шинжлэх ухаанч шинж чанараа алдаж, үзэл сурталч субъектив шинжтэй болох ажээ. Мөн эрх зүйг үзэл суртал, нам ангиас гадуур байхын зэрэгцээ нийгмийн ахуйгаас, өөрөөр хэлбэл нийгмийн үзэгдлүүдээс ангид, өөрөө өөртөө хөгжих тогтолцоо хэмээн үзсэн.

Х.Кельзены үзлээр, харилцан холбоо хамаарал бүхий үзэгдлүүдийн хоорондын холбоо нь хэм хэмжээний дэг журамд нийгмийн ахуйгаас ангид “байх ёстой” формаль-логик категорийн үндсэнд бий болдог байна. Х.Кельзены “байх ёстой зүйл”-ийн тухай онолыг Германы эрдэмтэн Артур Кауфман “Rechtsphilosophie” бүтээлдээ тодорхойлон авч үзэхдээ⁴⁹: “Шударга бус байдал бий боллоо гэхэд түүний үр дагавар мөн “бий болох” ёстой. Энэхүү “бий болох” нь эрх зүйн категорийн хувьд эрх зүйн нөхцөл ба эрх зүйн үр дагавар хоёрыг нэгтгэсэн тусгай утга л юм. Эрх зүйн энэхүү категори нь зөвхөн хэлбэр төдий шинж чанартай бөгөөд үүгээрээ эрх зүйн гаднах үзэл санаанаас зарчмын ялгаатай байдаг юм. Ийм байдлаар холбогдсон хэрэг явдлын агуулга ямар байх, эрх зүй хэмээн үзэх актууд нь ямар шинж чанартай байхаас үл хамааран түүнийг хэрэглэх л болно... Тэр нь (цэвэр эрх зүйн онол нь) тодорхой нөхцөл байдалд холбогдсон үр дагаварт төрийн цээрлэл болох эрүүгийн болон иргэний ба засаг захиргааны шийтгэл оногдуулахыг хүлээн зөвшөөрч байгаа боловч нөхцөлдүүлж буй үйл явдлыг нь буруу үйл явдал, харин нөхцөлдсөнийг нь буруу үйл явдлын үр дагавар гэж ангилдаг юм. Аливаа зүйлд агуулагдаж буй шинж чанар, эрх зүйн хэм хэмжээний хоорондын аливаа харилцаа холбоо, ёс суртахууны, өөрөөр хэлбэл позитив эрх зүйн гадна орших үнэлэмжтэй холбогдсон харилцаанаас үүдэж хүмүүсийн тодорхой үйл ажиллагаа, үйлдлийг хууль бус хэмээн үздэг юм биш. Гагцхүү позитив эрх зүйн байгууламж /тогтолцоо/ ийнхүү үйлдэлд цээрлүүлэх хариулт өгөх тухай үр дагаврыг эрх зүйн хэм хэмжээний нөхцөл болгож тавьсан тохиолдолд л түүнийг хууль бус үйл ажиллагаа, гэмт үйлдэл хэмээн үзнэ⁵⁰. “Байх ёстой” гэсэн ойлголт нь аргачлалын аргыг зөрчин ил тод факт баримт болох төрийн цээрлэлд чиглэгдэж байгаа нь тодорхой байна. Түүнчлэн “цэвэр” хэмээгдэж буй “байх ёстой зүйл” нь агуулгагүй учир ямар ч агуулгыг багтаах боломжтой нь мөн тодорхой байна. Кельзен энэхүү үр дагаврыг ойлгож: “Хэм хэмжээ нь утга учиргүй агуулгатай байж болно”⁵¹ гэжээ. Хоёр дахь нийтлэлдээ ч тэрбээр: “Ямар ч агуулга

49 Ханнс - Зайделийн сан. “Эрэгцүүлэл” сэтгүүл. УБ. 2000 оны 12 сар. Др.др. проф. Артур Кауфман.

“Эрх зүйн философийн мөн чанар, зорилго ба системчилсэн байр суурь”. 139-р талыг үзнэ үү.

50 H.Kelsen, *Reine Rechtslehre*, 1 Aufl. 1934, S. 24ff.

51 H.Kelsen, *Reine Rechtslehre*, 1 Aufl. 1934, S. 201.

зөв байж болно”⁵² гэсэн байдаг. Хермани Кленнер Х.Кельзены онолыг “Rechtsleere” /эрх зүйн хоосон зүйл/ гэж хошигнон нэрлэсэн нь огт үндэслэлгүй зүйл бас биш юм.

Х.Кельзен сүүлдээ эрх зүйн хэм хэмжээний хүчин төгөлдөр байх тухай онолоо өөрчилсөн юм⁵³. Тэрбээр эрх зүйн хэм хэмжээг байж болох шийдэл, шалтгаан үр дагаврын холбоос хэмээн үзэж, түүнийгээ хариуцлага хүлээлгэх хэмээн нэрлэжээ. Үүнийхээ дагуу бол эрх зүйн хэм хэмжээ нь төрийн байгууллагуудаас ирээдүйд үйлдэх үйл ажиллагаа мөн бөгөөд тэр нь аливаа этгээд хэм хэмжээнд заасан үйлдлийг хийсэн тохиолдолд төрийн тодорхой байгууллага түүний эсрэг тийм арга хэмжээ авна гэсэн утгатай юм. Гэвч ийнхүү утга нь алиныг хүртэл зөв байж болохуйц зүйл, өөрөөр хэлбэл жинхэнэ “байх ёстой зүйл”-ийг үндэслэж чадах юм бэ? Энэ нь төрийн байгууллага нь өөрийнхөө эрх хэмжээний дагуу ногдуулж болох шийтгэлийг ногдуулаагүй нөхцөлд өөр ямар нэгэн шийтгэл ногдуулах тухай үүрэг хүлээлгэсэн тохиолдолд боломжтой болох юм. Харин ингэснээр эрх зүйн үүрэг хариуцлага нь иймэрхүү хүчирхийллийн нөхцөлдсөн үйлдлийн regressus in infinitum-д уусч алга болох ёстой нь илхэн харагдаж байна. Хяналтын байгууллагын дараалал нь эцэс төгсгөлгүй байж болохгүй учир Кельзен аливаа зөрчлөөс ангид, утга төгөлдөр бүхий байгууламжийн тухай таамаглалыг “Үндсэн хэм хэмжээ” хэмээн тунхаглахад хүрч, түүнийгээ “жам ёсны эрх зүйн хэм хэмжээтэй нэгэн адил”⁵⁴ үйлчилдэг гэжээ. Тэрбээр “Утга төгөлдөр буюу зөрчилгүй байгууламжийн тухай постулатад үндэслэсэн эрх зүйн шинжлэх ухаан нь цэвэр позитивизмын хил хязгаарыг гэтлэн давж буй юм. Энэхүү постулатаас татгалзвал энэ нь түүний мөхөл болох билээ” гэжээ. Энэ нь “эрх зүйг танин мэдэх” боломжтой болгодог “метафизикийн (жам ёсны эрх зүйн) минимумын тухай зүйл юм”⁵⁵. Кельзены “байх ёстой зүйл” нь эцсийн эцэст ёс зүйн л категори юм⁵⁶ хэмээн үзсэн Артур Кауфманы үзэлтэй санал нийлж байгаа болно.

Кельзены үзлээр “эрх зүй нь “Үндсэн хэм хэмжээ”-ний тусламжтайгаар шаталсан логик бүтэц бүхий нэгдмэл тогтолцоонд оршиж байдаг”. Өөрөөр хэлбэл, эрх зүйн нэгдмэл, шаталсан тогтолцоотой байх үндэс нь хүн төрөлхтний оюун санаагаар үнэн болох нь нотлогдсон “Үндсэн хэм хэмжээ” / Grundnorm, Basic Norm / юм.

52 H.Kelsen, *Reine Rechtslehre*, 2 Aufl. 1960, Neudruck 1976, S. 201.

53 H.Kelsen, *Reine Rechtslehre*, 2 Aufl. 1960, Neudruck 1976, S. 9ff.

54 H. Kelsen, *Die philosophischen Grundlagen der Naturrechtslehre und des Rechtspositivismus*, 1928, S.20

55 H. Kelsen, *Fn.12*, S.66.

56 Ханнс - Зайделийн сан. “Эрэгцүүлэл” сэтгүүл. УБ. 2000 оны 12 сар. Др.др. проф. Артур Кауфман.

“Эрх зүйн философийн мөн чанар, зорилго ба системчилсэн байр суурь”. 140-р тал



“Үндсэн хэм хэмжээ” нь үнэт зүйлийн буюу ёс зүй, улс төрийн болон социологийн үүрэггүй, харин танин мэдэхүйн онолын үүрэгтэй бөгөөд норматив дэг журмын бодит үндэслэлийг бий болгодог байна. Иймд “Үндсэн хэм хэмжээ” нь жам ёсны эрх биш юм. Өөрөөр хэлбэл, “Үндсэн хэм хэмжээ” нь эрх зүйн бүхий л хэм хэмжээний нэгдмэл байх нөхцөл бүхий танин мэдэхүйн трансценденталь категори болно.

Эрх зүй нь логик холбоо хамаарал бүхий нэгдмэл шаталсан тогтолцоонд оршдог гэж Х.Кельзен үзсэнээр анх удаа парламент хариуцлага хүлээх асуудлыг хөндөж тавьсан.

Х.Кельзен хэдийгээр Үндсэн хуульд тулгуурлан бусад эрх зүйн актууд тогтоогдох асуудлыг авч үзсэн боловч эрх зүйг бүтээх, эрх зүйг хэрэглэх гэсэн хууль зүйн хоёр нэр томъёог ялгаж зааглан авч үзээгүй юм. Энэ үндсэнд тэрээр “Үндсэн хэм хэмжээг тогтооно гэдэг нь Үндсэн хуулийг хэрэглэж буй хэрэг юм. Үүний нэгэн адил шүүх ерөнхий хэм хэмжээг хэрэглэнэ гэдэг нь эрх зүйн хэм хэмжээг тогтоож буй хэрэг” гэж эрх зүйн хэм хэмжээний тогтолцоог эрх зүйн дэг журамтай адилтган авч үзэж байгаа нь эрдэмтэн судлаачдын зүгээс шүүмжлэгдэх үндэс болдог.

Нөгөө талаар Х.Кельзен шүүхийн шийдвэрийг тунхагийн шинжгүй, бүтээх шинжтэй хэмээн үзсэн. Шүүх нь хэм хэмжээг бүтээх явцдаа /шүүн таслах үйл ажиллагааны явцад/ түүний удирдлага болгож буй ерөнхий хэм хэмжээ нь тухайн эрх зүйн дэг журамтай нийцэж байна уу?, Үндсэн хуулийн /үндсэн хэм хэмжээний/ шинжтэй байж чадаж байна уу? гэдгийг шийдвэрлэх ёстой. Нөгөө талаар шүүх нь /дээд шатны шүүх/ хууль тогтоогчтой өрсөлдөж ерөнхий хэм хэмжээг /прецедент/ тогтоож болно гэжээ. Түүний үзлээр шүүх нь эрх зүйг боловсронгуй болгож, бүтээхэд идэвхитэй оролцож, хууль тогтоогчтой өрсөлддөг. Ийнхүү түүний үзлээр, эрх зүй нь байнгын хөдөлгөөнд байж, ерөнхийгөөс нэгж рүү, хийсвэрээс бодит байдал руу, энгийнээс нарийн руу хөгждөг байна.

Х.Кельзены үзлээр “эрх зүй нь хүмүүсийн зан үйлийн хэм хэмжээг зохицуулах систем буюу хүмүүсийн харилцааны хэм хэмжээний /норматив/ дэг журам юм.

Дээрхи үндэслэлээр эрх зүйн шинжлэх ухааныг норматив шинжлэх ухаан хэмээн үзэж, эрх зүйг норматив аргаар⁵⁷ судална гэжээ. Х.Кельзены үзлээр эрх зүй нь өөрөө эрх зүйн норматив ойлголтыг тодорхойлохгүй, харин норматив арга байх ёстой зохистой хэм хэмжээний хүрээнд эрх зүйн ойлголтыг тодорхойлох аж.

Мөн Кельзен төрийг захирах захирагдах харилцааны систем гэж үзэж байсан ч, төр бол хүмүүсийн харилцааны албадлагын, норматив дэг журам буюу харьцангуй төвлөрсөн эрх зүйн дэг журам⁵⁸ хэмээн эрх зүйтэй адилтган үзэж байв. Түүний төрийг эрх зүйн дэг журмын биелэл хэмээн үзсэн үзэл нь эрх зүйт төрийн үзэл санааг хөгжүүлсэн төдийгүй орчин үеийн төрийн ойлголтын үндсийг тавьсан гавьяатай юм.

“Цэвэр эрх зүйн онол” нь эрх зүйн тогтолцооны үндэс, түүний арга зүйн асуудлыг гаргаж тавьсан сайн талтай ч шүүмжлэлд нилээд өртдөг. Тухайлбал, Штаммлер, Шелер, Сменд нар түүний үзэл санааны эсрэг “Эрх зүйг цэврээр нь авч үзэх нь чухал бус, харин зөв авч үзэх нь чухал” гэж үзжээ.

Хяналтын асуулт:

1. Шинэкантч эрх зүйн философийн эрх зүйг судладаг онол- арга зүйн үндэс, онцлогийг тайлбарлана уу?
2. Шинэкантч эрх зүйн философийн Бадены чиг хандлага эрх зүйн зорилгыг хэрхэн үздэг вэ? Яагаад?
3. Эрх зүйт болон эрх зүйн бус хуулийн ялгааг тайлбарлана уу?
4. Шинэкантч эрх зүйн философийн Маргбургийн чиг хандлага позитив эрхийн үндсийг хэрхэн үздэг вэ? Яагаад?
5. Шинэкантч эрх зүйн философи болон жам ёсны эрхийн онолын онол- арга зүйн ялгааг тайлбарлана уу?
6. Шинэкантч эрх зүйн философи нь эрх зүй, эдийн засгийн хамаарлыг хэрхэн үздэг вэ? Энэхүү үзэл нь марксист философоос ямар ялгаатай вэ?
7. Эрх зүй эдийн засгийн өмнө хариуцлага хүлээх үү? Үүнийг онол- практикийн үүднээс тайлбарлана уу?
8. Норматив арга гэж ямар аргыг хэлэх вэ?
9. Цэвэр эрх зүйн онол эрх зүйн тогтолцооны үндсийг хэрхэн үздэг вэ?
10. Үндсэн хэмжээний ойлголтыг тайлбарлана уу?
11. Г. Кельзен яагаад парламент хариуцлага хүлээх ёстой гэж үзсэн вэ?

⁵⁷ Норматив арга гэдэг нь тодорхой үнэлэмжийн үүднээс байх ёстой зохистой хэм хэмжээг тодорхойлж, түүнтэй жиших замаар бодит байдалд шинжлэх ухааны үнэлэлт дүгнэлт өгөх арга юм.

⁵⁸ Чистое учение о праве Ганса Кельзена. Вып. 2. стр 110- 116



Ном зүй:

1. “Liberty” цуврал сэтгүүл. '1, 2
2. Сэлэнгэ. Х.Шинэкантч эрх зүйн философи. Философи шашин судлал. УБ.2004
3. Сэлэнгэ. Х.Цэвэр эрх зүйн онол. “Эрх зүй” сэтгүүл. УБ.2010. 1-2/2010(18-19)
4. Нерсесянц.В.С.Философия права.М., 1997.
5. Нерсесянц.В.С.История политических и правовых учений.М., 1996.
6. Тихонравов.Ю.В.Основы философии права.М., 1997.
7. Хеффе.О.Политика, право, схаведливость.М., 1994.
8. Шершеневич.Г.Ф.Общая теория права.т-1, 2.М., 1995.
9. Kaufmann.A. Rechtsphilosophie.1997
10. Gustav Radbrukh- Rechtsphilosophie. Studienausgabe by Stanley L. Paulson and Ralf Dreier (Jan 14, 1999)
11. Lehrbuch Der Rechtsphilosophie (German Edition) by Rudolf Stammler (Jan 1, 1923)
12. The theory of justice by Rudolf Stammler (1969)
13. Rechts- Und Staatstheorien Der Neuzeit: Leits Tze Zu Vorlesungen (German Edition) by Rudolf Stammler (Jan 1, 1925)
14. The Theory of Justice (Modern Legal Philosophy Series) by Rudolf Stammler (Jan 10, 2000)
15. Pure Theory of law by Hans Kelsen (Jun 30, 2009)
16. General Theory of law and State by Hans Kelsen (Jul 15, 2007)
17. General Theory of Norms by Hans Kelsen and Michael Hartney (May 9, 1991)

IX бүлэг Позитив эрх зүйн философи

Зорилго: Эрх зүйн бодит байдал, түүний үүрэг болон эрх зүйн хэм хэмжээний бүтэц, тогтолцоог хууль зүйн позитивизмын онол- арга зүйн үүднээс ойлгож танин мэдэх

1. ПОЗИТИВ ЭРХ ЗҮЙН ФИЛОСОФИЙН ГҮН УХААНЫ ҮНДЭС

Гүн ухааны хөгжлийн явцад XIX зууны эхэн үед позитив философи үүсч хөгжсөн бөгөөд шинэчлэгдсэн позитив философийн хөгжлийн үр дүнд позитив эрх зүйн философи үүсч хөгжсөн юм.

Позитивизм хууль зүйн шинжлэх ухаанд хоёр чиг хандлагаар хөгжиж байна. Үүнд:

Хууль зүйн позитивизм

Прагматик позитивизм

Хууль зүйн позитивизм нь эрх зүйг нийгмийн үзэгдлүүдээс ангид авч үзэж судалдаг бол прагматик позитивизм нь эрх зүйг нийгмийн үзэгдлүүдтэй холбож үздэгээрээ ялгаатай юм. Нөгөө талаар прагматик позитивизм нь реалист онолын чиглэлээр хөгжсөн тул энэ сэдвийн хүрээнд яригдахгүй болно.

Хууль зүйн позитивизм нь шинэчлэгдсэн позитив философийн чиг хандлага учраас гүн ухааны үндэс нь логикийн позитивизм юм. Мөн позитив философийн арга зүйн нэгэн адил юмсын мөн чанарыг танин мэдэх боломжгүй тул гагцхүү үзэгдлүүдийг судална гэж үздэг.

Позитив эрх зүйн философиин арга зүйн онцлог:

Гүн ухааны үндэс нь логикийн позитивизм

Формализмд үндэслэгддэг

Юмс үзэгдлийн мөн чанарыг танин мэдэх боломжгүй

Эрх зүй ямар байна вэ? гэдгийг судалдаг



2. ХУУЛЬ ЗҮЙН ПОЗИТИВИЗМ

МЭӨ V зуунаас олон зуун жил эрх зүйн сэтгэлгээнд ноёрхож ирсэн жам ёсны эрхийн онолыг хямралд оруулж, XIX зууны II хагаст эрх зүйн сэтгэлгээнд өөрчлөлт оруулсан онол бол хууль зүйн позитивизм юм.

Хууль зүйн позитивизмын гол төлөөлөгчид нь Английн Д.Остин, түүний сургаалийг баримтлагчид /Аналитик хууль зүйн шинжлэх ухааны төлөөлөгчид/, Германы К.Бергбом, П.Лабанд, Францын А.Эсмен, Оросын Г.В.Шершеневич юм.

Хууль зүйн позитивизм нь жам ёсны эрхийн эсрэг онол бөгөөд жам ёсны эрхийн талаархи тэдний үзэл санааг хоёр хувааж болохоор байна. Үүнд:

1. Жам ёсны эрхийн үзэл санааг баримтлагчид нь үйлчилж буй позитив эрхэд ёс суртахууны үнэлэмжийн үүднээс ханддаг, субъектив “хоосон, үл гүйцэлдэх санаа” хэмээн эрс үгүйсгэдэг

2. Жам ёсны эрх нь субъектив эрхээр солигдиж, жам ёсны эрх, позитив эрх нь нийлж нэгдсэн тул позитив эрхээс өөр эрхийн тухай ярих шаардлагагүй

Хууль зүйн позитивизм нь жам ёсны эрхийн онолын “эрх зүй ямар байх ёстой вэ?” гэсэн байх ёстой зүйлийн хүрээнд судлах арга зүйн асуудлыг шүүмжлэн “ямар байх ёстой вэ?” гэдэг бол “эрх зүй биш”, харин утопи санаа юм. Нөгөө талаар эрх зүйд зөв, шударга буюу буруу, шударга бус гэсэн ёс суртахуун, шашин, зан заншлын үүднээс өгөх субъектив үнэлэлт дүгнэлт нь эрх зүйн агуулгад огт хамааралгүй. Учир нь эрх зүй нь нийгмийн үзэгдлүүдээс хамааралгүй, агуулгаасаа ангид орших, гагцхүү өөрөө өөртөө үндэслэлээ олох цэвэр логик хэлбэр хэмээн үзэж, жам ёсны эрхийн онолыг үгүйсгэж байв⁵⁹. Иймд хууль зүйн позитивизм нь зөвхөн эрх зүйн үзэгдлүүдийг л судлана хэмээн үзсэн. Хууль зүйн позитивизмын энэхүү үзэл санааг агностизм руу хальтирсан үзэл санаа хэмээн марксист философи шүүмжилж байв.

Хууль зүйн позитивизм яагаад эрх зүйн агуулгыг бус, хэлбэрийн асуудлыг судалгааны гол асуудал болгож гаргаж тавив?

Нэгдүгээрт, хууль зүйн позитивизмын арга зүйн асуудалтай шууд холбоотой.

Хоёрдугаарт, эрх зүйн мөн чанар, агуулга, зарчим гэсэн хийсвэр танин мэдэхүйн

⁵⁹ Хууль зүйн позитивизмыг баримтлагчдын үзэл санаанд анализ хийж үзвэл: жам ёсны эрхийн талаар тэдний үзэл санаа хоёр хуваагдаж байна. Нэг хэсэг нь жам ёсны эрхийг эрс үгүйсгэж, хоосон санаа, хууль зүйн шинжлэх ухаанаас авч хаях хэрэгтэй гэж үзэж байгаа бол нөгөө хэсэг нь жам ёсны эрх нь субъектив эрхээр солигдсон тул позитив эрхээс өөр ямар нэгэн төгс эрхийн тухай ярих шаардлагагүй хэмээн үзсэн байна.

үүднээс бодит төр, эрх зүйн объектив мөн чанарыг тодорхойлох боломжгүй гэж үзсэн байна.

Иймд хууль зүйн позитивизм нь эрх зүйг хууль тогтоогчийн хүсэл зоригийн үр дүн, албадлагын хэм хэмжээ хэмээн үзэж, хууль эрх зүйг адилтгадаг. Энэ үндсэнд бүх хууль, захиргааны акт, шүүхийн шийдвэр буюу төрийн засаглалын бүх актуудыг эрх зүй хэмээн ойлгодог юм.

Хууль болон бусад актууд нь төрөөс хамгаалагдаж, төрийн албадлагаар хангагдаж, нийгэмд албадлагын журмыг бүрдүүлж байдаг. Энэхүү албадлагын журмыг зөрчвөл хууль зүйн хариуцлага оногдуулдаг. Иймд хууль зүйн позитивизм нь **“эрх зүй гэдэг нь бүх нийтээр заавал биелүүлэх, албадлагын хүчээр хангагдсан, албан ёсны хуулийн хэлбэрээр нийтлэгдсэн хэм хэмжээ”** гэж тодорхойлдог байна. Дээрхээс үндэслэн хууль зүйн позитивизм нь хуулиас гадуурхи эрх зүйн тухай асуудлыг авч үздэггүй юм.

Хууль зүйн позитивизмын гол төлөөлөгч Д.Остин: “Эрх зүй нь төрийн эрх баригчийн тогтоосон дүрэм журмын цогц, Аливаа эрх зүй гэдэг нь тушаал, команд”⁶⁰ гэсэн бол, К.Бергбом: “Эрх зүйн ойлголт нь хаана ч, хэзээ ч цэвэр формаль шинжтэй”⁶¹ гэжээ. Мөн Оросын хууль зүйн позитивизмыг баримтлагч Г.Ф. Шершеневич: “Эрх зүйн аливаа хэм хэмжээ бол тушаал мөн”⁶² гэснээр төрийн засаглал нь хэм хэмжээг тогтоосноор эрх зүй бий болдог, эрх зүйг төрийн бүтээгдэхүүн гэж үздэг байна. Төр нь эрх зүйг бүтээгч, эрх зүйн уг сурвалж төдийгүй түүх, логикийн үүднээс эрх зүйн өмнө байдаг гэж үзсэн. Ийнхүү хууль зүйн позитивизм нь төрөөс тогтоосон бүхий л актуудыг эрх зүй хэмээн үздэг.

Төр эрх зүй нь нийгмийн сууриас шалтгаална хэмээн үздэг марксист философийг шүүмжлэн “хууль нийгмийн амьдралын шаардлагаас шалтгаалан үүсээгүй, харин нийгмийн тодорхой харилцаа бодит хуулиас шалтгаалан үүсдэг” /Г.Ф.Шершеневич/ гэжээ. Мөн субъектив эрхийг төрөөс хуулийг тогтоосноор хууль ёсны эрх үүрэг бий болдог учир үүсмэл хэмээн үзэж түүний ач холбогдлыг үл хэрэгсдэг байна.

Ийнхүү эрх зүй хуулийг адилтгаж үздэг учраас хууль эрх зүйн үзэгдэл болохыг үгүйсгэдэг бөгөөд хууль нь эрх зүйн илрэх хэлбэр биш, харин хууль эрх зүйг бий болгодог гэж үздэг⁶³.

60 Austin.Lectures on Jurisprudence or the Philosophy of Positive Law. L.,1873.P.89,98.

61 Под. ред. В.С. Нерсисянца. История политических и правовых учений.М.1988.стр.573

62 Г.Ф. Шершеневич. Общая теория права. М.1910.вып.1.стр.281.

63 Хууль зүйн шинжлэх ухаанд эрх зүйн эх сурвалжийг формаль утгаар, материаллаг утгаар гэж 2 ангилдаг. Формаль эх сурвалжид эрх зүйн илрэх хэлбэрийг авч үздэг бол материаллаг эх сурвалжид хүний мөн чанар, оюун санаа, нийгэм гэсэн эрх зүйг бий болгож буй эх сурвалжийг ойлгодог.Харин хууль зүйн позитивизмын хувьд хууль нь материаллаг утгаар эрх зүйн эх сурвалж болдог.



Хууль зүйн позитивизм нь хуулийн ноёрхол, хууль тогтоогчийн хязгааргүй боломжийг бий болгосноор хууль тогтоогч нь өөрийн үзэмжээр ямарч эрх зүйг бүтээх боломжтой юм. Эрх зүйг хууль тогтоогчийн хүсэл зоригийн бүтээгдэхүүн гэж үздэг учраас эрх зүйн мөн чанар, шинж нь албадлага бөгөөд энэхүү албадлагын шинжээрээ нийгмийн бусад хэм хэмжээнээс ялгаатай хэмээн үздэг. Хууль зүйн позитивизм нь албадлагыг эрх зүйн шаардлага, объектив шинжийн үр дагавар бус, харин эрх зүйг бий болгодог, эрх зүйг тодорхойлдог фактор /хүчин зүйл/ гэж үзсэн.

Эрх зүйн үнэний тухайд хуульд заасан бол үнэн шударга гэж үзсэн бөгөөд энэ тохиолдолд эрх зүй, дур зоргын ялгаа байхгүй бөгөөд хууль зүйн позитивизмын хувьд эдгээрийн ялгааг гаргах боломжгүй юм.

Хууль зүйн позитивизмын танин мэдэхүйн онолын ашиг сонирхол нь позитив эрхэд төвлөрч байдаг учир позитив эрхийн хүрээнээс гарсан эрх зүйн мөн чанар, эрх зүйн санаа, эрх зүйн үнэт зүйлс гэх мэт эрх зүйн санаануудыг үгүйсгэдэг. Ийнхүү хууль зүйн позитивизмын танин мэдэхүй нь үндсэндээ эрх зүйн онолыг үгүйсгэж, гагцхүү хууль зүй судлал, хуулийн тухай сургаал байх ба хууль зүй судлалын судлагдахуун нь позитив эрх байна. Хууль зүй судлалын зорилго нь эрх зүйн догма /позитив эрхийн тухай үзэл санаа, чиг хандлага, позитив эрхийг судлах арга зүй, позитив эрхийн тухай тайлбар, ангилал, системчлэл г.м./ гэжээ.

Хууль зүйн позитивизмын хувьд үйлчилж буй эрх зүйг /хуулийг/ танин мэдэх гэдэг нь хуульд тусгагдаагүй шинэ мэдлэгийг олж авах, хуулийн мөн чанарыг танин мэдэх асуудал биш юм. Учир нь эрх зүйн тухай бүх мэдлэг нь позитив эрхэд, түүний текстэд байгаа учраас гагцхүү хуулийн текстийг зөв тайлбарлах явдал гэж үздэг байна. Үүнтэй уялдан хууль зүйн позитивизм лингвист философитой холбогддог юм.

Үнэт зүйлсийн хүрээнд хууль зүйн позитивизм нь эрх зүй, хууль хоёрыг адилтгадаг учир эрх зүйн үнэт зүйлсийг үгүйсгэж, хуулийн үнэт зүйлсийг л хүлээн зөвшөөрдөг. Ийнхүү хууль зүйн позитивизм нь эрх зүй, ёс суртахууныг ялган зааглаж, эрх зүйд хэт хийсвэр бус, бодитой хандах хандлагыг бий болгосон нь сайн талтай боловч, хууль зүйн шинжлэх ухаанд хэт хэлбэрдэх хандлагыг голлож, хууль тогтоогчийн дур зоргыг хүлээн зөвшөөрсөн нь хэлбэр агуулгаасаа гажих нөхцөлийг

бүрдүүлж байна. Иймд хууль зүйн позитивизмын “хууль бол хууль” гэсэн үзэл санааг шинэкантач эрх зүйн философийн гол төлөөлөгч Г.Радбрух: “Төрөөс тогтоогдсон хууль тогтоомжийг сохроор дагаж мөрдөх хуульчдыг бэлтгэж байна. Энэ нь тоталитар төрийг хүлээн зөвшөөрч, найр тавьсан явдал” гэж шүүмжилсэн.

3. Х.Л.А. Хартын шинэчлэгдсэн позитивизм

Хууль зүйн позитивизм нь хууль тогтоогчийн дур зоргыг хүлээн зөвшөөрч, хэт хэлбэрдсэн үзэл санааг илэрхийлж байсан. Иймд хууль зүйн позитивизмын алдааг засварлан, Х.Кельзений үзэл санааны нөлөөгөөр Х.Л.А.Харт шинэчлэгдсэн позитивизмын үзэл санааг гаргаж тавьсан. Түүний онол нь аналитик эрх зүй судлалын онол юм.

Х.Хартын онол нь хууль зүйн позитивизмд үндэслэгдсэн тул жам ёсны эрхийг шүүмжилж, “шударга бус эрх зүй бол эрх зүй биш, хууль бол эрх зүй биш гэсэн үзэл санаа бол сэтгэлгээний алдаа, төөрөгдөл” гэж үзсэн. Гэхдээ Х.Харт нь “хүний нийгмийн амьдралын зорилго нь амьд явах, амьдрах явдал гэж үзсэн. Хүний амьдралын зорилгоос үүдэж нийгмийн хэм хэмжээнүүд, ялангуяа эрх зүй, ёс суртахууны хэм хэмжээнүүд нь хүний зан үйлийн зохистой хэм хэмжээг агуулах ёстойг хүлээн зөвшөөрчээ. Энэхүү хүний амьд явах, өмчлөх эрхээ хамгаалах зэрэг зохистой хэм хэмжээ нь байх ёстой хэм хэмжээ юм.

Хүний амьдралын

зорилго нь


амьд явах, амьдрах

Х.Харт үзэхдээ: эрх зүй нь /позитив эрх зүй/ нь өөрийн бүтцээрээ анхдагч, хоёрдогч хэмээн ангилагдсан хэм хэмжээнүүдээс /норм/ бүрдэнэ гэжээ. Анхдагч эрх зүйн хэм хэмжээ нь үүргийн хэм хэмжээ юм. Үүргийн хэм хэмжээ нь субъектын хүсэл зоригийг харгалзахгүйгээр үүрэг биелүүлэхийг шаарддаг. Үүрэг болгосон анхдагч хэм хэмжээ нь хориглосон зан үйлийг гаргуулахгүй байх санаа зорилго бүхий цээрлүүлэх арга хэмжээ буюу албадлагатай холбоотой байна. Харин хоёрдогч хэм хэмжээ нь хувийн болон нийтийн эрх мэдлийг олгодог. Хувийн эрх мэдлийг олгож буй хэм хэмжээ нь субъектэд бусад субъекттэй эрх зүйн харилцаанд бие даан оролцох /гэрээ, гэрээслэл үйлдэх гэх мэт/ чадварыг эзэмшүүлдэг. Нийтийн эрх мэдэл олгож буй хэм хэмжээ нь удирдлага, шүүх, хууль тогтоох хүрээний үйл ажиллагааг тодорхойлж өгдөг байна. Хоёрдогч хэм хэмжээ нь субъектүүдэд тодорхой зан үйлийн ёс журмыг шаарддаггүй, харин зарим нэг субъектүүдэд тодорхой нөхцөлд эрх, үүргийг олгодог байна. Хэрвээ эрх зүйн тогтолцоо нь зөвхөн



анхдагч хэм хэмжээнээс бүрдвэл тодорхой бус, зогсонги, үр нөлөөгүй гэх мэт олон сул талтай байх ба энэхүү сул талуудыг дүрэм журмын дүрэм журам болж үйлчилдэг хоёрдогч хэм хэмжээний тусламжтайгаар даван туулах боломжтой гэж Х. Харт үзжээ. Анхдагч, хоёрдогч хэм хэмжээнүүдийн нэгдэл нь эрх зүйн тогтолцоог /эрх зүйг/ бүрдүүлнэ гэж үзсэн байна.

Х. Хартын үзлээр эрх зүйн тогтолцоо нь:



Х.Харт нь Х.Кельзений нөлөөгөөр эрх зүйн бодит байдал, хүч чадал нь хүний зан үйлийг тодорхойлох байх ёстой, зохистой хэм хэмжээнээс хамаарч, “хууль нь үндсэн хэм хэмжээнд үндэслэгдэнэ” хэмээн үзсэнээрээ хууль зүйн позитивизмыг засварлан шинэ шатанд гаргажээ.

Хяналтын асуулт:

1. Позитив эрх зүйн философийн арга зүйн үндсийг тайлбарлана уу?
2. Позитив эрх зүйн философи яагаад эрх зүйг байгаа зүйлийн хүрээнд судалдаг вэ?
3. Социологийн болон хууль зүйн позитивизмын арга зүйн ялгааг тайлбарлана уу?

4. Эрх зүйн бодит байдал, хүч чадлыг хууль зүйн позитивизмын онол-арга зүйн үүднээс тайлбарлана уу?
5. Хууль зүйн позитивизм жам ёсны эрх болон субъектив эрхийн хамаарлыг хэрхэн үздэг вэ?
6. Хууль зүйн позитивизм нийгэм болон эрх зүйн хамаарлыг хэрхэн үздэг вэ?
7. Шинэчлэгдсэн позитивизмын анхдагч болон хоёрдогч хэм хэмжээний ялгаа, тэдгээрийн харилцан хамаарлыг тайлбарлана уу?
8. Эрх зүйн агуулга ёс суртахуунаас ангид байх боломжтой юу?

Ном зүй:

1. Лүндэндорж. Н. Эрх зүйн сэтгэлгээний хөгжлийн чиг хандлага УБ.2003.
2. Лүндэндорж. Н. Jurisprudence. Эрх зүй судлал: философи, онол.УБ.2011.
3. Нарангэрэл. С. Монголын ба дэлхийн эрх зүйн тогтолцоо. УБ. 2001.
4. Сэлэнгэ Х. Хууль зүйн позитивизм: онол, арга зүйн асуудал. "Гэмт явдалтай тэмцэх асуудал" Цагдаагийн Академийн онол арга зүйн сэтгүүл 2008 № 2 (25)
5. Сэлэнгэ Х. Эрх зүйн танин мэдэхүй: онолын үндэслэл. "Эрх зүй" сэтгүүл, УБ, 2002, '8-9
6. Өнөрбаяр Ч. Хууль зүйн позитивизм
7. Hart H.L.A. Concept of law
8. Jeffrie G. Murphy and Jules L. Coleman. Philosophy of Law. USA. 1990.
9. Jules Coleman and Scott Shapiro. Jurisprudence and Philosophy of Law. Oxford. 2002.
10. Kaufmann.A. Rechtsphilosophie.1997
11. Legal Positivism (The International Library of Essays in law and legal Theory, Schools, No 7) by Mario Jori (Aug 1, 1992)
12. Legal Positivism in American Jurisprudence (Cambridge Studies in Philosophy and law) by Anthony J. Sebok (Mar 1, 2008)
13. Kaufmann.A. Rechtsphilosophie.1997.
14. The Philosophy of law (Oxford Readings in Philosophy) by Ronald M. Dworkin (Jan 6, 1977)
15. Нерсесянц,В.С.Философия права.М., 1997.



Х бүлэг

Эрх зүйн реалист онол

Зорилго: Эрх зүйн ойлголт, зорилго, хууль зүйн практик, түүний үр нөлөө, ач холбогдолыг реалист чиг хандлагын арга зүйн үүднээс танин мэдэх

1. ЭРХ ЗҮЙН РЕАЛИСТ ОНОЛЫН ҮҮСЭЛ, АРГА ЗҮЙН ҮНДЭС

ХIХ зууны II хагаст Германы хуульч, профессор Рудольф фон Иеринг нь (1818-1892 он) И.Бентамын эмперик утилитаризмын зарчимд тулгуурлан формаль чиг хандлага болон априор- метафизик эрх зүйн философийн эсрэг социологийн чиг хандлага бүхий өөрийн онолыг боловсруулж, түүнийгээ реалист онол гэж нэрлэсэнээр энэхүү онолын үндэс тавигдсан.

Р.Иеринг нь үзэхдээ: байгальд шалтгаангүй үр дагавар гэж үгүйн нэгэн адил нийгэмд зорилгогүй үйлдэл гэж байхгүй. Хүн зорилгод хүрэхийн тулд үйлдэл хийдэг. И.Бентамын эмперик утилитар зарчимд үндэслэн зорилго нь ашигтай, сайн үр дүнтэй байхад чиглэгддэг. Иймд хүний үйлдлийн үндэс нь ашиг сонирхол юм. Хүн өөрийн материаллаг болон материаллаг бус ашиг сонирхлыг хэрэгжүүлэх үүднээс нийгмийн янз бүрийн харилцаанд оролцдог.


Тодорхой бие хүний болон хэсэг бүлэг хүмүүсийн аминч үзлийн үүднээс нийгмийн эсрэг сөрөг үйлдэл хийвээс төр, эрх зүйн тусламжтайгаар албадлагыг хэрэглэнэ. Эрх зүй нь янз бүрийн ашиг сонирхолтой бүлэглэлүүдийн тэмцлийн үр дүн бөгөөд түүний үндэс нь материаллаг болон материаллаг бус ашиг сонирхол юм. Эрх зүйн зорилго нь энхтайван, түүнд хүрэх арга зам нь тэмцэл гэж үзжээ. Тэмцлийн үр дүнд л хүн өөрийн эрхийг олж авдаг гэжээ.

Ийнхүү хүч эрх зүйг бий болгодог, эрх зүй нь хуулиар хамгаалагдсан ашиг сонирхол буюу албадлагын хүчээр баталгаажсан нийгмийн зорилгын систем / хүчний бодлого/ хэмээн үзсэн байна.

Энэхүү онолыг Д.Грэй болон хэд хэдэн төлөөлөгчид үргэлжлүүлэн хөгжүүлсэн бөгөөд янз бүрийн чиг хандлагуудаас бүрдсэн хууль зүйн шинжлэх ухааны онолын чиг хандлага болж хөгжиж байна.

Реалист онолын нөлөөгөөр “эрх зүйн социологийн онол” үүсч хөгжсөн юм. Эрх зүйн реализм нь англо-саксоны эрх зүйн тогтолцоотой улс орнуудад хөгжихөөс гадна мөн баруун Европод скандиновын орнуудад (А.Хегерштрем, В.Лундштед, А.Росс г.м) хөгжсөн. Америкийн болон скандиновын реалистууд аль аль нь эрх зүйг формализмаас ангижруулах зорилготой гарч ирсэн. Гэхдээ реализм нь нэгдмэл системчлэгдсэн онол биш юм.

Эрх зүйн реалист онол нь Америкийн болон Скандиновын реализм гэсэн хоёр чиг хандлагаар хөгжиж байгаа ч, Америкийн реализм нь хууль зүйн шинжлэх ухааны онолын хөгжилд ихээхэн нөлөөтэй хөгжиж байна. Америкийн реализм нь дараах хоёр чиг хандлагад хуваагддаг юм. Үүнд:



Арга зүйн талаас нь авч үзвэл: Эрх зүйн реалист онол нь утилитаризм, прагматизм, плюрализмд үндэслэн эрх зүйг эмперик түвшинд судладаг.

Эрх зүйн реализмын танин мэдэхүйн үндэс нь У.Джеймс, Ж.Дьюи нарын прагматик философи, онолын үндэс нь Холмсын хууль зүйн прагматизм⁶⁴ гэж эрдэмтэд үздэг юм.

Реалист арга зүй нь шүүх, захиргааны практикийг үнэлэн, шинэчлэлт хийхэд чиглэгдэж байна.



⁶⁴ История политических и правовых учений XX в. М.1995. стр.257.



2. ЭРХ ЗҮЙН РЕАЛИСТ ОНОЛЫН АГУУЛГА

Эрх зүйн реалист онол нь шинэкантч эрх зүйн философи, хууль зүйн позитивизмын эсрэг гарч ирсэн онол юм. Энэхүү онолын зорилго нь эрх зүйг формализмаас ангижруулж, шүүхийн практикийн үр нөлөөг дээшлүүлж, хууль зүйн механизмыг бодитой хэрэгжүүлэхэд чиглэгддэг.

Дээрхи зорилгод тулгуурлан эрх зүйн позитив агуулгыг судлах нь чухал биш, харин түүний үйл ажиллагааг судлах нь чухал гэж үздэг.

Эрх зүйн реалист онолын агуулгын чиг хандлага нь:

- Эрх зүй гэж юу вэ?
- Эрх зүйн уг сурвалж нь юу вэ?
- Эрх зүйн үндэс юу вэ?
- Эрх зүйн үнэт зүйл нь юу вэ?
- Эрх зүйн бодит байдал, хүч чадал юунд оршино вэ?

Эрх зүйн реалист онолын агуулга:

- Эрх зүй бол зорилго биш, харин нийгмийн зорилгод хүрэх арга хэрэгсэл
- Нийгэм эрх зүйн тогтолцооноос түрүүлж хөгждөг тул нийгмийн өөрчлөлттэй эрх зүй тохирох шаардлагатай буюу байнгын хөдөлгөөнд байх ёстой
- Байгаа болон байх ёстойн хооронд ихээхэн ялгаа байдаг тул шүүх өөрийн үзэмжээр хэргийг шийдвэрлэх ёстой
- Эрх зүй шүүхээс тогтоогддог
- Эрх зүй, шударга ёсны тухай уламжлалт ойлголтонд бүрэн итгэх хэрэггүй
- Эрх зүйн үнэт зүйл нь хууль зүйн техникийн хөгжлөөс болон эрх зүйг хэрэглэх үйл ажиллагааны хэлбэрээс хамаарна

Эрх зүйн реалист онол нь Америкийн болон Скандиновын реализм гэсэн хоёр чиг хандлагаар хөгжиж байна.

Скандиновын чиг хандлага: эрх зүйн хэм хэмжээ, хариуцлага, хууль ёсны ойлголтын хүрээгээр судлагаагаа хязгаарладаг

Америкийн чиг хандлага: хууль зүйн механизмын бодит ажиллагаа, практик асуудалд анхаарлаа хандуулдаг.

3. АМЕРИКИЙН РЕАЛИЗМ

Америкийн реализм нь үзэхдээ байгаа болон байх ёстойн хооронд нилээн ялгаа байна. Нийгэм эрх зүйн тогтолцооноос түрүүлж хөгждөг тул нийгмийн өөрчлөлттэй эрх зүй нийцэж, тохирч байх шаардлага гарч байна. Гэтэл эрх зүйн хэм хэмжээ нь хоорондоо логик зөрчилтэй “зуурсан гурил, баримлын шавартай ижил” байхаас гадна “өнгөрсөн онд худалдаж авсан хүүхдийн өмдтэй адил” нийгмийн харилцаанаас хоцорч байна гэж позитив эрхийг шүүмжилж байв. Ялангуяа радикал реалистууд нь эрх зүй нь дүрэм, журмаас тогтохгүй хэмээн үзэж, хууль болон шүүхийн прецедентыг үгүйсгэж, эрх зүй бол шүүхийн эмперик шийдвэр гэж үзсэн. Учир нь хэрэг, маргаан бүр адилгүй, дахин давтагддаггүй, ялгаатай байдаг. Хууль буюу ерөнхий хэм хэмжээ тодорхой хэрэг, маргааныг шийдвэрлэхгүй. Шүүгч хэрэг шийдвэрлэх шийдвэрлэх бүрдээ эрх зүйг бүтээж байдаг гэснээр эрх зүйн норматив шинжийг үгүйсгэж байна. Нэгдмэл тогтоогдсон хэм хэмжээнд шүүхийн практик л ноёрхоно. ”Шүүгч хэзээ ч хууль хийж байгаагүй, хийх ч үгүй. Энэхүү хэм хэмжээ шүүхийн шийдвэрээс өмнө байдаг. Шүүх энэхүү урьд нь байсан хэм хэмжээг нээж олдог юм... Хэрвээ урьд нь тогтоогдсон хэм хэмжээ хожим тодорхой хэрэгт шүүхээр хэрэгсэхгүй болгогдож байвал энэхүү хэм хэмжээ нь зохион бүтээгдсэн болохоос бодит эрх зүй, амьд эрх зүй биш юм. Үүнээс үндэслэн урьдах хэм хэмжээ нь хэзээ ч оршин байгаагүй хэмээн үзэх ёстой”⁶⁵ гэж үзжээ. Ийнхүү эрх зүйг индивидуаль олон шийдвэр хэмээн үзэж, эрх зүйн хүрээнд ерөнхий ойлголт байхыг үгүйсгэдэг юм. Энэ нь нэгж ерөнхийн хамаарлыг үгүйсгэж байна.

Шүүгч аливаа хэрэг маргааныг шийдвэрлэхдээ хууль, дүрэм журамд үндэслэхгүй бол юунд үндэслэж хэрэг маргааныг шийдвэрлэх болж байна? гэсэн асуулт зүй ёсоор тавигдана. Үүнд реалистууд хариулахдаа “Шүүгч гэдэг бол хүн. Түүний үйл ажиллагаанд сэтгэл зүйн янз бүрийн элементүүд (сэтгэл хөдлөл гэх мэт) нөлөөлдөг. Иймд шүүгч интуици болон бусад нөлөөлөх хүчин зүйлийн үр дүнд иррациональ замаар шийдвэр гаргахдаа итгэл төрүүлэх аргументыг олох чадвартай байх нь хуульчийн урлаг⁶⁶” гэж үздэг.

Мөн эрх зүйд нийгэм-эдийн засгийн олон хүчин зүйл нөлөөлж байдаг учраас эрх зүй цэвэр байх боломжгүй төдийгүй, эрх зүйг хянах боломжгүй, урьдаас төсөөлөхийн аргагүй үзэгдэл хэмээн үздэг юм. Ийнхүү формализмын эсрэг тууштай тэмцэж, хууль зүйн позитивизмыг шүүмжлэж буй реалист үзэл санаа нь эрх зүйн норматив

65 Frank J. Courts on trial. Myth and reality in American justice. N.-Y., P.263.

66 История политических и правовых учений XX в. М.1995. стр.262.



шинж, эрх зүй нь тогтвортой, ерөнхий ойлголттой байх үзлийг илт үгүйсгэх төдийгүй эрх зүйг судлах явдлыг (хууль зүйн шинжлэх ухааныг шинжлэх ухаан биш хэмээн үздэг), цаашилбал эрх зүйг ч мөн үгүйсгэж скептизм, нигилизм руу хальтурсан байна. Үүнийг Америкийн эрх зүйн онолч Жерома Холла шүүмжлэхдээ “Эрх зүйн реализмын нормативизмаас ялгагдах гол онцлог нь хэт эмперик, сайхан бодит нөхцөлүүдийг энгийн зурагласан, хэт туйлширсан экстремист шинжтэй”⁶⁷ гэжээ.

Харин дундыг баримтлагчид нь (Ллевеллин, Гарлан, Патерсон) “шүүхийн прецедентыг өнгөрсөн үеийн тэмдэглэл” хэмээн үзэж болохгүй, шинэ харилцаанд нөлөөтэй бөгөөд харин норматив хэм хэмжээг шүүх анхаарч болох, эс бөгөөс эс анхаарч ч болох хүчин зүйл (фактор) хэмээн үзэж, эрх зүй нь формаль логик бүтэцтэй болохыг хүлээн зөвшөөрдөг юм. Гэхдээ эрх зүй нь хэм хэмжээний цуглуулга биш, харин шүүх захиргааны ажилтны хэрэг маргааныг шийдвэрлэсэн шийдвэр⁶⁸ хэмээн үздэг (Холмс) байна. Ийнхүү реалист онолын эдгээр чиглэлүүд нь эрх зүйн норматив үндэслэгээнд хандах өөр өөрийн хандлагаараа хоорондоо ялгаатай байна.

Радикалистууд нь дундыг баримтлагчдыг эрс тууштай бус, дундыг баримталсан, шүүхийн чөлөөт байдлын үзэл санааг дэвшүүлээгүй хэмээн шүүмжилдэг бол дундыг баримтлагчид “эрх зүй судлалын зорилго нь эрх зүйн ойлголтыг устгах бус, харин эрх зүй олон ойлголттой болохыг батлан, эрх зүйн плюрализмыг хөгжүүлэх явдал, хэт радикал үзэл нь бусад онолын урсгалууд реалист онолын үзэл санааг ойлгож танин мэдэхэд тус нэмэр болохгүй байна” хэмээн шүүмжлэдэг.

Эрх зүйн үнэлэлтийн асуудлыг эрх зүйн реалист онол нь шударга ёсны категорид хамааруулж үздэг байна. Шударга ёс нь эрх зүйн үнэлэлтээс хамаарна гэх боловч ерөнхий нэгдмэл шударга ёсны үзэл санааг шүүмжлэн “бодитой бус, нэр төдий зүйл” бөгөөд шүүх тодорхой хэрэг маргааныг шийдвэрлэхэд төдийлөн тус нэмэр болдоггүй. Харин шүүгч аливаа хэрэг маргааныг шийдвэрлэхдээ эрх зүйг бүтээхийн зэрэгцээ шударга ёсыг байнга эрэлхийлж байдаг хэмээн үзсэн байна.

Тэгэхээр эрх зүйн реализм нь формализмд үндэслэгдсэн хууль зүйн позитивизмын хуулийг тогтоосноор эрх зүй бий болдог, өөрөөр хэлбэл хууль бол эрх зүй хэмээн үздэг үзлийг шүүмжлэн “зогсонги” объектив эрхийг үгүйсгэж, эмперик олон факторууд эрх зүйд нөлөөлөн шийдвэрлэх ач холбогдолтой болохыг номлодог байна.

Эрх зүйн үнэт зүйл нь хийсвэр сэтгэлгээнээс бус, харин эрх зүйг хэрэглэх үйл ажиллагааны хэлбэр, хууль зүйн техник хэр хөгжсөнөөс шалтгаална гэж үздэг.

Эрх зүйн реализм нь эрх зүйг формализмаас ангижруулах, эрх зүйн плюрализмыг хөгжүүлэх, шүүхийн чөлөөт байдлыг хангах, хууль зүйн техникийг хөгжүүлэхэд тодорхой хувь нэмэр оруулжээ хэмээн дүгнэж болох юм.

67 Интернэтээс авав. “Интегративная юриспруденция” Джерома Холла.

68 История политических и правовых учений XX в. М.1995. стр.260.

Хяналтын асуулт:

1. Эрх зүйн реалист онолын үндэс, арга зүйн онцлогийг тайлбарлана уу?
2. Эрх зүйн реалист онолыг үндэслэгчид ашиг сонирхол болон эрх зүйн асуудлыг хэрхэн үздэг вэ?
3. Радикал реализм, дундыг баримтлагчдын үзэл хандлагын онцлог, ялгааг тайлбарлана уу?
4. Реалист онол яагаад шүүх хэрэг маргааныг шийдвэрлэхдээ хуулийн зүйл заалтад бус, бодит фактанд үндэслэн хэргийг шийдвэрлэх ёстой гэж үздэг вэ?
5. Эрх зүйн реалист онол, Цэвэр эрх зүйн онолын ялгааг тайлбарлана уу?
6. Эрх зүйн реалист онол нь шүүгчийн зорилгыг хэрхэн үздэг вэ?
7. Эрх зүйн реалист онолын Америкийн болон Скандиновын чиг хандлагын ялгаа, онцлогийг тайлбарлана уу?
8. Эрх зүйн реалист онол нь эрх зүйн бодит байдал, хүч чадлыг хэрхэн үздэг вэ?
9. Эрх зүйн реалист онол нь эрх зүйн үнэт зүйлд хэрхэн ханддаг вэ?

Ном зүй:

1. Лүндэндорж. Н. Эрх зүйн сэтгэлгээний хөгжлийн чиг хандлага УБ.2003.
2. Лүндэндорж. Н. Jurisprudence. Эрх зүй судлал: философи, онол.УБ.2011.
3. Нарангэрэл. С. Монголын ба дэлхийн эрх зүйн тогтолцоо. УБ. 2001.
4. Сэлэнгэ Х. Формализм ба эрх зүйн реалист онол. МУИС-ийн ХЗС-ийн “Эрх зүй, төрийн онол, түүх”- ийн тэнхмийн бюллетень. УБ. 2005.
5. Jeffrie G. Murphy and Jules L. Coleman. Philosophy of Law. USA. 1990.
6. Jules Coleman and Scott Shapiro. Jurisprudence and Philosophy of Law. Oxford. 2002.
7. Kaufmann.A. Rechtsphilosophie.1997
8. Kaufmann.A. Rechtsphilosophie.1997.
9. The Philosophy of law (Oxford Readings in Philosophy) by Ronald M. Dworkin (Jan 6, 1977)
10. Нерсесянц,В.С.Философия права.М., 1997.
11. American Legal Realism by William W. Fisher, Morton J. Horwitz and Thomas A. Reed (Oct 14, 1993)
12. Naturalizing Jurisprudence: Essays on American Legal Realism and Naturalism in Legal Philosophy by Brian Leiter (May 17, 2007)
13. Europe. The New Legal Realism: Essays in Honour of Hjalte Rasmussen by Henning Koch, rensen, Karsten Hagel-SF, Ulrich Haltern and Joseph H. H. Weiler (Dec 6, 2010)
14. Scandinavian legal realism (University of Washington School of Law. Student papers) by Robert D Kaplan (1969)



XI бүлэг

Эрх зүйн социологийн онол

Зорилго: Эрх зүй, нийгмийн харилцан хамаарал, эрх зүйд нөлөөлөх нийгмийн хүчин зүйлс болон хууль зүйн практикийн ач холбогдол, үр дүнг социологийн онол-арга зүйн үүднээс танин мэдэх

1. ЭРХ ЗҮЙН СОЦИОЛОГИЙН ОНОЛЫН АРГА ЗҮЙН ҮНДЭС

Эрх зүйн социологийн онол нь реалист чиг хандлагын нөлөөгөөр ХХ зууны эхэнд үүсч хөгжсөн.

Эрх зүйн социологийн онол нь:



Эрх зүйн социологийн онолын товч агуулга			
Эрх зүй нь нийгмийн амьдралын урт удаан туршлагын үр дүнд бий болсон	Эрх зүйн үндэс - нийгмийн амьдрал	Нийгмийн амьдралаас бий болсон эрх зүй бол амьд эрх зүй	Эрх зүйг бүтээхэд нийгмийн социаль бүлэглэлүүд оролцдог

Эрх зүйн социологийн онолын чиг хандлага:

Эрх зүйн социологийн онол нь нэг талаас ерөнхий социологийн хүрээнд эрх зүйн үзэл баримтлал бий болох замаар, нөгөө талаас хууль зүйн шинжлэх ухаанд социологийн ойлголт, арга зүйг хэрэглэсэний үр дүнд бүрэлдэн тогтсон юм. Эрх зүйн социологийн онолыг голлон Герман, Австри, Франц, Орос, Америкийн социологийн болон хууль зүйн шинжлэх ухааны төлөөлөгчид хөгжүүлсэн тул социологийн онолын чиг хандлагыг дараах чиг хандлагаар авч үзэж байна.

Амьд эрх зүйн онол

Институционалист социологийн чиг хандлага

Социологийн сэтгэл зүйн чиг хандлага

2. АМЬД ЭРХ ЗҮЙН ОНОЛ

“Амьд эрх зүйн онол”-ын төлөөлөгчид Е.Эрлих, Г.Канторович, Г.Зинцхеймер нар нь эрх зүйн социологийн онолын хөгжилд ихээхэн үүрэг гүйцэтгэсэн юм.

“Амьд эрх зүйн онол” нь дараах асуудалд анхаарал хандуулдаг.

1. Амьд эрх зүй


2. Эрх зүйн чөлөөт байдал

3. Эрх зүйг судлах арга зүйн асуудал



Е.Эрлих, Г.Канторович, Г.Зинцхеймер нар нь догматик, спекулятив-метафизик онолын эсрэг эрх зүйг эмперик түвшинд судлаж, шүүх захиргааны хууль бүтээх эрх чөлөөг өргөтгөхийг эрмэлзсэн. Энэхүү үзэл санааны үүднээс эрх зүйг хууль тогтоох үйл ажиллагаанаас ч биш, мөн шүүхийн практикаас ч биш, харин нийгмийн амьдралаас эрж хайх ёстой гэж үзсэн. Иймд эрх зүйг танин мэдэх үндэс нь нийгмийн амьдралд тодорхой хэрэгжиж байгаа хэлцэл, гэрээ, гэрээслэл гэх мэт эрх зүйн баримт бичиг, заншил юм. Эрх зүй судлаачид нь хүмүүсийн зан үйл, харилцаанд ажиглалт хийж, нийгмийн амьдралаас тасархай, хийсвэр формаль хэм хэмжээг бус “амьд эрх зүй”-г судлах ёстой гэжээ.

Тэгээд ч эрх зүй нь бүхэлдээ хуульд тусгагдаж чаддаггүй. Төрөөс тогтоосон хэм хэмжээ бол эрх зүйн нэг л хэсэг юм.



Нөгөө талаар хууль, бодит амьдралд хэрэгжиж буй “амьд эрх зүй” хоёрын хооронд нилээн ялгаа байна гэж үзэж, “амьд эрх зүй”-г позитив эрхийн эсрэг сөргүүлэн тавьж байсан. Гэхдээ энэхүү онол нь позитив эрх зүйг үгүйсгээгүй юм. Энэхүү үзлээрээ радикал реализмаас ялгаатай.

“Амьд эрх зүй” гэж юу вэ?


Нийгмийн харилцаа түргэн хурдацтай хөгжиж, өөрчлөгдөн шинэчлэгдэж байгаа нөхцөлд хууль нь нийгмийн амьдралаас хоцорч байдаг. Харин нийгмийн амьдралыг өөртөө шингээсэн, түүнтэй нийцэж зохицуулж байдаг эрх зүй бол “амьд эрх зүй” юм.

Нийгэм нь гэр бүлээс төр хүрэл янз бүрийн бүлэглэл, холбоо, нийгэмлэгийн нэгдэл юм. Эдгээр нийгмийн янз бүрийн нэгдэл, холбоо /компани, трест, картель, синдикат, корпораци гэх мэт/ нь өөрийн дүрэм, журам, эрхийг төрөөс гадна тогтоодог.

Амьд эрх зүй гэж юу вэ ?

Нийгмийн материаллаг ашиг сонирхолтой бүлэглэл, холбоодоос тогтоосон, нийгмийн амьдралыг өөртөө шингээсэн дүрэм журам, гэрээ

“Амьд эрх зүй”-н онолын төлөөлөгчид нь позитив эрх зүйг үгүйсгээгүй боловч, нийгмийн хөгжлөөс хоцорч байдаг зогсонги эрх зүй гэж шүүмжилж, шүүхийн шийдвэрийг илүүд үзэж байв. Энэхүү үндэслэлээр хууль тогтоогч хэм хэмжээг тогтоодоггүй, харин өдөр тутмын хуульчдын практик үйл ажиллагааны явцад “амьд эрх зүй” буюу бодит эрх зүй бий болчихсон байдгийг хууль тогтоогч илрүүлэн баталгаажуулдаг гэжээ. Ийнхүү эрх зүйг нийгмийн харилцааны дэг журам гэж үзсэн.



“Амьд эрх зүй”-н онолын агуулга:

1. Эрх зүйн мөн чанар, үндэс, агуулгыг зөв танин мэдэхийн тулд “амьд эрх зүй”-г судлах

2. Шүүхийн практик, хуулийн текстээс хальж, эрх зүйн харилцааны хөгжлийг судлах

3. Эрх зүйг хийсвэр сэтгэхүйгээс бус, бодит амьдралаас хайх,

4. Хувийн эрх зүй – амьд эрх зүй


5. Шүүх хэрэг маргааныг шийдвэрлэхдээ хууль нийцэхгүй байвал амьд эрх зүйд үндэслэх



3. ИНСТИТУЦИОНАЛИСТ-СОЦИОЛОГИЙН ЧИГ ХАНДЛАГА

Эрх зүйн социологийн онолын нэг чиг хандлага нь институционалист-социологийн чиг хандлага юм. Энэхүү онолын төлөөлөгчид нь Е.Леви, Ж.Гурвич, А.Леви-Брюль нар юм.

Институционалист-социологийн чиг хандлага нь өндөр хөгжилтэй нийгэм гэдэг бол институцийн нэгдэл үзсэн. Институци гэдэг нь тодорхой зорилго, үзэл санааны үүднээс нэгдсэн нийгмийн бүлэглэл юм. Институци нь нийгмийн амьдралын механизмыг ойлгох боломжийг бий болгодог.



Төр нь улс төрийн бусад байгууллагаас онцгой гойд ялгаагүй, нийгэмд оршин буй институцийн нэг юм. Нийгмийн институци бүр өөр өөрийн эрхтэй бөгөөд бүх нийтээр заавал даган биелүүлэх хэм хэмжээг боловсруулах, улмаар боловсронгуй болгоход оролцдог гэж институционалист-социологийн чиг хандлага нь үзсэн юм. Ийнхүү төрийн хууль бүтээх монопол эрхийг үгүйсгэж, эрх зүйд плюрализм хөгжих үндсийг тавьсан байна. Дээрх үзэл санааны үүднээс Францын институционалист А.Леви-Брюль хуульчдыг хоёр ангилсан. Үүнд:

1. Монистууд буюу гагцхүү төр нь эрх зүйн тогтолцоотой бөгөөд эрх зүйг бүтээх эрх мэдэлтэй гэж үздэг хуульчид
2. Плюралистууд буюу нийгмийн институци бүр эрх зүйг бүтээх, боловсронгуй болгоход оролцдог гэж үздэг хуульчид

Институционалист А.Леви-Брюль нь “эрх зүйн үндэс, эх сурвалж нь хаана байна вэ? гэсэн асуулт тавиад, үүнд би “эрх зүй нийгмийн институцээс үүсдэг” гэсэн ганц л хариулт өгнө” гэжээ. Иймд А.Леви-Брюль нь эрх зүйг дараах шинжүүдийг агуулдаг гэж үзсэн байна. Үүнд:

1. Заавал биелэгдэх
2. Нийгмийн институцээс тогтоогдох
3. Нийгмийн харилцааны явцад байнга өөрчлөгдөн шинэчлэгдэж байх

Зарим судлаач эрдэмтэд үзэхдээ эрх зүйн хэм хэмжээг нийгмийн бусад зан үйлийн хэм хэмжээтэй хольж, адилтгасан гэж институционалист-социологийн чиг хандлагыг шүүмжилдэг болно.

Институционалист-социологийн чиг хандлагын агуулга:

1. Эрх зүй институцээс бүтээгддэг

2. Эрх зүйн уг сурвалж нь норматив факт, харин хууль бол формаль эх сурвалж

3. Эрх зүйн үндэс – хууль зүйн туршлага

Институционалист-социологийн чиг хандлага нь хууль зүйн практикийн ач холбогдлыг нэмэгдүүлж, эрх зүйн эх сурвалжид хандах хандлагад өөрчлөлт хийхийг эрмэлзсэнээрээ ач холбогдолтой юм.



4. Социологийн сэтгэл зүйн чиг хандлага

Эрх зүйн социологийн онолын сэтгэл зүйн чиг хандлагын төлөөлөгчид нь Ж.Гурвич, П.Сорокин нар юм.


Сэтгэл зүйн чиг хандлага нь эрх зүйн индивидуалист үзлийг шүүмжилж, бие хүн, төр хоёрын хоорондын хамаарлын асуудалд анхаарлаа хандуулж, эрх зүй гэдэг нь нэг талаас субьектын эрх, нөгөө талаас төрөөс тогтоосон хэм хэмжээний систем гэж үздэг. Энэхүү үзэл санааны үүднээс нийгэм гэдэг нь материаллаг болон материаллаг бус ашиг сонирхолтой, нийгмийн янз бүрийн түвшинд орших, социаль бүлэглэлүүдийн нэгдэл гэж үзсэн.

Эрх зүйн социологийн онолын сэтгэл зүйн чиг хандлагын төлөөлөгч Ж.Гурвич нь эрх зүйг нийгмийн социаль бүлэглэлүүдээс тогтоогддог гэж үзэж “социаль эрх зүй”-н санааг дэвшүүлсэн. Үүнийгээ Ж.Гурвич плюралист эрх зүйн философи гэж нэрлэсэн юм.

Социаль эрх зүйн санаа нь индивидуализмыг даван туулах хэрэгсэл болж гарч ирсэн.

Социаль эрх зүй нь бие хүний бус, бид гэсэн объектив нэгдлийн эрх бөгөөд нийгмийн харилцааны дээд хэлбэрийн илрэл юм.

Социаль эрх зүй нь итгэлд үндэслэгддэг тул гаднаас тогтоогддоггүй, социаль бүлэглэлийн дотоодоос тогтоогддог, автономт эрх болно.





Эрх зүйн бодит байдал юунд оршиж байна вэ? гэсэн асуултад онолын чиг хандлагууд өөр, өөрийн арга зүй, онолын янз бүрийн хариултуудыг өгдөг. Харин Ж.Гурвич нь эрх зүйн бодит байдлыг хууль зүйн туршлагатай холбоотой бөгөөд энэ нь эрх зүйн үнэт зүйлийг хамт олны актанд хүлээн зөвшөөрсөнөөр илрэнэ гэж үзсэн юм. Хууль зүйн туршлага нь заавал рационал ухамсрын үйлдэл байх шаардлагагүй,

энэ нь интуитив замаар бий болж болно гэжээ. Иймд эрх зүйн бодит байдал нь зөвхөн социаль эрх зүйн хүрээнд төдийгүй эрх зүйн тогтолцоонд бүхэлд нь илрэнэ гэж үзсэн.

5. РОСКО ПАУНДЫН СОЦИОЛОГИЙН ОНОЛ

XX зууны эрх зүйн социологийн онолын хөгжилд Америкийн хуульч Роско Паунд ихээхэн хувь нэмэр оруулсан.

Роско Паундын арга зүйн үндэс:



Роско Паунд нь инструментализмын үүднээс инженерийн ажлыг ямар нэгэн уламжлалт идеал төлөвлөгөөтэй нийцэж байгаа эсэхийг харгалзан дүгнэдэггүй, харин өмнөө тавьсан зорилготой хэрхэн нийцэж байгаагаар дүгнэдэг. Инженерийн ажилд үнэлэлт, дүгнэлт өгдөгийн нэгэн адил эрх зүйд хандах ёстой гэж үзсэн. Энэ үндсэнд эрх зүйн дэг журмыг судлахын хамт эрх зүйн мөн чанар, шинжийг шүүмжлэн хэлэлцэх ёстой. Эрх зүйн дэг журмыг ойлгохдоо найруулан томъёолсон үр дүнгийн эмхэтгэл, цуглуулга гэж ойлгож болохгүй, харин үйл ажиллагаа гэж ойлгох хэрэгтэй. Учир нь эрх зүйн зорилго нь нийгмийн зохицлыг хангах явдал юм. Иймд эрх зүй нь нийгмийн зохицлыг бэхжүүлэх үүрэгтэй, нийгмийн хяналтын арга хэрэгсэл буюу “нийгмийн инженер” гэж үзсэн.



Роско Паунд нь эрх зүйн ойлголтыг дараах гурван аспектын үүднээс авч үзэж байсан бөгөөд гурав дахь аспектын ойлголтыг илүү хүлээн зөвшөөрч байсан юм. Үүнд:

1. Эрх зүй- эрх зүйн дэг журам буюу нийгмийн харилцааг зохицуулах албадлагын журам
2. Эрх зүй- эрх зүйн хэм хэмжээний нийлбэр цогц
3. Эрх зүй- шүүх болон захиргааны үйл ажиллагаа буюу процесс

Ийнхүү Роско Паунд нь социологийн онолын төлөөлөгчдийн нэгэн адил эрх зүйг нийгмийн амьдралтай холбож, хуульчдын бүтээлч үйл ажиллагааны үр дүн гэж үзэж, хууль зүйн техник, шүүхийн практик ач холбогдол өгсөнөөрөө сайн талтай юм.

Хяналтын асуулт:

1. Амьд эрх зүйн онол нь эрх зүйн үндсийг хэрхэн үздэг вэ?
2. Амьд эрх зүй гэж юу вэ? Амьд эрх зүй болон позитив эрхийн ялгааг тайлбарлана уу?
3. Хувийн эрх зүйг амьд эрх зүй гэж үзэж болох уу?
4. Гэрээ нь хуулийн нэгэн адил дээд хүчин чадалтай байж болох уу?
5. Эрх зүйг судлахад шүүхийн практик, хуулийн текстийн хүрээнд судлах нь хангалттай юу? Эрх зүйн социологийн онол - арга зүйн үүднээс тайлбарлана уу?
6. Амьд эрх зүйн онол нь яагаад төрийн хууль тогтоох монопол эрхийг үгүйсгэдэг вэ?
7. Социаль эрх гэж юу вэ?
8. Эрх зүйн социологийн онол нь эрх зүйн зорилгыг хэрхэн үздэг вэ?
9. Эрх зүйн социологийн онол нь эрх зүйн реалист онолоос онол- арга зүйн ямар ялгаатай вэ?
10. Эрх зүйн социологийн онолын хууль зүйн шинжлэх ухаанд оруулсан үнэт зүйл, хувь нэмрийг тодорхойлно уу?

Ном зүй:

1. Лүндэндорж. Н. Эрх зүйн сэтгэлгээний хөгжлийн чиг хандлага УБ.2003.
2. Лүндэндорж. Н. Jurisprudence. Эрх зүй судлал: философи, онол.УБ.2011.
3. Нарангэрэл. С. Монголын ба дэлхийн эрх зүйн тогтолцоо. УБ. 2001.
4. Jeffrie G. Murphy and Jules L. Coleman. Philosophy of Law. USA. 1990.
5. Jules Coleman and Scott Shapiro. Jurisprudence and Philosophy of Law. Oxford. 2002.
6. Kaufmann.A. Rechtsphilosophie.1997
7. The Philosophy of law (Oxford Readings in Philosophy) by Ronald M. Dworkin (Jan 6, 1977)
8. Нерсеянц,В.С.Философия права.М., 1997.
9. Jurisprudencija I - III by Rosko Paund (2000)
10. A Sociological Theory of Law (International Library of Sociology) by Niklas Luhmann (Jul 1985)
11. Law's Community: Legal Theory in Sociological Perspective (Oxford Socio-Legal Studies) by Roger Cotterrell (Jun 12, 1997)
12. A Sociology of Jurisprudence (Legal Theory Today) by Richard Nobles and David Schiff (Feb 1, 2006)
13. Sociological Theories of Law (International Library of Essays in Law and Legal Theory : Schools, Vol 12) by Kahei Rokumoto (Jun 1, 1994)
14. Classical Sociological Theory (Sociology for a New Century) by Bert N. Adams and R. A. Sydie (Jan 29, 2002)



ХII бүлэг


Феноменологи эрх зүйн философи

Зорилго: Эрх зүйн цэвэр мөн чанар, эрх зүй болон эрх зүйн ухамсрын харилцан хамаарал, эрх зүйн априор танин мэдэхүйн процессыг ойлгож, танин мэдэх

1. ФЕНОМЕНОЛОГИ ЭРХ ЗҮЙН ФИЛОСОФИЙН АРГА ЗҮЙН ҮНДЭС

Феноменологи эрх зүйн философи нь ХХ зууны эрх зүйн философийн онолын чиг хандлага юм. Энэхүү философийн гол төлөөлөгчид нь Х.Вельцель, Г.Гуссерль, А.Райнах. Феноменологи эрх зүйн философийн гүн ухааны үндэс нь субъектив идеализм. Феноменологи эрх зүйн философи нь эрх зүйг агуулга талаас нь, байх ёстой зүйлийн хүрээнд, априор түвшинд судалдаг. Учир нь феноменологи эрх зүйн философи нь өөрийн арга зүйн үүднээс шинжлэх ухааны судалгаа гаднаас өгөгддөггүй, өөрийнх нь цэвэр сэтгэлгээнээс өгөгддөг учир юмс үзэгдлийн сэтгэлгээ, бясалгалын үр дүнг судлах ёстой гэж үздэг.

Феноменологи арга зүйн үүднээс шинжлэх ухааны судалгаа гаднаас өгөгддөггүй, өөрийнх нь цэвэр сэтгэлгээнээс өгөгддөг учир юмс үзэгдлийн сэтгэлгээ, бясалгалын үр дүнг судлах ёстой байна.



2. ФЕНОМЕНОЛОГИ ЭРХ ЗҮЙН ФИЛОСОФИЙН АГУУЛГА

Феноменологи эрх зүйн философи нь эрх зүйн үндсийг эйдос гэж үздэг. Феноменологи эрх зүйн философийн төлөөлөгч Г.Гуссерль нь бүх түгээмэл мөн чанарыг эйдос гэж үзэж байв.

Эрх зүйн эйдос гэж юу вэ?

Эрх зүйн эйдос гэдэг нь эрх зүйн цэвэр мөн чанар, идеал хэлбэр, эрх зүйн хэм хэмжээний априор үзэл санааг багтаасан эрх зүйн түгээмэл мөн чанар юм. Эрх зүйн эйдос нь эрх зүйг танин мэдэж, ухамсарлах интенциаль /юмсыг ухамсарлах сэтгэл/ танин мэдэхүйн үр дүнд бий болдог.



Феноменологи эрх зүйн философичид үзэхдээ: эрх зүйн тогтолцоо позитив эрхээр илрэхгүй, учир нь априор бүтэцтэй. Өөрөөр хэлбэл эрх зүйн цэвэр мөн чанар, хэлбэр, шинжийг агуулсан априор бүтэцтэй. Энэ нь эрх зүйг судлах объект бөгөөд интенциаль объект /интенциаль ухамсрын явцад бий болох/ юм.

Эрх зүй нь хэм хэмжээ танин мэдэхүйн объект болохын хувьд субъекттэй холбоотой. Субъектын танин мэдэхүйгүйгээр эрх зүй нь орших боломжгүй. Эрх зүйн танин мэдэхүйн интенциаль ухамсрын явцад эрх зүйн априор үзэл санаа нь бий болж, эйдит эрхийг бүтээдэг.

Эйдит эрх нь эрх зүйн цэвэр мөн чанар, идеал хэлбэр, априор үзэл санааг агуулж байгаа тул жам ёсны эрхийн нэгэн адил, позитив эрхийн өмнө оршиж, түүний үндэс болно гэж үзэж байна.

Эйдит эрх —————> Позитив эрх

Эрх зүйн эйдосыг тайлбарлах явцдаа феноменологи эрх зүйн философи нь объектив, субъектив идеализмын аль алинд нь хальтарч байна. Нэг талаас эрх зүйн эйдос, норматив үзэл санаа нь нэг талаас объектив шинжтэй боловч индивидуаль ухамсар, сэтгэл зүйд мэдрэгддэггүй. Тухайлбал, үүрэг, өмч гэх зэрэг эрх нь мод, чулуу гэдгийн нэгэн адил ахуйн шинжтэй. Үүнийг позитив эрх нь бүрэн ойлгож



хүлээн авах боломжгүй, харин гажих боломжтой байдаг гэж үздэг. Нөгөө талаас эрх зүйн эйдос нь интенциаль объект. Эрх зүйн хэм хэмжээ нь танин мэдэхүйн судлагдахуун болохын хувьд субъектын танин мэдэхүйгээс гадуур байх боломжгүй. Эйдит эрх, априор эрх зүйн санаа нь байнгын интенциаль ухамсрын явцад л оршин байдаг гэж үзсэнээрээ субъектив идеализм руу хальтирдаг юм.

Ийнхүү феноменологи эрх зүйн философи нь субъектын эрх зүйн ухамсар, эрх зүйн танин мэдэхүйн үр дүнд эрх зүй бий болно гэж үзэж байна.



Хяналтын асуулт:

1. Феноменологи эрх зүйн философи эрх зүйн үндсийг хэрхэн үздэг вэ?
2. Эрх зүйн эйдосийг хэрхэн танин мэдэх вэ?
3. Эйдит эрх болон позитив эрхийн хамаарлыг тайлбарлана уу?
4. Эрх зүй нь субъектын танин мэдэхүйгээс гадуур орших боломжтой юу?
5. Эрх зүйн эйдос, норматив үзэл санаа нь позитив эрхээр бүрэн илэрдэг үү?

Ном зүй:

1. Нерсеянц,В.С.История политических и правовых учений.М., 1996.
2. Нерсеянц,В.С.Философия права.М., 1997.
3. Jeffrie G. Murphy and Jules L. Coleman. Philosophy of Law. USA. 1990.
4. Jules Coleman and Scott Shapiro. Jurisprudence and Philosophy of Law. Oxford. 2002.
5. Kaufmann.A. Rechtsphilosophie.1997
6. The Philosophy of law (Oxford Readings in Philosophy) by Ronald M. Dworkin (Jan 6, 1977)
7. Ideas: General Introduction to Pure Phenomenology (Routledge Classics) by Edmund Husserl and Dermot Moran (Apr 26, 2012)

ХIII бүлэг

Герменевтик эрх зүйн философи

Зорилго: Эрх зүйн ойлголт, түүний мөн чанарыг герменевтик эрх зүйн философийн онол - арга зүйн үүднээс ойлгож танин мэдэх

1. ГЕРМЕНЕВТИК ЭРХ ЗҮЙН ФИЛОСОФИЙН АРГА ЗҮЙН ҮНДЭС

Эрх зүйн философийн орчин үеийн онолын чиг хандлаг нь герменевтик эрх зүйн философи нь юм. Энэхүү философийн гол төлөөлөгчид нь А.Кауфман, В.Хассемер. Герменевтик эрх зүйн философийн гүн ухааны үндэс нь субъектив идеализм. Герменевтик эрх зүйн философи нь эрх зүйг агуулга талаас нь судалдаг. Гэхдээ эрх зүйг зөвхөн байгаа зүйлийн хүрээнд бус, мөн байх ёстой зүйлийн хүрээнд судалдагаараа онцлогтой юм.

Герменевтик философийн хөгжлийн явцад герменевтик арга зүй, герменевтик философи хоёрыг ялгаж зааглаж ирсэн байна.

Герменевтик арга зүй нь дундад зууны үеэс шинжлэх ухааны бие даасан арга болж хөгжсөн. Герменевтик гэдэг нь гермес гэсэн бурхдын хүсэл зоригийг хүмүүст тайлбарладаг бурханы нэрнээс үүссэн байна. Герменевтик арга зүйг хөгжүүлэхэд Ф.Шлейермахер, Дильтей нар ихээхэн хувь нэмрийг оруулжээ.


Герменевтик арга зүй нь текстийг тайлбарлах онол бөгөөд түүх, соёлын нөлөөлөл, нийгэм - эдийн засгийн шалтгаанаар агуулгыг өөрчлөхгүйгээр текстийг ойлгох нь чухал гэж үздэг.

Аливаа хүмүүс өөр хоорондоо харилцан мэдээлэлд оршдог бөгөөд харилцан мэдээлэлийг хэрэгжүүлэх хэрэгсэл нь эх хэл юм. Эх хэл бол ахуйн орон сууц гэж үздэг.

Герменевтикийн логикоор эх хэл яагаад ахуйн орон сууц болж байна вэ?

Хүмүүс харилцан зөв ойлголцсоноор ахуйг байгаагаар нь ойлгоно. Хүний амьдралын хэлийг эхээр нь ойлговол ахуйг зөв тодорхойлно.

Герменевтик арга зүйгээр аливаа юмсыг ойлгоход гурван харилцаа үүсдэг бөгөөд үүнийг герменевтикийн гурвал гэдэг байна. Танин мэдэхүйн объект, зохиогч, мэдээлэлийг хүлээн авч буй субъектын хооронд харилцаа үүсэх ба мэдээлэлийг хүлээн авч буй объект нь зохиогчийг зөв ойлгосноор объектыг зөв тодорхойлно гэж үздэг.



2. ГЕРМЕНЕВТИК ЭРХ ЗҮЙН ФИЛОСОФИЙН АГУУЛГА

Герменевтик арга зүй нь XVIII зуунаас оноос бие даасан аргаасаа хальж философи болж хөгжсөн байна.

Хууль зүйн шинжлэх ухааны хувьд XX зууны үед герменевтик эрх зүйн философиийг А.Кауфман, В.Хассемер нар хөгжүүлжээ.

Герменевтик эрх зүйн философийн онцлог нь жам ёсны эрхийн онолыг хүлээн зөвшөөрч, жам ёсны эрхийн онолыг хөгжүүлэхэд ихээхэн хувь нэмрийг оруулсан болно.

Герменевтик эрх зүйн философичид үзэхдээ уламжлалт жам ёсны эрхийн онолчдын үзэл санааг өөрчилж, жам ёсны эрх нь түүхэн нөхцөлд байнга өөрчлөгдөж байдаг эрх хэмээн үзжээ.

Жам ёсны эрх нь эрх зүйн санаа буюу шударга ёсноос үүсдэг. Эрх зүйн санаа нь позитив эрхийн үндэс, эрх зүйн үндсэн зарчим болохын хувьд байх ёстой зүйлээс бий болдог байна. Байх ёстой эрх зүйн санаа буюу үндсэн зарчим нь нийгмийн амьдралын бодит нөхцөл байдал болох байгаа зүйлтэй нийцэж бий болно. Энэхүү танин мэдэхүйн үйл ажиллагааны үр дүнд эрх зүйн хэм хэмжээ /хууль, прецедент/ бүрэлдэн тогтож байдаг гэж герменевтик эрх зүйн философичид үзэж байна.

Иймд герменевтик эрх зүйн философичидийн үзлээр эрх зүй нь байгаа болон байх ёстойн зохицол юм.



Герменевтик эрх зүйн философич А.Кауфман үзэхдээ: “Эрх зүйг танин мэдэх гэдэг нь герменевтик онолын цөм болсон асуудал. Эрх зүйг танин мэдэх гэдэг нь эрх зүйг ойлгох процесс бус, харин түүхэн амьд хэлний үндсэн дээр бодит түүхэн эрхийг тогтоох процесс” гэж үзжээ. Иймд эрх зүй нь герменевтик танин мэдэхүйн процессын үр дүн юм.

Хяналтын асуулт:

1. Герменевтик арга зүйг хуулийг тайлбарлахад хэрхэн хэрэглэдэг вэ?
2. Герменевтик эрх зүйн философийн жам ёсны эрхийг хөгжүүлэхэд оруулсан хувь нэмрийг тайлбарлана уу?
3. Герменевтик эрх зүйн философи эрх зүйн үндсийг хэрхэн үздэг вэ?
4. Эрх зүйг танин мэдэх герменевик арга зүйг тайлбарлана уу?
5. Герменевтик эрх зүйн философийн онцлог, ач холбогдлыг тайлбарлана уу?

Ном зүй:

1. Нерсесянц,В.С.История политических и правовых учений.М., 1996.
2. Нерсесянц,В.С.Философия права.М., 1997.
3. Jeffrie G. Murphy and Jules L. Coleman. Philosophy of Law. USA. 1990.
4. Jules Coleman and Scott Shapiro. Jurisprudence and Philosophy of Law. Oxford. 2002.
5. Kaufmann.A. Rechtsphilosophie.1997
6. The Philosophy of law (Oxford Readings in Philosophy) by Ronald M. Dworkin (Jan 6, 1977)
7. de Heidegger a Habermas - Hermeneutica (Biblioteca Herder) (Spanish Edition) by Javier Bengoa Ruiz de Azua (Mar 1994)



XIV бүлэг

Экзистенциалист эрх зүйн философи

Зорилго: Эрх зүйн бодит ахуй, түүний мөн чанарыг экзистенциалист эрх зүйн философийн онол- арга зүйн үүднээс танин мэдэх

1. ЭКЗИСТЕНЦИАЛИСТ ЭРХ ЗҮЙН ФИЛОСОФИЙН АРГА ЗҮЙН ҮНДЭС

Экзистенциалист эрх зүйн философи нь хууль зүйн шинжлэх ухааны ХХ зууны онолын нэг гол чиг хандлага юм. Экзистенциалист эрх зүйн философийн гол төлөөлөгчид нь Э.Фехнер, Г.Кон, В.Майхофер нар билээ.

Экзистенциалист эрх зүйн философийн гүн ухааны үндэс нь субъектив идеализм. Философийн судлагдахууныг хүн гэж үздэг бөгөөд хүний мөн чанарыг хүний оюун санаа хэмээн үздэг рационализм, нийгмийн харилцааны цогц хэмээн үздэг марксизмын эсрэг философи юм.

Экзистенциалист эрх зүйн философи нь гадаад ахуйг бус, дотоод ахуйг судлах ёстой хэмээн үзэж, ердийн эмперик ахуйн эсрэг хүний оршин ахуйг сэргүүлэн тавьдаг оршин ахуйн философи.

Оршин ахуй /*esistenza*/ гэж юу вэ?

Оршин ахуй нь хүний мөн чанараас өмнө оршдог бөгөөд хүний оюун ухаанд үл захирагдах шинжтэй. Иймд экзистенциалист философичдын үзлээр оршин ахуй нь хүний мөн чанар бус аж. Учир нь хүний мөн чанар нь тодорхой өгөгдсөн зүйл юм. Харин оршин ахуйн нэг гол шинж нь үл объективчлагдах чанар. Хүн өөрийн чадвар, мэдлэг, ур чадлаа практикт гадаад юмс болгон объективчилж болно. Тэрчлэн хүн өөрийн сэтгэхүйг онолын талаас оногдохуй буюу объект болгон үзэж болно. Харин онолын болон практикийн объективчилалаас мултран үлддэг, хүнд үл захирагдах цорын ганц зүйл бол хүний оршин ахуй буюу экзистенци юм. Оршин ахуй нь ердийн ахуйд байнга илэрдэггүй, тодорхой нөхцөлд, тодорхой модусаар илэрдэг байна. Тухайлбал, оршин ахуй нь тодорхой нөхцөлд айх, түгших, баярлах, гомдох зэрэг модусаар илэрдэг байна. Гэхдээ оршин ахуй нь баярлах хөөрөх модусаар илрэх боловч оршин ахуйг бүрэн илэрхийлж чаддаггүй гэж экзистенциалист философичид үздэг.

2. ЭКЗИСТЕНЦИАЛИСТ ЭРХ ЗҮЙН ФИЛОСОФИЙН АГУУЛГА

Экзистенциалист эрх зүйн философи нь эрх зүйн мөн чанар, үүргийг оршин ахуйтай холбож авч үздэг юм. Тэдний үзлээр позитив эрх зүй нь ердийн ахуйд хиймэл, зохиомол, зогсонги үзэгдэл тул позитив эрх зүй нь өөрийн хүч чадлаа хүний оршин ахуйгаас олж авдаг⁶⁹. Нийгмийн амьдралын тодорхой нөхцөлд ердийн ахуй, оршин ахуйн харилцаа илэрч, тэр нөхцөлд оршин ахуй нь позитив эрхэд нөлөөлдөг байна. Иймд позитив эрх зүйг экзистенциалист эрх зүйн боломж хэмээн үздэг. Э. Фехнер болон экзистенциализмын бусад эрх зүй судлаачид дээрхи романтик хэмээн нэрлэгдэх экзистенциализмыг төдийлэн дэмждэггүй. Э. Фехнер: эрх зүй нь өөрийн үндэс, мөн чанарын хувьд хүний оршин ахуй, чөлөөт хүсэл зоригоор тодорхойлогддог гэж үздэг⁷⁰.

Экзистенциалистүүд үзэхдээ: эрх зүй нь өөрийн агуулгаар тодорхой /тусгай/ эрх зүйн нөхцөлүүдэд тасралтгүй гинжин холбоо бүхий байдаг. Маш их олон эрх зүйн тохиолдлууд /хэргүүд/ нь зогсонги, хуурай хэм хэмжээгээр / АНУ-ын архи хориглосон хууль шиг, эсвэл монголын хууль гурав хоног гэдэг шиг хэм хэмжээгээр / илрэх боломжгүй гэж үздэг. Учир нь хэргийн нөхцөл байдал болгон бие даасан, өөрийн онцлогтой, дахин давтагдахгүй шинжүүдийг өөртөө агуулж байдаг байна. Иймд экзистенциалист эрх зүйн философичид эрх зүйг норматив шинжгүй хэмээн үздэг. Тухайлбал, К. Яспер: “оршин ахуйгаас ангид бүхэн механик, зогсонги /үхмэл/ хэмээн үзэж байна”⁷¹. Ийнхүү экзистенциалист эрх зүйн философичид хэм хэмжээг ухамсрын зохиомол үр, хоосон санаа хэмээн үгүйсгэдэг. Иймд марксистүүд хуулийн нэр хүндийг бууруулж, шүүгчийн эрхийг хэт өргөмжилсөн хэмээн үзэж, экзистенциалист эрх зүйн философичдийг шүүмжилж байв⁷².

Экзистенциалист эрх зүйн философичид эрх зүй, эрх зүйн институтыг хувь хүний болон хамт олны амьдрах үйл ажиллагааны хэлбэр, хүмүүсийн хамтран аж төрөх арга гэдэг талаас нь судлах ёстой гэж үздэг. Иймд нийгмийн бүхий л хүрээнд эрх зүйд субъектив дүгнэлт өгч, эрх зүйг ухаж ойлгоход экзистенциалист анализ хийхэд хүргэдэг.

Экзистенциалист эрх зүйн философи нь эрх зүйн ахуйг судлахад гол анхаарлаа хандуулж, ахуйгаас эрх зүйг танин мэдэх, ахуйгаас шинэ хэм хэмжээг бүтээхэд ач холбогдол өгдөг юм. Тэдний үзлээр ахуйн үүднээс эрх зүйг гадаад нөлөөлөлийн фактор болохын хувьд хүний зан үйлийг тодорхойлох төдийгүй хүний зан характерын шинж, бие хүний өөрийнх нь илрэх хэлбэр гэж тодорхойлдог. Ийнхүү ертөнц нь хүний субъектив байдал мөн. Иймд эрх зүйн зохицуулалтын үндсэн шаардлага нь

69 История политических и правовых учений. М. 1988. стр. 721

70 История политических и правовых учений. М. 1988. стр. 721- 722

71 История политических и правовых учений. М. 1988. стр. 722

72 История политических и правовых учений. М. 1988. стр. 722



нийтийн ашиг сонирхолд хохирол учруулахгүйгээр хувийн ашиг сонирхол, зорилгыг хангах арга юм. Хувь хүний ашиг сонирхолыг бүрэн хангах тусам нийгмийн асуудлыг /зөрчлийг/ шийдвэрлэх явдал амжилттай байдаг гэж үздэг.


Экзистенциалист эрх зүйн философичид, ялангуяа А. Кауфман, М. Мюллер нар нь хууль зүйн шинжлэх ухааны онол- арга зүйн суурь, үндэс болох эрх зүйн философийн зорилгыг эрх зүйн түүхэн ахуйг танин мэдэж тодорхойлох явдал хэмээн үзэж, эрх зүйн ахуйг судлах арга зүйн асуудлыг хөндөж гаргажээ. Тэд үзэхдээ: “өмнө нь эрх зүйн ахуйг танин мэдэх явдал алдаатай, буруу байсан. Учир нь эрх зүйн ахуйг байгаа зүйлтэй, гадаад ертөнцтэй адилтгаж байсан. Ахуйг гаднаас нь авч үзэх нь эрх зүйг бүрэн ойлгож танин мэдэх боломжгүй болгож байна. Иймд ахуйг дотроос, өөрөөс нь судлах ёстой” гэж үзсэн.

Ахуйг өөрөөс нь судлах боломжтой юу? Ийм ахуй байгаа юу? Гэсэн асуултад “мэдээж боломжтой. Эрх зүйн ахуй бол хүн” гэж үзэж байна.



Эрх зүйг хүний оршин ахуйгаас илрүүлэн гаргах ёстой. Эрх зүйг хүний оршин ахуйгаас илрүүлэн гаргахад феномен шинэ хэлбэрээр бий болдог. Өөрөөр хэлбэл, эрх зүйг хүний оршин ахуйн үр дүн гэж үзэж байна. Тодорхой нөхцөлд хүмүүсийн харилцааны явцад хувь хүний зан үйлд нийцсэн шаардлагууд /нийтлэг зарчим, хэм хэмжээнүүд/ бий болдог бөгөөд энэхүү шаардлагууд нь хүмүүсийг нэгтгэх, үүргийн үндэс болж өгдөг. Иймд тодорхой нөхцөл бүрд эрх зүй бий болдог. Нөхцөл байдал /ситуаци/ бүр харилцан адилгүй байдаг тул тодорхой нөхцөлд үүссэн эрх зүй бүр экзистенциалист эрх зүй юм. Экзистенциалист эрх зүй бол бодит эрх зүй. Харин позитив эрх зүй нь хиймэл, зогсонги эрх зүй тул экзистенциалист эрх зүйд нийцэж байх ёстой гэж үзсэн. Экзистенциалист эрх зүйн философи нь позитив эрх зүйн өмнө өөр ямар нэгэн эрх зүй /жам ёсны эрх зүй/ байна гэж үздэгээрээ жам ёсны эрхийн онолтой төсөөтэй байна.

Ийнхүү экзистенциалист эрх зүйн философи нь эрх зүйг тодорхой нөхцөлд оршин ахуйгаас үүссэн хэрэг маргааныг шийдвэрлэсэн шийдвэр гэж үздэг.



Экзистенциалист эрх зүйн философийн гол агуулга нь зөв шийдвэр гаргахад чиглэгддэг бөгөөд зөв шийдвэр нь позитив эрх зүйгээс бүрэн илрэн гарч чадахгүй тулд экзистенциалист эрх зүйд анхаарлаа хандуулахыг чухалчилдаг. Эрх зүйн маргааныг зөв шийдвэрлэх нь хамгийн чухал. Иймд шүүгчийн зорилго нь гэм бурууг тогтоохоос илүүтэй, хэргийг бүх талаас нь авч үзэж, зөв шийдвэр гаргах явдал гэж үздэг.

Экзистенциалист эрх зүйн философи нь позитив эрх зүйн эсрэг, экзистенциалист эрх зүйг сөргүүлэн тавьж, эрх зүйн тодорхойлолт ойлголтыг авч үздэггүй, эрх зүйн хэм хэмжээг үгүйсгэдэг боловч, арга зүйн үүднээс эрх зүйн мөн чанар, үүргийг хүний дотоод ахуйн үүднээс авч үзэх явдал гэж үзэж, эрх зүйг формализмаас ангижруулахад нөлөөлсөн философи юм.

Хяналтын асуулт:

1. Оршин ахуйн онцлог, шинжийг тодорхойлно уу?
2. Оршин ахуй позитив эрхэд хэрхэн нөлөөлдөг вэ?
3. Эрх зүйн ахуйг өөрийнх нь дотроос судлах боломжтой юу?
4. Экзистенциалист эрх зүйн философи нь эрх зүйг хэрхэн бүтээгддэг гэж үздэг вэ?
5. Нийтлэг ашиг сонирхол ба иргэний эрх, үүрэгийн харилцан холбоог экзистенциалист эрх зүйн философийн арга зүйн үүднээс тайлбарлана уу?
6. Экзистенциалист эрх зүйн философи нь шүүгчийн зорилгыг хэрхэн үздэг вэ?

Ном зүй:

1. Нерсесянц, В.С. История политических и правовых учений. М., 1996.
2. Нерсесянц, В.С. Философия права. М., 1997.
3. Jeffrie G. Murphy and Jules L. Coleman. Philosophy of Law. USA. 1990.
4. Jules Coleman and Scott Shapiro. Jurisprudence and Philosophy of Law. Oxford. 2002.
5. Kaufmann, A. Rechtsphilosophie. 1997
6. The Philosophy of law (Oxford Readings in Philosophy) by Ronald M. Dworkin (Jan 6, 1977)



В. МОНГОЛЫН ЭРХ ЗҮЙН ФИЛОСОФИ

XV бүлэг

Монголын эрх зүйн философи

Зорилго: Монголын эрх зүйн сэтгэлгээ, түүний уг сурвалж, үндэс, онцлогийг өрнө-дорнын эрх зүйн сэтгэлгээтэй харьцуулж, эрх зүйн философийн онол- арга зүйн үүднээс Монголын эрх зүйн сэтгэлгээний үнэт зүйлийг илрүүлэн танин мэдэх

1. МОНГОЛЫН ЭРХ ЗҮЙН СЭТГЭЛГЭЭ НЬ ДОРНО ДАХИНЫ ЭРХ ЗҮЙН СУРГААЛТАЙ ХОЛБОГДОХ НЬ

Дорно дахины төр, эрх зүйн үзэл сэтгэлгээ нь газар зүйн орчин, түүнээс үүдсэн амьдрах аж төрөх аргад тулгуурлан хөгжиж, улмаар өрнөөс ялгагдах дорнын өвөрмөц төрт ёсны үзэл сэтгэлгээ, соёл иргэншлийг бий болгосон юм.

Дорно дахины улс орнууд нь дорнын соёлд үндэслэн эрхийг бус үүргийг дээдлэж, төр, хуулийг шүтэж ирсэн төрт ёсны үзэл сэтгэлгээний түгээмэл шинжийг агуулдаг.

Дорно дахины төр, эрх зүйн сэтгэлгээнд нөлөөлсөн хүчин зүйл:

- Газар зүйн орчин
- Амьдрах , аж төрөх арга
- Дорнодахины соёл иргэншил
- Нийгэм, улс төрийн тогтолцоо

Газар зүйн орчин, амьдрах аж төрөх аргаас улбаалан цусан төрлийн холбоонд үндэслэгдсэн эцгийн эрхт ёс, уламжлалт ёс заншил дорнын улс орнуудад харьцангуй удаан хугацаагаар хадгалагдан үлдсэн нийгмийн нөхцөл байдал нь төрийг дээдлэх, төрийн үүргийг хувь хүний үүргээс дээгүүрт авч үзэх, улмаар эрхийг бус үүргийг дээдлэх үзлийн нийгмийн үндсийг бүрдүүлжээ.

Дорно дахины эрхийг бус, үүргийг дээдлэх ёс нь ахас дээдсийг хүндлэн, хүү нь эцэгтээ, залуучууд нь ахмаддаа, харьяат ард нь төрдөө захирагдах нийгмийн удирдах удирдуулах жам ёсны зайлшгүйг ухаарсан ёс заншил, өвөрмөц сэтгэлгээнд үндэслэгдсэн юм. Тухайлбал, Хятадын Гүн-зийн сургаалтнууд шударга ёсны үзэл санаанаас “зорилгогүй үйлдэх”-ийн үзэл санааг гаргаж: Хүн юу ч хийхгүй байж чадахгүй, яагаад вэ гэвэл хүн бүхний хувьд хийвэл зохих юм бий. Хэдий тийм боловч түүний хийж байгаа нь зорилгогүй байна. Учир нь хийвэл зохих зүйлийн үнэ цэнэ гадаад үр дүнд биш (ёс суртахууны албадлагын үүднээс бус), харин уг зүйлд байдаг байна. Өөрөөр хэлбэл, үүргийн мөн чанартай холбоотой аж.

Гүн-з бүхнийг Мин-д буюу “Тэнгэрийн эрх”-нд даатган “Мин-ийг танин мэднэ гэдэг бол оршин буй ертөнцийн журмын зайлшгүйг зөвшөөрөн хүлээх, хэн нэгний гадаад амжилт, эсвэл бүтэмжгүйдлийг хайхрахгүй байх явдал. Хэрэв хүн ингэж үйлдэж чадвал алдах учиргүй. Учир нь, хэрэв бид хүлээсэн үүргээ биелүүлж байгаа бол түүний хэрэгжилт нь бидний үйлдлийн гадаад амжилт буюу бүтэмжгүйдлээс үл хамааран зөвхөн үйлдлийн баримтаараа л зан суртахуунтай юм. Ингэснээр хүн ялах хүслэнгээс ч, дийлэгдэх аюумшгаас ч ангижирч зол жаргалтай болно”/ Лунь Юй/ гэжээ. Энэ нь Гегелийн “хүн юмсын хүрээ, хязгаар, зайлшгүй шинжийг ухамсарласнаар жинхэнэ эрх чөлөөг эдэлнэ” хэмээсэнтэй ижил утгыг илэрхийлж байна. Өөрөөр хэлбэл, хүн ертөнцийн жам ёсыг ухаарсанаар үүргээ ухамсарлан хүн ёсоор амьдрах аж.

Мөн Энэтхэгийн буддын шашны бурхан багшийн “Бүгдэд хэрэгтэй үгс” сургаалд: “ах захын ёсыг баримталж, найрсаг ёс хийгээд үүрэг хариуцлагыг дагаж мөрдөх ёстой” хэмээн сургасан байна⁷³.

XIII зууны монголчууд ч “бие тэргүүнтэй, дээл захтай нь сайн” хэмээн ахас дээдсээ хүндлэх ёсыг чанд сахиж, үүргээ ухамсарлан “Эмээлээ тохуул, Үүдээ сөхүүл” хэмээн хөвүүнээ төрд зүтгүүлэхээр Чингис хаанд авчиран өгдөг байв.

Дорно дахинд үүргийг дээдлэхээс гадна бие хүний ач холбогдол, амьдралын үнэт зүйлс, эрхийг дээдэлсэн үзэл санаа тодорхой хэмжээгээр байсан юм. Тухайлбал, Гүн-зийн сургаалийн эсрэг гарч ирсэн даосизмыг үндэслэгчийн нэг Ян жү-гийн гол зарчим нь “Хүн бүр хувиа борлуул” гэсэн сургаал юм. Ян жү-гийн энэхүү сургаал нь хүний оршихуйг хадгалахыг эрмэлзсэн байх бөгөөд түүний утга, мөн чанарыг “Ле-з” шаштирт: “Ян Жү-гээс Цинь-з асуусан нь: Хэрэв та биеэсээ цорын ганц үс суга татаад хорвоог аварч болох байсан бол та үүнийг хийх үү?” хэмээн асуухад Ян Жү хариуд нь: “Хорвоог ганц үс хялгасаар аварч болохгүй” гэжээ. Цинь-з хэлэхдээ: “боломжтой байсан бол өгөх үү?” гэхэд Ян Жү хариулсангүй тул Цинь-з гараад энэ тухай Мэн Сунь Ян-д ярихад, Мэн Сунь Ян: “Чи багшийн санааг ойлгосонгүй. Би

73 Д.Лүндээжанцан, Н.Жалбажав, Д.Отгонтуяа. Эрх зүйн философи. УБ. 1998. 164-р тал.



чамд тайлбарлаж өгье. Хэрэв арьснаасаа тасдаж өгөөд мянган алтан зоос авахаар байвал чи хийх үү?” гэжээ. Цинь хариуд нь “тэгнэ” гэжээ. Мэн Сунь Ян: “Хэрэв чиний нэг мөчийг таслаж аваад оронд нь бүтэн улс өгвөл тасалдуулах уу, чи?” гэхэд Цин-з дуугүй байсанд Мэн Сунь Ян: “Арьстай харьцуулахад үс юу ч биш. Хэсэг арьс мөчтэй харьцуулахад юу ч биш. Гэтэл нэг дор байгаа олон үс арьсны адил бас чухал. Олон хэсэг арьс хамтдаа бол мөч шиг бас л чухал. Нэг үс биеийн түмний нэг. Тэгэхээр түүнийг тоохгүй байж яаж болох вэ? гэжээ. Иймд Ян Жү: “Хэрэв өөрт нь хор хүргээд хорвоод ашиг болохоор байсан бол эртний хүмүүс үс ч өгөхгүй. Хэрэв тэдэнд хорвоогийн жолоог ав гэвэл тэд авахгүй. Хүн бүр нэг ч үс гэсэн сугалахаас татгалзвал, хүн бүр шагнал болгож хорвоог авахаас татгалзвал энэ хорвоод төгс дэг журам тогтоно” гэжээ. Даосизмын гол бүтээл болох “Дао-дэ-зин” бүтээлд Ян Жү-гийн гол үзэл санаа нь тусгагдсан байдаг. “Бидний амьдрал бол бидний эзэмшил мөн, бидэнд түүний ашиг маш их юм. Хэрэв түүний үнэ өртгөөр яривал Тэнгэрийн хүү байсантай ч харьцуулшгүй. Түүний чухлыг яривал хорвоог эзэлсэн баялагаар ч арилжишгүй. Түүний хадгалагдахыг яривал нэгэн өглөөг алдвал хэзээ ч буцаашгүй юм. Мөн чанарыг таньсан хүн санаа тавьдаг гурван юм ийм байна” гэжээ. Ян Жүгийн энэхүү үзэл санааг ХХ зууны Хятадын гүн ухаантан Фэн Ю Лань: Нэг удаа алдсан эзэнт улсыг нэг өдөр буцааж болох боловч нэг удаа үхвэл амьдралыг буцааж болохгүй хэмээн яагаад эд юмыг хялайн харж амьдралыг үнэлвэл зохихыг тайлбарласан байна⁷⁴ гээд “Даосизмын философийн гол утга санаа нь амиа аварч хор хөнөөлөөс зайлсхийх санаа юм” гэж нилээд өрөөсгөл дүгнэлт хийжээ. Харин Даосизмын гол төлөөлөгч Ян Жү-гийн дээрхи үзэл санаа нь игоизмыг дээдэлсэн бус, харин бие хүний эрх, оршихуйг хамгаалан, амьдралын үнэ цэнийг дээдэлсэн үзэл санаа хэмээн үзэх нь илүү үндэслэлтэй байна.

Дорнодахины төр, эрх зүйн сэтгэлгээний онцлог:

**“Хүн тэнгэрийн дор төрж, төрийн дор захирагдана”
гэсэн захирах захирагдах ёсонд үндэслэгдсэн**

**Эрхийг бус, шударга ёсыг нийгмийн хариуцлага хэмээн
ухамсарласан үүргийг дээдэлсэн эрх зүйн сэтгэлгээ
хөгжих үндсийг бүрдүүлсэн**

**Эрхийг бус, үүргийг дээдлэх ёс нь нийгмийн удирдах
удирдуулах жам ёсны зайлшгүйг ухаарсан ёс заншил,
өвөрмөц сэтгэлгээнд үндэслэгдсэн**

74 Фэн Ю Лань. Хятадын философийн товч түүх. Ихэсэг. УБ. 2000.36-37-р тал.

2. МОНГОЛЫН ЭРХ ЗҮЙН СЭТГЭЛГЭЭНИЙ УГ СУРВАЛЖ

Монголчуудын ертөнцийг үзэх үзлийн, ялангуяа төр, эрх зүйд хандах сэтгэлгээний уг сурвалж нь юуны өмнө мөнх тэнгэрийг шүтэх үзэл байсныг монголын түүхэн эх сурвалжууд нотолж байна. Тухайлбал:

“Монголын Нууц Товчоо” түүхэн эх сурвалжид: “Тэнгэр газар эелдэж, Тэмүүжинг улсын эзэн болготугай” гэж зарлигдав гэсэн бол Монголын их эзэн Чингис хаан хэлэхдээ:

“Эрэмгий сайнаар
Эзэн эс боллоо, би.
Эрхт тэнгэр
Эцгийн хайраар
Эзэн боллоо, би.
Эцэг тэнгэрийн ачаар
Эсрэг дайснаа дарлаа, би” гэжээ.

Монголчууд яагаад мөнх тэнгэрийг шүтэх болов? Мэдээж юуны өмнө доктор Г.Лувсанцэрэнгийн: “Байгальтай зохицон аж төрөх ёсны нэг илрэл нь Тэнгэр, Газрын нэгдлийг голчоор баримтлах үзэл, дадал болно. Газар дэлхий, Агаар тэнгэр хоёр үзэгдэл үйлчлэлийн нягт уялдаатай, байгалийн нэгдмэл цогц болох нь ойлгомжтой. Түүгээр зогсохгүй байгалийн бүрдэл хэсэг болсон хүн, түүний үйл ажиллагааг ч уг нэгдэлтэй холбон үздэг байв” гэж хэлсэнчлэн газар зүйн орчин, амьдрах аж төрөх арга, ёс заншил, соёл иргэншил нөлөөлөхөөс гадна монголчуудын ертөнцийг үзэх үзэл сэтгэлгээ нь юмсын мөн чанарт чиглэсэн трансценденталь шинжтэй байсан байна. Энэ талаар судлаач эрдэмтэд хэрхэн тайлбарласаныг авч үзье.

Мөнх тэнгэр гэж чухам юу вэ?

Доктор С.Дулам: “Мөнх тэнгэр бол оюн санааны дээд түвшний үзэгдэл”, доктор Г.Лувсанцэрэн: “Мөнх тэнгэрийн тухай ойлголт нь бүхний язгуур болж, бүхэнд түгээмэл байдаг, энэ утгаараа бүхнийг “амилуулан”, шимэлж өгдөг түгээмэл чанарыг илэрхийлнэ. Ийнхүү Мөнх тэнгэрийн тухай үзэл бол бөө мөргөлийн олон тэнгэрт ёсноос \политеизмээс\ дээш гарсан онол болох юм” гэж мөнх тэнгэрийг шүтэх үзлийг рационал утгаар тайлбарлаж байна.

Харин доктор Х. Сэлэнгэ “Мөнх тэнгэр нь оюун санааны диалектик, объектив субъектив хүчний нэгдэл мөн” гэж үзэж, түүнийгээ хэд хэдэн үндэслэлээр тайлбарласан⁷⁵ байна.

⁷⁵ Х. Сэлэнгэ “ХШ зууны монголын төр, эрх зүйн үзэл санаа, түүний үнэт зүйл” УБ. 2004-номноос үзнэ үү.



Мөнх тэнгэрийг шүтэх үзлийг домог зүй, хэл шинжлэл, гүн ухааны үүднээс тайлбарлавал: Эрхэт дээд Мөнх тэнгэрийн өчиг, санд:

Үнэмлэхүйн дээд Мөнх тэнгэр минь,
Үнэнийг үнэн болгон заяасан тэнгэр минь \өвөрлөгч\
Хамгийн дээд Мөнх тэнгэр минь \халимагт\
Хамаг бүгдийг заяасан тэнгэр минь
Хөдлөхийн дээд хөх Мөнх тэнгэр минь,
Хөдлөх бүгдийг заяасан тэнгэр минь
Хамгийн заяасун Хан Мөнх тэнгэр минь \буриад\
Хөдлөх хөх Мөнх Тэнгэр
Энэ бүгдэсийн заяасан,

Эрхэт Мөнх тэнгэр гэсэн шатлалд доктор С. Дулам хэл шинжлэл, гүн ухааны үүднээс тайлбарлахдаа: “Үнэмлэхүйн дээд” хэмээх нь “үнэн (м) -лэ-х” буюу “үнэн болж биелэх” гэсэн санаа бөгөөд “үнэний биелэл” болохын “дээд” утга нь гагцхүү оюун санааны хүрээнд боломжтой “үнэнийг үнэн болгож заяасан” буюу “үнэний үүсгэл”, “оюуны ургаль болж байдаг”-ыг илэрхийлж байна. “Хөдлөхийн дээд хөх Мөнх тэнгэр”, “Хөдлөх бүгдийг заяасан тэнгэр” гэдэг нь орчихуйн дээд буюу эрчим хөдөлгөөний жам ёсыг дохиолж байдаг гэсэн утга буюу мөнхийн хөдөлгөөний хууль болохыг илэрхийлж байна” гэжээ.

Л.Лоренц: “Мөнх тэнгэр бол ердийн утгаараа Бурхан тэнгэр ч биш, Эзэн сахиус ч биш, Мөнх тэнгэр юмсын гадна, хамгийн дээр оршиж байдаг” гэсэн бол түүхийн ухааны доктор Ч.Жүгдэр: “Тэнгэр хэмээх ойлголтод байгалийн харагдах ба үл харагдах бүх хүчийг хамруулан үзэж байсан” гэжээ. Өөрөөр хэлбэл тэнгэр бол оюун санааны болон материаллаг ертөнцийн нэгдлийг тодорхойлох дээд хүчний нэгдэл болно. Иймд мөнх тэнгэр бол объектив, субъектив шинжтэй.

Доктор Г.Лувсанцэрэн: “Мөнх тэнгэрийн үзэл бол Чингис хааны төрийн үзлийн онолын үндэс мөн гэж хэлэх бүрэн үндэстэй...Мөнх тэнгэрийг шүтэх нь их үйл хэргийн төлөө эрч хүчээ хураан зангидаж, дайчлан илэрхийлэх хүчин зүйл болж байжээ. Төр, түүний эзэн өөрийн туйлын хүслэн болох Тэнгэрлэг чанартаа дүйцэж, түүнийг хадгалан байх гэсэн чармайлт нь төрөө төр шиг байлган барьсан жинхэнэ хаан шиг хаан байхад хөтлөн дуудаж, дайчлан зоригжуулж байжээ.Энэ нь утгаа төр хийгээд хаан өөрийнхөө тэнгэрлэг чанарыг олж, түүндээ хүрч, түүнийгээ илэрхийлж хэрэглэх арга мөн юм. Үнэндээ ч нэгэн тэнгэрт түгээмэл чанарыг шүтэн барих үзэл л нэгдсэн том гүрний төрийн онолын үндэс болсон, үзэл суртал болохоос өөр аргагүй” гэж мөнх тэнгэрийг шүтэх үзэл нь монголын эрх зүйн философийн үндэс болохыг хүлээн зөвшөөрсөн байна.

Монголчуудын эрх зүйн сэтгэлгээний үндэс нь мөнх тэнгэрийг шүтэх үзлээс гадна Алунгоо хатны “Эв эе”-ийг эрхэмлэх сургаал мөн.

“Айл хүний амь нэг, саахалт хүний санаа нэг” гэсэн ардын зүйр цэцэн үгнээс улбаатай Алун-гоо хатны “эв эе”-ийг сахих сургаал нь монголчуудын оюун соёлын илрэл юм. “Эв эе”-ийг эрхэмлэх сургаал нь монголчуудын оршихуй мөнх, хүчирхэг байхын үндсийг илэрхийлжээ. “Эв эе”-ийг сахих сургаал монголчуудын тэнгэрлэг зарчим болохын хувьд овог ургийн бичил нэгдлээс аймаг улсын үзэл баримтлал болж хөгжсөн байна. Иймд доктор Н.Лүндэндорж: “Эв нэгдлийн үзэл санаа-монголчуудын төр ёс, эрх зүйн үзэл сэтгэлгээний язгуур эх сурвалж мөн⁷⁶” гэжээ.

“Эв эе”-ийг эрхэмлэх сургаал

“Эв эе” гэдэг нь нийгмийн хөгжлийг тодорхойлох нэгдлийн буюу арга билгийн шүтэн барилдлагын илрэл

“Эв эе” гэдэг нь монголчуудын хамтран аж төрөх, оршихуйн үндэс”

“Эв эе”-нийгэмшлийн дээд хэлбэр

3. МОНГОЛЫН ЭРХ ЗҮЙН СЭТГЭЛГЭЭ, ТҮҮНИЙ ҮНЭТ ЗҮЙЛ

Монголчуудын эрх зүйн сэтгэлгээ нь нийгэмшиж ирсэн цаг үеэс хөгжсөн, монголчуудын оюун санааны хөгжлийн бүтээгдэхүүн, соёлын нэг хэсэг юм.

Дорно дахины эрх зүйн сэтгэлгээ, түүний нэг хэсэг болох монголчуудын эрх зүйн сэтгэлгээ нь өрнийн эрх зүйн сэтгэлгээ, соёлын нэгэн адил үнэт зүйлийг агуулж байна.

Монголчуудад эртнээс нийгмийн ёс, эрх зүйн хэм хэмжээний үзэл санаа үүсч хөгжжээ. Эрх зүйн талаар монголчуудын сэтгэлгээний уг сурвалж болох ардын сэцэн үгэнд:

76 Н.Лүндэндорж. Төр, эрх зүйн сэтгэлгээний хөгжлийн чиг хандлага. УБ.2002.264-р тал.



“Амраглах гэгч анхны ёс
Мэндлэх гэгч мөнхийн ёс
Зуд нэгэн жилийнх
Журам мянган жилийнх⁷⁷
Төрийн ёс дагаж явбал хүндлэл ихтэй болох
Төв журмыг дагаж явбал

Түмэн зүйлийг мэдэж болох⁷⁸ гэснийг шинжлэн үзвэл хүний ёс, нийгмийн хэм хэмжээ нь хүмүүсийн харилцааны мөнхийн орших ёс бөгөөд энэхүү ёсыг дагаж явбал оюуны болон нийгмийн эрх чөлөөтэй байх үзэл санааг илэрхийлсэн байна. Өөрөөр хэлбэл, хүмүүсийн зан үйлийн ёс журам нь байгалийн хуулийн нэгэн адил зайлшгүй дагаж мөрдөх хэм хэмжээ болохыг монголчууд эртнээс ойлгож, хэрэгжүүлж байсан. Энэ үндсэнд Чингис хаан тархай бутархай олон ханлиг улсыг нэгтгэн нэгэн улс болгохдоо: “Мөнх тэнгэр мөхөс миний биеийг зарлигдан түмэн иргэдийг захируулахаар соёрхов. Тал нутагт одоо болтол ямарч эмх журамгүй учраас ийм зэрэгт хүрсэн ажээ. Үр хүүхэд нь эцэг эхийн үгийг авахгүй, дүү нар нь ахаа дагахгүй, эр нь эхнэртээ итгэхгүй, эхнэр нь эрийнхээ үг даахгүй, дагагсад нь ахлагчаа хүндэтгэхгүй, ноёд нь ард албатынхаа дотор үүрэг гүйцэтгэхгүй, баячууд нь ядуучуудаа тэтгэхгүй, газар сайгүй сэтгэл тайван суухыг бодохгүй, бидний омог аймаг, төрөл угсаатны дэг журам бүр алдагдаж, сүр сүлдгүй болоход хүрч буй. Эдүгээ хүрсэн газар болгонд дураараа авирласан хүмүүн олон. Худалч хулгайч, урвагчид, дээрэмчид хүртэл бий болжээ. Иймээс миний бие ард олныхоо хүсэл захиасыг даган энэхүү мөчид хатуу төв чанга жам ёсоор тэд нарыг засч нэгтгэн энх амгалан зол жаргалыг энэ нутагтаа хүртээн тогтоохыг чармайх ёстой” гэж⁷⁹ хүн өөрийн дур зоргоор байж, хэний ч эсрэг юу хүссэнээ хийх нь ёс журамгүй явдал бөгөөд энэ нь ард түмний хүсэл зоригийн гадуур зүйл учраас нийгмийг засах ёсыг тогтоон, ард түмнийг нэгтгэн тэдэнд сайн сайханыг хүртээх ёстой гэсэн нь эрх зүйн санааг маш тод илэрхийлж, дээд заргач Тататунгад зарлигдахдаа: Би нэгэн “ёс” хэмээх хууль дүрмийг бүтээе гэж бодож байх юм. Энэхүү хууль дүрмээр миний үйлсийг залгамжлагчид бүхэн баларшгүй их судар болгох хэрэгтэй. Таван зуун он, мянган он, түмэн оны хойно миний үндэс суурийг залгамжлахад Чингис хааны хууль дүрмийг баримталж өчүүхэн ч өөрчлөхгүй бол “мөнх тэнгэр” тэднийг тэтгэх болно. Бид нар урт насалж хүн төрөлхтний зол жаргалыг эдэлж чадах магад. Хэрвээ энэхүү хууль дүрмийг чанга сахихгүй бол хаант улс минь бутран сарнихад хүрнэ⁸⁰,

77 Монголын философийн түүх.1-р дэвтэр.УБ.1997.153-р тал.

78 Монголын философийн түүх.1-р дэвтэр.УБ.1997.155-р тал.

79 Ч.Далай.Эзэн Чингисийн гэрээслэл ба эдүгээ миний бодол. Чингисийн туг. УБ.1990. №1.

Сайшаал.“Чингис хааны товчоон.1,2-р дэвтэр.Өвөрмонгол.1987.492-р тал.

80 Перецен.“Чингис хааны байлдааны бодлого ба арга”Өвөрмонгол хэвлэл.1983.114-р тал.

“Бүх улсын доторхи хулгайг цээрлүүлж, худлыг мохоож, үхүүлэх ёстойг үхүүлж, яллах ёстойг яллаж бай. Нийт улсын өмчийг хувааж заргыг шийтгэж, түүнийгээ хөх дэвтэрт бичиж тэмдэглэгтүн. Надтай зөвлөж, Шигихутагийн шийтгээд цагаан цаасан дээр хөх бичиг бичиж дэвтэрлэснийг урагийн урагт хүртэл үүрд хэн ч бүү өөрчилтүгэй” /МНТ.203-р зүйл/ гэж “Их засаг” хуулийг тогтоосон юм. Үүнээс хойш одоог хүртэл монголчууд өөрсдийн дагаж мөрдөх хэм хэмжээнүүдийг /Монгол-Ойрадын хууль, Халх журам г.м хууль тогтоомж/ тогтоон гаргаж, үеийн үед даган мөрдөж ирсэн билээ.

Дээрхи ардын зүйр үгний “төрийн ёс буюу төрөөс тогтоосон хэм хэмжээ хуулийг дагаж мөрдсөнөөр хүндлэл ихтэй болох” гэж үзэж байснаас үзвэл, ёс журмыг дагаж мөрдсөнөөр эрхээ хамгаалуулах, эрх нь зөрчигдөхгүй байх үндэс бий болохыг тодорхойлсон байна. Тийм ч учраас төрийн ёс буюу хуулийг тогтоосон эзнээс эхлэн бүгд дагаж мөрдөж байх хууль дээдлэх зарчмын тухай:

“Цааз хэмээгч эзнээс үүсэн түшмэлээр зарламой

Цаазыг дагах эзнээс эхлэн олон цэрэг дор хүрмой

Цаазыг чангатгах дор эрхбиш урьд эзэн нь сахимой

Цааз барьсан жононгийн дохиог хэн айлгүй зөрчмой⁸¹” гэсэн төрийн хууль бүгдэд ижил үйлчилж, бүх нийтээр дээдлэн, чанд сахин биелүүлэх үзэл санаа Их засаг хуулиас эхлэн өнөөгийн МУ-ын Үндсэн хуульд⁸² тусгалаа олжээ.

Нөгөө талаар монголчууд өөрсдийн оршихуй, хүчирхэг эрхийн хамгаалалттай байх үндсийг тэнгэрлэг ёс - эв эеийг сахих явдал хэмээн үзэж:

“...Хаалгат гэрт суусан

Хатан хүн жаргахдаа

Эр юүгээ сайнд жарга юу

Хамаг бүгд жаргахдаа

Эв эеийнхээ сайнд жаргамуй за”.../Лу.Алтан товч.104-106/

“Хоёр хүн эвтэй болбоос

Төмөр хүрээ мэт бэх

Хорин хүн эвгүй болбоос

Эвдэрхий хүрээ мэт хэврэг

Өнөр хүн эвгүй болбоос

Өнчин хүний элэг болох

81 В.Инжиннаш. Хөх судар. 1179-1180-р тал.

82 1992оны МУ-ын Үндсэн Хуулийн 2, 14-р зүйл.




Олон хүн эвгүй болбоос

Оорцог хүний идэш болох” гэж үзэж байсан нь Монголын нууц товчооноос Оюунтүлхүүр хүртэлхи бүх л сурвалж бичгүүдэд тусгагдсан байдаг. Энэ нь хэдийгээр “та ийм эрхтэй, ийм эрхгүй” гэсэн эрхийн хязгаар, хүний эрхийн тухай тодорхой заагаагүй ч, монголчууд хамтран аж төрөхдөө хоорондоо зохицон эв эеийг хичээн, эрхийг бус үүргийг эрхэмлэх нь тэдний оршихуй, амьдрах чадвартай, хүчтэй байхын үндэс хэмээн үзэн хүний зан үйлийн ёс журмыг илэрхийлэн, эв эеийг сахих явдлыг өрх гэрээс төрийн түвшинд гаргаж тавьсан явдал бол эрх зүйн үзэл санааны чухал үнэт зүйл болно. Иймд “эв эе”-ийг сахь гэсэн тэнгэрлэг зарчим нь монголын төр, эрх зүйн тулгуур зарчим болж иржээ. Энэхүү “эв эеийг сахь” гэсэн сургаалыг орчин үеийн эрх зүйн сэтгэлгээний үүднээс дахин үнэлж, хүний зан үйлийн зайлшгүй дагаж мөрдөх үндсэн хэм хэмжээ /категорический императив, basic norm/ гэж үзэх бүрэн үндэслэлтэй байна.

Хүний зан үйлийн зайлшгүй дагаж мөрдөх хэм хэмжээний үндсийг Германы сонгодог философич И.Кант гаргаж тавьсан бөгөөд түүний үзэл санаанд тулгуурлан Кельзен, Харт гэх мэт судлаачид хөгжүүлсэн билээ. Хүний зан үйлийн зайлшгүй дагаж мөрдөх хэм хэмжээ нь нийгэм, түүх, төрөөс дээгүүр орших бөгөөд хүний амьд байх гэсэн амьдралын зорилгыг өөртөө багтаасан “Өөрт хүсэхгүй зүйлийг бусдад бүү хий” /Т.Гоббс/, “Хүн өөрийн зан үйлийг авч явахдаа бусдад хууль болохуйцаар авч яв, хүн хүндээ хүний ёсоор ханд” /И.Кант/ гэсэн хүний оршихуйн зарчмаар илэрдэг нөхцөлгүй хууль билээ. Энэхүү үзэл санаа дорно дахинд ч байсан /Хятадын Гүнз: “Өөртөө тохиохыг хүсэхгүй байгаагаа бусдад бүү хүс”, Японы хан хүү Сётоку Тайси: “юмсын хамгийн зохистой зөв ёс журам нь зөвшилцөл”/ бөгөөд монголчуудын “эв эеийг сахь” гэсэн сургаал нь дээрхи санаануудтай агуулгаараа ижил байгаа болно. Өөрөөр хэлбэл, харилцан бие биений амьдрах хүсэл эрмэлзлэл, эрхийг хүлээн зөвшөөрч, эв эеийг сахих буюу зохицох гэсэн санааг бүрэн агуулж байгаа тул үндсэн хэмжээний түвшинд үнэлэх бүрэн боломжтой юм.

Хүний зайлшгүй дагаж мөрдөх хэм хэмжээ /Үндсэн хэм хэмжээ/



Монголчууд хүний зан үйлийн зайлшгүй дагаж мөрдөх хэм хэмжээг гаргаж тавьсан явдал нь тэдний эрх зүйн сэтгэлгээний түвшинг тодорхой хэмжээгээр тодорхойлж байна. Учир нь хүн төрөлхтний эрх зүйн сэтгэлгээний хөгжлийн бүхий л үе шатанд хүний эрхийг хамгаалах үүднээс хүмүүсийн өөр хоорондын зохицлыг /эв эеийг эрхэмлэн бусдын эрхийг зөрчихгүй байх үүргийг хүлээх/ хангах гол арга хэрэгслийг эрх зүй хэмээн үзэж ирсэнтэй зарчмын зөрөөгүй байгаа билээ.

Монголчууд “Үнэнийг ологч хууль, үеийг ологч хутга” хэмээн үзэж, хуулийг тогтоосон эзэн хаан ч/ төр/, сайд түшмэл ч, харц ард ч нэгэн адил даган биелүүлж байсан учир “төр төмөр нүүртэй”, “төр төмбөгөр, ёс ёмбогор” гэх болжээ. Үнэн төр ёс нь ёс бусаар хүний эрхэнд халдахыг хориглож, иргэний эрхийг хамгаалж байсан билээ. Тухайлбал, Чингис хаан өрлөг, сайд нартаа хандан: “Дэлхий дахины улс бүхнийг бартал дайлахуй дор бэрх үгүй. Гагц тэнгэрийн доорхи нэгээхэн иргэнийг хилсдүүлэхүй дор хэрсүүлвээс хаан хүмүүний явдал буй за” гэжээ⁸³. Хүний зан үйлийг зохицуулж буй “хууль нь шударга, сургаал нь цэцэн” учир төрт ёсыг урагийн урагт хүртэл үүрд хэн ч өөрчлөлгүй бишрэн дээдлэх ёстой ажээ. Иймд монголчууд хамгийн шударга зүйлийг хууль хэмээн үзэж, түүнийг хэлбэрэлтгүй дагаж мөрдөх үзэл санааг хэрэгжүүлж ирсэн байна.

Монголчуудын эрх зүйн үзэл санаа нь арга билгийн ухааныг удирдлага болгон хүний зан үйлийг дан ганц хатуу чанд хуулиар зохицуулах боломжгүй учраас хүний дотоод мэдрэмж, хүсэл зоригт нөлөөлөх үүднээс “...Дэлхий дахиныг эзлэхүй нь хүмүүнийг эзлэхүй дор буй. Хүмүүнийг эзлэхүй нь хүмүүний сэтгэлийг эзлэхүй дор буй. Хүмүүний сэтгэлийг олвоос даруй дэлхий дахиныг олов хэмээмэй⁸⁴...” хэмээн ёс зүйн хэм хэмжээг хэрэглэж, энэ үүднээс билиг сургаалийг Чингис хаан гаргаж байв. Чингис хаан хуулиар /арга/ хүний гадаад харилцааг, билиг сургаалиар /билиг/ хүний дотоод харилцааг зохицуулж, эрх зүйн болон ёс суртахууны хэм хэмжээг бий болгон хослуулан хэрэгжүүлж байсныг эрх зүйн үзэл санааны онцлог, үнэт зүйл гэж үзэх ёстой.

Эцэст нь дүгнэхэд Монголчуудын эрх зүйн сэтгэлгээ нь эрх зүйн үнэт зүйлсийг агуулсан монголчуудын оюун соёлын үнэт зүйлсийн илэрхийлэл болохын хувьд хүн төрөлхтний сэтгэлгээний үнэт зүйлсийн нэг хэсэг мөн.

Хяналтын асуулт:

1. Өрнийн эрх зүйн сэтгэлгээнээс ялгагдах дорнодахины эрх зүйн сэтгэлгээний онцлогийг тодорхойлно уу.
2. Дорнодахины үүргийг дээдлэх сэтгэлгээг уламжлал, шинэчлэлийн үүднээс тайлбарлана уу?

83 В.Инжиннаш.Хөх судар.1812.

84 В.Инжиннаш.Хөх судар.Өвөхмонгол хэвлэл.1221-1222.



3. “Юмс өөрийн мөн чанар, нэртэйгээ тохирч байх ёстой” гэсэн дорнодахины үзлийг төр, эрх зүйн сэтгэлгээний үүднээс тайлбарлана уу?
4. Монголын эрх зүйн сэтгэлгээний уг сурвалж, түүний онцлогийг тайлбарлана уу.
5. Монголчууд яагаад төрөө шүтдэг байсан вэ? Орчин үед уламжлал, шинэчлэлийн үүднээс энэхүү үзэлд хэрхэн хандах вэ?
6. Монголчууд хуулийг хэрхэн ойлгож, үнэлж байсан вэ?
7. Монголчуудын “Эв эе”-ийг сахь” гэсэн сургаалийг дахин үнэт зүйлийн түвшинд үнэлж, хүний зайлшгүй дагаж мөрдөх хэм хэмжээ гэж үзэж болох уу?

Ном зүй:

1. Бира.Ш. Монголын түүх, соёл, түүх бичлэгийн судалгаа. УБ. 2001
2. Дашням.И. Чингисийн хаант улсын төр, хууль цааз.УБ., 1997.
3. Жамбал. А. Улс төрийн сургаалийн түүх. УБ.2001
4. Жүгдэр.Ч.Монголд феодализм тогтох үеийн нийгэм-улс төр, гүн ухааны сэтгэлгээ./Эртнээс ХIY зуун хүртэл/.УБ., 1987.
5. Жүгдэр.Ч.ХY-XIII зууны Монголын нийгэм-улс төр, гүн ухааны сэтгэлгээний хөгжлийн тойм.УБ., 1984.
6. Жүгдэр.Ч.XIX-XX зууны зааг дахь Монголын нийгэм-улс төр, философи сэтгэлгээний хөгжилт.УБ., 1972.
7. Лүндэндорж. Н. Эрх зүйн сэтгэлгээний хөгжлийн чиг хандлага УБ.2003.
8. Лүндэндорж. Н. Төрийн онол. УБ.2005.
9. Монголын төрийн байгуулал, улс төрийн сэтгэлгээний хөгжил. /МТӨ Ш-МТ ХХ зуун/ 2 боть.УБ., 1995.
10. Монголын философийн түүх.1-р дэвтэр.УБ.1997.
11. Монголын философийн түүх.2-р дэвтэр.УБ.2000.
12. Нарангэрэл. С.Монголын ба дэлхийн эрх зүйн тогтолцоо. УБ. 2001
13. Нарангэрэл. С. Эрх зүйн эх толь бичиг. УБ. 2007
14. Сэлэнгэ. Х. XIII зууны Монголын төр, эрх зүйн үзэл санааны үнэт зүйл. УБ.2004
15. Тэмүүжин. Х. Ёст үг. УБ. 2000.
16. Тэмүүжин. Х. Ёст үг. УБ. 2004.
17. Хавх.Н.Монголчуудын соёл иргэншлийн гүн ухаан.УБ., 1995

Г. САЛБАР ЭРХ ЗҮЙН ФИЛОСОФИ

XVI бүлэг


Нийтлэг эрх зүйн философи үндэс

Зорилго: Нийтлэг эрх зүйн философийн түүхэн гарвал, жишгээр шийдвэрлэх зарчим, түүний онцлог, нийтлэг эрх зүйн орчин үеийн чиг хандлагын талаар эрх зүйн онолын ерөнхий ойлголтыг танин мэдэх

1. СОНГОДОГ НИЙТЛЭГ ЭРХ ЗҮЙН ФИЛОСОФИ

Энэ эрх зүйн гол онцлог нь нийгмийн бүх харилцааг зохицуулсан хэм хэмжээг бүтээх нь хүндрэлтэй гэж үзээд тэрхүү орон зайг нийтлэг эрх зүй буюу шүүхийн жишиг, заншил, эрх зүйн зарчмаар нөхөхийг эрмэлздэгт оршино. Нийтлэг эрх зүй нь шүүхийн шийдвэр, заншил, ерөнхий зарчмуудын цогц бөгөөд өдгөө улам боловсронгуй болж буй эрх зүйн тогтолцоо юм.

Анх Английн философич, хуульч И.Бентам “шүүгч хуулийг бүтээдэг” гэсэн үзэл санааг илэрхийлсэн байдаг. Үндсэндээ нийтлэг эрх зүйг шүүхээс тогтоодог эрх зүй гэж ойлгож болно. Тиймдээ ч нийтлэг эрх зүйн бусад эрх зүйгээс ялгагдах гол онцлог нь хууль тогтоох үйл ажиллагааг хэрэгжүүлж буй субъектын ялгаатай шинж байдаг. Тодруулбал, хэргийг шийдвэрлэх, шийдвэр гаргах замаар шүүхэд хууль тогтоох үйл ажиллагаа хэрэгждэг байна.



Англо-саксоны эрх зүйн бүлд шүүхийн шийдвэрийг эрх зүй гэж үздэг. Шүүгчид нийтлэг шинжтэй шийдвэр гаргадаггүй бөгөөд тухайн маргааныг төгс шийдэх зорилгыг өмнөө тавьдаг.



Нийтлэг эрх зүй нь цогц тогтолцоо болохын хувьд өөрийн гэсэн онцлогтой. Эдгээрийг дор харуулбал:




1. Stare decisis буюу жишгээр шийдвэрлэх зарчим

Шүүхүүд эрх зүйн зөрчил болон түүний хүрээнд үүссэн маргааныг шийдвэрлэхдээ хуульд тайлбар өгөх шаардлагатай болдог. Ингэхийн тулд өмнө нь бусад ижил төрлийн болон дээд шатны шүүхүүд хэрэг маргааныг шийдвэрлэхдээ хуулийг хэрхэн тайлбарлаж байсныг судалдаг. Энэ нь шүүх байгууллагын залгамж чанар, урьдчилсан тодорхой байх зарчмыг хангахад ихээхэн түлхэц болдог байна.

Энэ зарчим нь нийтлэг эрх зүйн амин чухал хэсэг бөгөөд шүүхийн шийдвэр нь зөвхөн тухайн маргаанд оролцож буй талуудад хамааралтай бус, цаашид энэ төрлийн хэрэг маргаанд баримтлах жишиг болж үйлчлэх тухай нийтлэг эрх зүйн ерөнхий зарчим юм.

Жишгээр шийдвэрлэх зарчим нь шүүгчид дараах давуу талыг олгодог.



Эндээс үзвэл прецедентын гол ач холбогдол нь тухайн шийдвэр өөрөө биш, харин түүний үндэслэл байдаг. Жишгээр шийдвэрлэх зарчим нь прецедент дээр

үндэслэн хэрэгждэг. Эндээс дүгнэвэл, нийтлэг эрх зүй нь шүүгч прецедентийг баримтлан шийдвэр гаргах замаар буюу жишгээр шийдвэрлэх зарчмаар дамжин хэрэгждэг байна.

Түүхэн үүднээс авч үзвэл, адил төсөөтэй хэргүүдийг шийдвэрлэх үлгэр жишээ шүүхийн прецедент Англид үүсч хөгжсөн ба 1150-иад оны үед Хэнри II хааны үед эхлэл нь тавигдсан гэж үздэг.

Эрх зүйд шинэчлэл авчирсан хэмээн нэр нь дуурссан Хэнри II хааны үед шүүхийн шийдвэрүүдийг шийдсэн хэргийн төрлөөр нь ангилан ялгаж, каталогизуулах ажлыг хийсэн байна. Хожмоо шүүхүүд ижил төсөөтэй хэрэг маргааныг шийдвэрлэхдээ өмнөх шийдвэрүүдийг хянаж, хэрэг шийдвэрлэсэн зарчмыг авч хэрэглэж эхэлжээ. Ийнхүү жишгээр шийдвэрлэх зарчим хэрэгжиж эхэлсэн байна.

Тэр үеийн нийтлэг эрх зүй нь харьцангуй өндөр түвшинд хөгжсөн, хэрэглэж буй эрх зүйнхээ талаарх нарийн гүнзгий ойлголтуудыг аль хэдийнэ бий болгосон байв. Тухайн цаг үед хуульчид, шүүгчид, парламентын гишүүд зэрэг хуулийн хэрэглээнд дадлагажсан хүмүүс олон, харин эрх зүйн онолчид, философичид хангалттай байсангүй. Тийм ч учраас нийтлэг эрх зүй практикт тулгуурлан хөгжих боломж бүрдсэн байна. Улмаар нийтлэг эрх зүйн тогтолцоо 500 гаруй жилийн турш хангалттай сайн хөгжиж, тогтвортой үйлчилсээр ирсэн ба Английн колончилолын нөлөөгөөр Америк болон бусад улсад дэлгэрчээ.

Нэгэнт эрх зүйн маргааныг шийдвэрлэсэн бол энэ нь бусад фактуудад хэрэглэгддэг, шүүх ч дараа дараагийн хэрэг маргааныг шийдвэрлэхдээ тухайн адил төсөөтэй маргаан дээр цаг дэмий үрэх шаардлагагүй гэж үздэг. Жишгээр шийдвэрлэх зарчим нь тууштай мөрдөгддөг, шүүгчид ч энэхүү сайтар бэхэжсэн заншлыг зөрчихөөс цааргалдаг боловч бүхий л шүүхийн шийдвэр үүрд өмнөхтэйгээ адил гарна гэсэн үг биш юм.

2. Сонгодог нийтлэг эрх зүйн философи

Сонгодог нийтлэг эрх зүй нь эрх зүйг хүсэл зориг, мөн чанарын илэрхийлэл гэхээсээ илүүтэй түүнийг бодит амьдрал дээр туршиж, нарийн чанд ухан ойлгосны үндсэн дээр хэрэгжих ёстой гэж үздэг ба “заншил”, “прецедент” гэсэн нэр томъёо чухал үүрэгтэй хэрэглэгддэг.

Эрх зүйг ягштал мөрдөгдөх хэм хэмжээнүүдийн нийлбэр бус, харин ч заншил, хэрэглээ, туршлага дээр суурилсан бодит сэтгэлгээний хэв маяг гэж үзэх ёстой хэмээн 1765 онд Английн хуульч, шүүгч Уильям Блэкстоун “Английн эрх зүйн тухай тайлбар” номдоо бичжээ.



Түүнчлэн 1610 онд Томас Хэдли Английн парламентад тавьсан илтгэлдээ “... нийгмийн өдөр тутмын амьдралд үүссэн аливаа асуудлын дотор нь орж, ажиглагдаж, танигдсан “зөв хэрэглээ” бол нийтлэг эрх зүй юм гэсэн байдаг.

“Заншил” Сонгодог нийтлэг эрх зүйн онолчид нийтлэг эрх зүй бол төрт улсын нийтлэг заншил юм гэж үздэг. Томас Хэдли, Уильям Блэкстоун, Мэтью Хэйл зэрэг эхэн үеийн онолчид энэхүү үзлийг дэмжсэн байна.

Тэд нийтлэг эрх зүйг цаг хугацааны шалгуурыг давж чадсан маш эртний эрх зүй хэмээн тайлбарладаг. 1610-аад онд Английн хааны танхимын ерөнхий шүүгчээр ажиллаж байсан улс төрч, барристер Сэр Эдуард Көүк “нийтлэг эрх зүйн ихэнх гол номлол, дүрмүүд эртний Ромын үеэс хойш өөрчлөгдөлгүй хадгалагдаж ирсэн” гэжээ. Тухайн цаг үеийн Английн нэртэй хуульч, шүүгч Мэтью Хэйл нийтлэг эрх зүй нь хүч чадал, зүй ёсны шинж чанараа дани, саксон, нормандчуудын өвлөн авчирсан соёл заншлаас бус, харин түүнийг нь хүлээн зөвшөөрч, баталгаажуулсан Англи улсын ачаар олж авсан гэж тайлбарладаг.

Мэтью Хэйлийн үзсэнээр нийтлэг эрх зүйн хүлээн зөвшөөрөгдөх хүч чадал дараах гурван нөхцөлөөс хамааралтай ажээ.

Нэгдүгээрт, нийтлэг эрх зүй нь түүхэн залгамж шинжтэй. Түүхэн хугацааны туршид олон өөрчлөлт явагдаж, үүний үр нөлөөгөөр томоохон цогц эрх зүй болон хөгжсөн.

Хоёрдугаарт, энэхүү залгамж шинж нь хэсгээс бүхэл рүү шилжих явцаас хамааралтай. Нийтлэг эрх зүйн хүчин төгөлдөр үйлчлэх шинж нь хэрэг маргааныг хэн шийдвэрлэсэн, хэзээ шийдвэрлэсэнд бус, харин хаант улсад хэрхэн хүлээн зөвшөөрөгдөж чадсанд оршиж байна. Шүүхийн шийдвэр, номлол, практик нь нэгэн бүхэллэг шинжийг олж байгаа нь тэдгээрийн үүсэл гарлыг бус, нэгдэн нийлэх үйл явцыг анхаарахад хүргэж байна.

Нийтлэг эрх зүйн философид заншил, статут, шүүхийн шийдвэрийн нэгдэх үйл явц нь дан ганц логик дэс дарааллын асуудал бус басхүү практикийн шинжтэй зүйл гэж үздэг.

Гуравдугаарт, энэхүү нэгдмэл бүтцийг бодит амьдралд хэрэгжүүлэх үйл явц чухал. Аливаа эрх зүй нийгмийн амьдралд хүлээн зөвшөөрөгдөх ёстой. Нийтлэг эрх зүй нь энэхүү шалгуурыг бүрэн дүүрэн хангаж чаддаг. Учир нь нийтлэг эрх зүй нь өөрөө нийгмийн амьдралаар бүтээгддэг гэж үздэг байна.

“Прецедент” “Шүүгч хуулийг андуурч, эндүүрэх тохиолдол гардаг учраас хууль болон шүүгчийн байр сууринд шалтгаант холбоо үүсдэггүй.” гэж Уильям Блэкстоун үзсэн байдаг. Хэрвээ шүүхээс нэгэнт гаргасан шийдвэрийг эргэж харах боломжгүй, энэ нь ирээдүйн бүх шүүгч нар хэрэг маргааныг шийдвэрлэхдээ тухайн шийдвэрийг л дагаж мөрдөх, түүгээр шийдвэрээ гаргах ёстой гэж үзвэл нийтлэг эрх

зүй нь шалгарсан жишиг байх зарчмаа алдана. Тиймээс шүүхийн шийдвэрийг хатуу тогтоосон прецедент гэж үзэх нь алдаатай юм.

Нийтлэг эрх зүйд үүнийг **res judicata** зарчмаар тайлбарладаг. Энэ нь шүүхийн эцсийн шийдвэр нь тухайн хэрэг маргааныг шийдвэрлэсэн тохиолдлын хувьд заавал биелэгдэх шинжтэй байх тухай зарчим юм.

Харин ирээдүйд тухай хэрэг маргаантай төстэй асуудлыг шүүх дахин шийдвэрлэх тохиолдолд өмнөх шүүхийн шийдвэрийн үндэслэл, дүгнэлтийн ач холбогдлыг харгалзан үзэх учиртай юм. Шүүхийн эцсийн шийдвэр гарах хүртэлх шатанд шүүхүүд өмнөх шатны шүүхийн шийдвэрийг нягтлах боломжтой байдаг.

Эндээс үзвэл прецедент нь шууд утгаараа хууль биш боловч хуулийн үндэслэл болж байна. Сонгодог нийтлэг эрх зүй нь үргэлж хуулийг хатуу ягшсан номлол, дүрэм журмаар тодорхойлохын эсрэг байсаар ирсэн. Өөрөөр хэлбэл эрх зүй нь дүрэм, журам, хуулиудын бүрдэл бус, харин бодит учир шалтгааны практик үндэслэл юм.

Практик үндэслэл нь өөрөө нийгмийн дэг журмыг бий болгодог гэж сонгодог нийтлэг эрх зүй үздэг байна. Заншил, хэм хэмжээг томъёолж болох ч энэхүү томъёолол нь тэр чигтээ заавал дагаж мөрдөгдөх шинжийг агуулдаггүй.

Прецедентийн заавал биелэгдэх шинж нь дараах байдлаар илэрлээ олдог.

1. Өмнөх шүүхийн шийдвэрүүд нь хэрэг маргааныг хэрхэн шийдэж, ямар үр дүн гаргасан гэдгээрээ бус, харин дараагийн шүүх хэрхэн хэрэглэж шийдвэр гаргасан гаргасан бэ гэдгийг чухалчилдаг.
2. Бие даасан эрх зүйн маргаанууд нь хэм хэмжээ тогтоосон шинжгүй байдаг. Эдгээр нь эрх зүйн оновчтой үндэслэл гарган илэрхийлэхэд л хэрэглэгддэг.
3. Өмнө шийдэгдсэн хэргүүд нь дараа дараагийн хэргүүдийг шийдэхэд хянамгай хандаж, олон талаас нь эргэцүүлэхэд саад болдоггүй. Харин ч үндэслэл, шалтгааныг илүү сайтар тогтоох боломжийг олгодог. Хэрэг маргааныг шийдвэрлэсэн өмнөх шүүхийн томъёолол, баримталсан үндэслэл нь тухайн шийдвэрт үлдэх ба эцсийнх гэж тооцогдохгүй.

Энэ үүднээс прецедентийг жишиг болгон хэрэглэх зарчмыг тайлбарлаж болно. Ирээдүйд хэрэг маргаан шийдвэрлэх шүүгч нь өмнөх шүүхийн шийдвэрүүдийг дэнслэн үзэх боломж хэзээд нээлттэй гэсэн үг юм.

АНУ-д олон муж улсын хувьд тэдгээрийн хууль тогтоомж гэрээнээс үүдэн гарч болох хүндрэл нэг бүрт тохирох дүрэм журам боловсруулж хүчрэхгүй байгаа тул нийтлэг эрх зүй нь гэрээнээс үүдсэн маргааныг шийдвэрлэхэд чухал үүрэг гүйцэтгэсэн хэвээр байна.



2. НИЙТЛЭГ ЭРХ ЗҮЙН КОНВЕНЦИАЛИЗМ

1. Нийтлэг эрх зүйн конвенциализмын онол дараах зүйлст анхаарлаа хандуулдаг.

1-рт, нийтлэг эрх зүйн конвенциализм нь ихэнх позитивист онолуудын хүлээн зөвшөөрдөг эрх зүйн загвараас татгалздаг. Позитивист загвараар бол эрх зүй нь дүрэмжсэн заавар юм. Эдгээр заавруудын бодит байдал, үндэслэл, агуулгыг бие даасан шалгуураар тодорхойлдог. Нийтлэг эрх зүйн прецедентыг эрх зүйн нэг эх сурвалж гэж үздэг ч энэ загвартай нийцдэггүй.

Нийтлэг эрх зүйн конвенциализмын зарчим нь орчин үеийн нийтлэг эрх зүйд давамгайлж буй онолын урсгал юм. Нийтлэг эрх зүйн конвенциализмын онол нь эрх зүйг нарийн зохион байгуулалтад орсон тохиролцоонуудын цогц гэж үздэг.

Орчин цагийн нөлөө бүхий нийтлэг эрх зүйн онолч Лон Фүллэр “Эрх зүйн шинжилгээ” /The Anatomy of Law/ номдоо “шүүхийн шийдвэр нь ямагт тайлбарласан шинжийг агуулж байдаг” гэж бичсэн байдаг. Үүнийг тодруулбал, нийтийн эрх зүйн конвенциализм нь анхаарлаа хууль тогтоогч байгууллагуудын дүрэмжсэн заавар болох хуулиудаас холдуулж, хууль доторхи бодит учир шалтгаан руу хандуулдаг. Энэ үзлээр эрх зүй нь тохиролцоо, тэр дундаа практик дээр хэрэгжсэн дэг журам юм.

2-рт, нийтлэг эрх зүйн конвенциализм нь Х.Л.Хартын дэвшүүлсэн эрх зүйн тохиролцоот үндэс суурийн тухай онолоос тэс өөр юм. Хартын онолоор эрх зүйн дэг журам заавал олон нийтийн амьдрал дээр хэрэгжсэн тохиролцоонуудаас бүрдэх бус тогтолцооны хувьд зөв зохистой дэг журмуудаас бүрдэж болдог ба тухайн дэг журмыг хүлээн зөвшөөрөгдөхүйц нийтлэг зарчмаар тодорхойлж болно гэж үздэг. Хүлээн зөвшөөрөгдөхүйц зарчим нь өөрөө нийгмийн факт, тэр дундаа албан тушаалтнуудын ердийн практикийн тухай факт юм. Энэ үүднээсээ түүний хүлээн зөвшөөрөгдөх байдал хууль хэрэглэх эрх бүхий албан тушаалтнууд, зарим хуульчдын үйл ажиллагаагаар хязгаарлагддаг байна. Үүнийг формаль буюу хэлбэрийн конвенциализм хэмээн нэрлэдэг ба эсрэгээр нийтлэг эрх зүйгээр хэлбэржсэн эрх зүйг материаллаг конвенциализм хэмээн нэрлэж байна.

2. Орчин үеийн нийтлэг эрх зүйн конвенциализмын онолоор эрх зүй нь хоёр хэлбэрийн тохиролцоог агуулж байдаг.

- Эрх зүй бол бодит практик дээр үндэслэж биеллээ олсон заншлуудын нийлбэр.
- Оршин байх эсэх нь нийгэм дэх илүү өргөн хүрээний практиктай уялдах, нийцэх эсэхээс шалтгаалдаг.

3. Нийтлэг эрх зүйн конвенциализм нь эрх зүйг дараах аргачлалаар бүтээдэг гэж үздэг.

Нэгдүгээрт, нийтлэг эрх зүйн прагматик мөн чанар нь бодит амьдрал дээрх асуудлуудыг хэрхэн шийдвэрлэх тухай үндэслэл, нотолгоог голлон анхаардаг. Бодит амьдрал дээрх асуудлууд нь улс төрийн номлол, сургааль болон нийгмийн амьдралын өргөн хүрээг хамарч чаддаг гэж үздэг.

Хоёрдугаарт, эрх зүйн практик үндэслэлийг түүхэн шинжтэй гэж үздэг. Хууль тогтоох үйл ажиллагаа болон прецедент бүтээж буй шүүхийн шийдвэрүүд нь бүгдэд ил тод байдаг учраас иргэдийн анхаарлын төвд байж, тэд энэ талаар өөрсдийн үндэслэл, нотолгоогоо санал болгох боломж нь нээлттэй байдаг гэж үздэг.

Гуравдугаарт, учир шалтгаан, үндэслэл нотолгоог хангалттай гарган илэрхийлсэн хэм хэмжээнүүдийн гол ялгарах онцлог нь оюун сэтгэлгээний техникт оршдог гэж үздэг. Шүүгчийн дотоод итгэл үнэмшил нь үүнийг шаарддаг ба нийтлэг эрх зүйг бүтээхэд гол үүрэг гүйцэтгэдэг.

Дөрөвдүгээрт, эрх зүйг нийгмийн амьдралд үндэслэлтэйгээр хэвшүүлэн мөрдөх үйл явц нь гол төлөв нийтийн хүч хөдөлмөрөөр бүтдэг гэж үздэг. Өөрөөр хэлбэл нийтлэг эрх ашигт нийцүүлэн бодож сэтгэх, маргаж мэтгэлцэх, шийдвэр гаргах үйл явцаар дамжин эрх зүйг бүтээдэг гэж үздэг байна.

Тавдугаарт, энэхүү нийтийн үйл ажиллагааг олон нийтээр дахин хэлэлцүүлдэг. Энэ нь иргэдийн анхаарлыг татаж, улмаар нийгмийн салбар бүрийг төлөөлсөн илүү олон хүн оролцох боломжийг бүрдүүлдэг гэж үздэг.

Харин Х.Л.Хартын хэлбэрийн конвенциализм нь эрх зүйн тохиролцооны үүрэг ролийг үнэмлэхүй бага түвшинд байлгахад чиглэгддэг. Эрх зүй бол тохиролцоон дээр тулгуурладаг. Үүнийг урвуу пирамидтай зүйрлэж болно.





Хэлбэрийн конвенциализм нь эрх зүйг иргэдийн амьдралтай нийцүүлэхэд чиглэсэн буюу эрх зүйн дотоод уялдааны талаарх тохиролцоо гэж үздэггүй. Харин материаллаг конвенциализм нь эрх зүй бол нийгмийн практикт өргөнөөр ашиглагдаж, гүн гүнзгий үндэс суурь хүртлээ хэлбэржиж чадсан байх ёстой гэж үздэг.

Хяналтын асуулт:

1. Stare decisis буюу жишгээр шийдвэрлэх зарчмыг тайлбарла.
2. Нийтлэг эрх зүйн сонгодог үзэл баримтлал ёсоор эрх зүйг хэн, хэрхэн бүтээдэг вэ?
3. Заншил ба прецедентийг харьцуулан тайлбарла.
4. Нийтлэг эрх зүйн конвенциализмын онолтой сөргөлдөгч онолын урсгал юу вэ?

Ном зүй:

1. Francis Bacon “Elements of the Common Laws of England” 1978
2. Lon Fuller “The Anatomy of Law” 1968
3. H.L.A.Hart “Essays in Jurisprudence and Philosophy” 1983
4. H.L.A.Hart “The Concept of Law” 1994
5. Jeremy Bentham “Of Laws in General” 1970
6. William Blackstone “Commentaries on the Laws of England” 1998
7. Jeffrie G. Murphy and Jules L. Coleman. Philosophy of Law. USA. 1990.
8. Jules Coleman and Scott Shapiro. Jurisprudence and Philosophy of Law. Oxford. 2002.

XVII бүлэг

Эрүүгийн эрх зүйн философи үндэс


Зорилго: Гэмт хэрэг ба ялын мөн чанар, агуулгыг эрх зүйн философийн үүднээс танин мэдэх

1. ЭРХ ЧӨЛӨӨ БА ДУР ЗОРГО

Эрх чөлөө ба дур зоргын тухай асуудалд онолын үндэслэлтэй хандаж, орчин үеийн эрх зүйн философи хөгжилд жинтэй хувь нэмэр оруулсан хүн бол Германы сэтгэгч Георг Фридрих Гегель юм.

Тэрээр эрх зүй нь материаллаг бус, оюун санааны үндэстэй гэж үзсэн байдаг.

Гегель эрх чөлөөний үндсийг тайлбарлахдаа чөлөөт хүсэл зориг гэсэн нэр томъёог хэрэглэсэн юм. Үүнийг тухайн үеийн Германы нэртэй философич Иммануэль Кант мөн тайлбарласан байдаг.




И.Кантын үзлээр чөлөөт хүсэл зориг нь хүний ухамсрын факт, практик оюун санааны нотлогдохгүй үнэн байдаг. Харин Гегелийн үзлээр чөлөөт хүсэл зориг нь оюун санааны нотлогдохгүй үнэн, түүнд итгэх зүйл биш, харин туйлын оюун санааны хөгжлийн хамгийн чухал хэсэг байдаг.

Мөн И.Кант сэтгэхүй ба хүсэл зоригийг ялгаатай зүйл гэж үзсэн бол Гегель энэ хоёр нь нэгдмэл зүйл хэмээн тайлбарлахдаа: “Сэтгэхүйгүй хүсэл зориг гэж байх ёсгүй” гэжээ. Тодруулбал хүн гэгч бодгаль нь сэтгэхүй, хүсэл зориг хоёрын нэгдэл болохоос бус сэтгэх чадвартай хэрнээ хүсэл зориггүй, эсвэл хүсэл зоригтой хэрнээ сэтгэх чадваргүй байж болохгүй гэсэн гаргалгааг Гегель хийсэн байдаг.




Ийнхүү сэтгэхүй, хүсэл зориг гэсэн цогцийн дундаас чөлөөт хүсэл зориг бий болдог гэж Гегель үзсэн юм. Үндсэндээ чөлөөт хүсэл зориг бол эрх чөлөө юм гэж тайлбарлажээ.

Ийнхүү эрх чөлөө буюу чөлөөт хүсэл зориг бий болохын тулд тодорхой үе шатыг дамжин хөгждөг гэж Гегель үзсэн байна.




Эндээс эрх чөлөө ба дур зоргын ялгааг харж болж байна.

Гегелийн үзлээр эрх чөлөө нь ухамсарлагдсан зүйл тул түүнийг улам гүнзгий ойлгох тусам хүч чадал нь нэмэгдэж байдаг ажээ. Эндээс эрх чөлөөний талаархи жам ёсны эрх зүй ба Гегелийн үзэл санааны ялгаатай байдал илрэн гардаг.



Ёс суртахууны тухайд Гегелийн үзэл сэтгэлгээ өөрийн гэсэн онцлогтой. Түүний тайлбарласнаар ёс суртахуун нь чөлөөт хүсэл зоригийн гадаад, дотоод бодит ахуйн нэгдэл байдаг.

Түүний үзлээр ёс суртахуун нь тодорхой үе шатыг дамжин илэрдэг байна.



Гегель хувь хүн төрд нэгдэж, иргэний эрх, үүргээ ухамсарлан, хуульд ухамсартайгаар захирагдаж байгаа цагт жинхэнэ эрх чөлөөтэй байдаг гэсэн юм.

Тэрээр нийгэмд оршин буй чөлөөт байдал бол хэсэг бүлэг хүмүүсийн дур зоргоороо авирлахыг даван туулах явдал гэжээ. Хүмүүсийн хүсэл зоргийн нийгэм дэх хязгаарлал нь гагцхүү эрх зүйгээр зохицуулагдаж, эрх зүйн хэм хэмжээгээр илрэн гарч, эрх зүйн харилцааны хүрээнд л хэрэгжиж байдаг байна.

2. ДУР ЗОРГО БА ГЭМТ ХЭРЭГ

Дур зорго ба гэмт хэргийн тухай философи сэтгэлгээг Гегель хөгжүүлсэн болно. Хүн оюун сэтгэхүйтэй, ухамсарт амьтан болохын хувьд гэмт хэрэг үйлдэх нь хариуцлагагүй үйлдэл гэж үзсэн байдаг.

Ингэснээрээ гэмт хэрэг нь хувь хүний төдийгүй нийт төр улсын хүсэл зоригт харш үзэгдэл бөгөөд түүнийг үгүй хийдэг хэмээн тайлбарласан байна. Гэмт үйлдэл нь хохирогчийн эрхийг үгүйсгэж буй явдал бөгөөд хүний эрх чөлөөг үгүй хийж байгаа явдал ажээ. Бүр тодруулбал хүний чөлөөт хүсэл зоригтой этгээд болохыг нь үгүйсгэж байгаа хэрэг гэж тайлбарласан байдаг.


Америкийн Рид коллежийн профессор Петр Ж.Стайнбергер Гегелийн гэмт хэрэг ба ял шийтгэлийн талаархи философи сэтгэлгээ нь үндсэн гурван асуултад хариулахад чиглэсэн гэсэн дүгнэлтийг хийсэн байдаг. Үүнд:

1. Бид яагаад гэмт хэрэгтнийг заавал шийтгэх ёстой вэ?
2. Гэмт хэрэг ба ял шийтгэл нь хоорондоо нийцэж байх ёстой юу?



3. Сэтгэл мэдрэлийн өвчин нь хүлээн зөвшөөрөгдөхүйц хамгаалалтын арга хэрэгсэл мөн үү?

Тэрээр гэмт хэрэг бол гэм буруутай этгээдийн дур зорго гэж үзжээ. Энэхүү дур зорго нь гэмт хэргийн нийгмийн аюулыг илтгэдэг.



Дээрх зураглалыг харцгаая. Гегелийн үзэл санаагаар гэмт хэрэг хүний эрхийг үгүйсгэж байна. Ингэснээрээ чөлөөт хүсэл зоригийн гадаадахуйг мөн үгүйсгэж байна. Иймээс ял шийтгэлийг чөлөөт хүсэл зоригийн гадаад ахуйтай холбоотой хэмээн үзэж, ял шийтгэл нь хохирогчийн эрхийг эргэж сэргээдэг тул гэмт хэрэгтний өөрийн эдлэх ёстой эрх хэмээн тайлбарлажээ.

Үгүйсгэлийг үгүйсгэх шаардлага. Үгүйсгэгдсэн эрхийг сэргээж, бодит эрхийг бий болгож, гэмт хэрэг оршин байхыг үгүйсгэж байгаагаараа ял нь үгүйсгэлийн үгүйсгэл бөгөөд шударга ёсны илэрхийлэл гэж Гегель үзсэн байдаг. Иймд ял оноох замаар гэмт хэргийг үгүйсгэх нь хууль ёсны төдийгүй эрх зүйг бэхжүүлэхэд зайлшгүй чухал гэжээ.

Ял шаардах эрх. Гэмт этгээд оюун ухаантай, сэтгэх чадвартай, ухамсартай субъект болохын хувьд өөрийн үйлдлийн зөв, бурууг болон үйлдлийн үр дагаврыг ойлгон ухамсарлах чадвартай учир ял шаардах эрхтэй гэж Гегель үзсэн байдаг.

Гэмт этгээд гэм буруугаа ойлгож, үүргээ ухамсарлан, өөрийн үйлдлийн үр дагавар болох ял эдлэх зайлшгүй шинжийг хүлээн зөвшөөрч ял шаардаж буй нь түүний чөлөөт хүсэл зоригтой, эрх чөлөөтэй субъект болохыг нь илэрхийлдэг байна. Хэрвээ гэмт этгээдийн энэхүү ял шаардах эрхийг үгүйсгэвэл түүнийг чөлөөт хүсэл зоригтой, эрх чөлөөтэй субъект болохыг нь үгүйсгэж буй хэрэг болно.

Гэмт этгээдийн өөрөө өөртөө ял ноогдуулах эрхийг нь хасвал эрх чөлөөг нь хязгаарлаж буй хэрэг. Эрх чөлөөг хязгаарлана гэдэг бол уг гэмт этгээдийг ухамсартай, оюун ухаантай хүнийх нь хувьд авч үзэхээс татгалзаж буй хэрэг юм.

Энэхүү үзэл санаанаас ургуулан бодвол ялтан эрх чөлөөтэй байж болох эсэх тухай асуулт гарч ирдэг. Гегель “Шийтгэгдэж буй гэмт хэрэгтэн оногдуулсан ялыг эрх чөлөөг нь хязгаарлаж байгаа мэт үзэж байлаа ч, үнэн хэрэгтээ уг ял нь түүний өөрийн үйлдлийн үр дагавар юм. Үүнийг тэрээр хүлээн зөвшөөрснөөр эрх чөлөөтэй хүн мэт биеэ авч явна” гэжээ.

3. ЯЛЫН ФИЛОСОФИ

Эртний грекийн сэтгэгч Платон ял бол гэмт этгээдийн эрх ашиг гэж үзжээ. Ял бол эцсийн дүндээ тухайн буруутай этгээдийн ёс суртахууныг хөгжүүлэх арга хэрэгсэл юм гэж тайлбарласан байдаг.

Мөн ялын философийн талаар сэтгэгч Чезаре Беккариа хэлэхдээ гэмт этгээд үйлдсэн хэрэгтээ ял оногдуулахыг хүлээн зөвшөөрөх нь зөв юм гэж үзсэн байна. Тэрээр төрт улс байгуулагдах үед нийгмийн гэрээ байгуулж гэмт этгээд өөртөө ял оногдуулахыг хүлээн зөвшөөрдөг гэж үзсэн байдаг. Орчин үеийн нийтийн эрх зүйн үзэл сэтгэлгээ ч мөн адил хувь хүн нийтийн хүсэл зоригийг үндэслэн өөрийн эдлэх эрхээ төрд даатгадаг гэж тайлбарладаг нь түүний үзэл санааны үргэлжлэл юм.

Харин Гегель гэмт хэрэг үйлдсэн үйлдлээрээ л гэмт этгээд өөртөө ял оногдуулахыг хүлээн зөвшөөрдөг гэж үзжээ.

Гэмт этгээдийн ял шаардах эрхийн тухай үзэл санааны үүднээс Гегель Чезаре Беккариагийн цаазаар авах ялыг үгүйсгэсэн үзэл санааг шүүмжилж байв.

Чезаре Беккариа нийгмийн гэрээний онолын үүднээс “Хууль бол ганц нэгээрээ бас дээр нь өөрийн эрхээр амьдарч байвч үргэлжийн дайн самуун, нэгэнт баталгаажуулаагүй болохоор ямар ч үр ашиггүй эрх чөлөөнөөс залхсан хүмүүсийн нийгэмд нэгдэх гэрээ болой. Тэд эрх чөлөөнийхөө өчүүхэн хэсгийг золиослоод хариуд нь үлдсэн хэсгийг нь айх аюулгүй, тайван эдлэх боломжийг олж авсан юм. Өөрийн эрх чөлөөний өчүүхэн хэсгийг алдахгүйн тулд хамгийн чухал эрх болох амьд явах эрхийг золиослох хүн байх уу? Нийгэм өөрийгөө бүрдүүлдэг хүнээ ална гэдэг хачирхалтай эрх шүү” хэмээн цаазаар авах ялыг хууль ёсны бус гэж шүүмжилсэн.

Нөгөө талаар нийгмийн гэрээнд хүнээс салгаж үл болох амьд явах эрхийг хамгаална гэж заасан атлаа цаазаар авах ялыг хүлээн зөвшөөрөх нь зүй ёсны бус хэмээн үзсэн юм.

Гегель

- Ял шударга байх ёстой. Ялын хэмжээ нь үйлдсэн гэмт хэрэгтэйгээ дүйцэх ёстой. Ял нь өр төлөөс юм.

Кант

- Ял бол нөхөн төлөөс юм

Беккариа

- Гэмт этгээд өөрийн хийсэн үйлдэлдээ ял оногдуулахыг хүлээн зөвшөөрөх ёстой. Гэхдээ цаазаар авах ял бол байж болшгүй зүйл.

Гегель эртний Грекийн сэтгэгч Платоны нэгэн адил ялын зорилгыг авч үзэхдээ: ял нь айлган сүрдүүлэх эсвэл, засан хүмүүжүүлэх зорилготой бол эрх зүйн



ямар ч үр дүнд хүрэхгүй хэмээн ялын ашигтай байх шинжийг үгүйсгэж, ялын мөн чанартай зөрчилдөнө хэмээн үзэж байв. Өөрөөр хэлбэл, ял нь ашигтай байх зарчимд үндэслэгдэж болохгүй юм. Иймд ялын зорилго нь үнэн, шударга ёсыг тогтоох явдал гэж үзсэн.

Ял нь зөвхөн гэмт хэрэг үйлдэгдсэн тохиолдолд яригдах зүйл юм. Орчин үеийн эрүүгийн эрх зүйн философид үүнийг тайлбарлахдаа зоосны хоёр талтай адилтгаж үзжээ. Зоосны нэг талд гэмт хэрэг байгаа бол түүний нөгөө талд ял шийтгэл байх нь зүйн хэрэг гэж үзсэн байна. Эцсийн дүндээ ялын бодлого нь тухайн гэмт хэрэгт тохирсон ял л оногдуулах ёстой. Түүнээс хүнд, эсвэл хөнгөн ял байж болохгүй гэж үзэхэд оршдог юм.

Хяналтын асуулт:

1. Дур зорго, эрх чөлөөнөөс ямар ялгаатай вэ?
2. Гэмт хэргийг оюун ухаантай хүний үйлдлийн илрэл гэж үзэж болох уу?
3. Гэмт хэргийн мөн чанар, шинжийг эрх зүйн философийн үүднээс тайлбарлана уу?
4. Ял мөн чанар, шинжийг эрх зүйн философийн үүднээс тайлбарлана уу?
5. Ялыг яагаад шударга ёстой адилтгадаг вэ?
6. Ялын шударга байх үндэслэлийг тайлбарлана уу?
7. Санамсаргүй үр дагаварт субъектив байдлаар хандаж болох уу?
8. Чөлөөт хүсэл зоригийн тухай И.Кант, Г.Ф.Гегель нарын үзэл санааны ялгаатай талыг тайлбарлана уу?
9. Гегелийн сэтгэлгээн дэх үгүйсгэлийг үгүйсгэх шаардлагын тухай ярилцана уу.

Ном зүй:

1. Гегель. Соч. Т. VI. Стр. 80
2. Brown, Stephen Paul, (2001), Punishment and the Restoration of Rights □ Punishment and Society, 3 (4);
3. А.А.Пионтковский. Учение Гегеля о праве и государстве. М. 1993
4. Hegel, Die Philosophie des Geistes, S. 309
5. Гегель. Энциклопедия. Т. I
6. Гегель Г. Философия права. М. 1990.
7. Чезаре Беккариа. Гэмт хэрэг ба ялын тухай. Орч. Г.Эрдэнэбат. УБ. 2007
8. Jeffrie G. Murphy and Jules L. Coleman. Philosophy of Law. USA. 1990.
9. Jules Coleman and Scott Shapiro. Jurisprudence and Philosophy of Law. Oxford. 2002.
10. Kaufmann.A. Rechtsphilosophie.1997

XVIII бүлэг Хувийн эрх зүйн философи үндэс

Зорилго: Хувийн эрх зүйн философийн үндэс, онолын чиг хандлагуудын онол арга зүйн онцлогийг танин мэдэх

1. ХУВИЙН ЭРХ ЗҮЙН ОНОЛЫН ЧИГ ХАНДЛАГА

Хувийн эрх зүйн философи чиг хандлага өнөөдөр үндсэн хоёр онолын урсгал дээр төвлөрөн хөгжиж байна. Үүний нэг дэх нь эрх зүй ба эдийн засгийн онол юм. Эрх зүй ба эдийн засгийн онолыг хөгжүүлэгчдийг детеренцийн онолчид гэж нэрлэдэг. Ричард Познер, Стивен Шэвелл, Дуглас Миламед, Роналд Коуз нарыг энд нэрлэж болно.

Энэ онол ёсоор эрх зүй нь үүрэг хариуцлагыг улам бүр чангатгаснаар гэм буруутай этгээдийн үйлдэл тэр хэрээр багасна гэсэн үзлийг тайлбарладаг.

Хоёр дахь нь хууль зүйн залруулалтын онол юм. Жүлэс Коулмэн, Эрнест Вэйриб, Артур Рипштейн, Ричард Эпштейн, Стифен Перри нарыг энд нэрлэж болно.

Деонтик буюу ёс суртахууны үүрэг хариуцлагыг чухалчлах энэ онол ёсоор нэг хүн нөгөөдөө учруулж байгаа шударга бус үйлдлийг нөхөн барагдуулах өртэй үлддэг гэж үздэг. Анх Аристотель Никомахын Этик номынхоо тавдугаар дэвтэрт энэ онолын сонгодог загварыг гаргаж ирсэн бол өдгөө хувийн эрх зүйн онолын урсгалын гол хоёр урсгалын нэг болон хөгжиж байна.

Үндсэндээ хувийн эрх зүй нь хувь этгээдэд иргэний хариуцлага хүлээлгэхэд чиглэдэггүй. Харин хувийн эрх зүйн харилцаанд оролцож байгаа хувь этгээдүүд тухайн харилцааныхаа хүрээнд бие биенийхээ өмнө үүрэг хариуцлагаа ухамсарлах явдлыг нэмэгдүүлэхэд чиглэдэг хэмээн Бенжамин Зипүрски тайлбарласан байдаг. Тэр ч үүднээсээ хувийн эрх зүйн үндсэн тулгуур үзэл нь **private right of action** буюу **бие даан хэрэгжүүлэх эрх** юм. Энэ эрх нь тодорхой хувь этгээд хуулиар хүлээн зөвшөөрөгдсөн хэмжээнд тодорхой арга замаар үйлдэл хийх боломж юм.



1.1. ЭРХ ЗҮЙН ЭДИЙН ЗАСГИЙН ОНОЛ

Энэ нь орчин үеийн хувийн эрх зүйн салбарт хамгийн их нөлөө үзүүлж буй чиг хандлага юм. Хариуцагчаас иргэний нэхэмжлэлээр хохирол гаргуулан авах үйл ажиллагаа нь түүний учруулсан гэм хортой дүйцэж байгаа эсэхэд шүүх анхаарлаа хандуулах ёстой гэсэн утга агуулгыг илэрхийлдэг.

Эдийн засгийн детеренцийн загвар нь хувийн эрх зүйн хэд хэдэн асуудлыг хөнддөг.

Нэгдүгээрт, хувийн эрх зүйг аливаа харилцааг зохицуулагч хамгийн том арга хэрэгсэл гэж үздэг. Хувийн эрх зүйн зарчим нь хувь хүний үйл ажиллагаан дахь ашигт чанарыг гаргах буюу эцсийн дүндээ баялгийн шударга хуваарилалт хийх явдал юм. Энэ эрх зүйн зохицуулах чиг үүрэг нь гэм хорын, гэрээний, эсвэл өмчийн харилцааны бүх үе шатанд илрэн гардаг гэж үздэг.

Хоёрдугаарт, хувийн эрх зүйн хэм хэмжээ нь цэвэр хэрэглээний шинжтэй байдаг. Хамгийн багадаа үнэ цэнэ, агуулга гэсэн хоёр зүйлээр илэрч гарна. Хувийн эрх зүйн хэм хэмжээ нь үндсэндээ эдгээрийн тусламжтай бий болж болох үнэ цэнийн тухай асуудал юм.

Гуравдугаарт, эрх зүйн маргааны хувь хүний удирдлага дээр суурилсан тогтолцоо нь хувийн эрх зүйн болзолт шинж чанар юм. Хариуцлагын хэм хэмжээг зөрчсөнөөс болж тодорхой хувь этгээдэд гэмтэл учирлаа гэж үзвэл энэ нь өөрөө нотолгооны хамгийн том эх сурвалж болох жишээтэй.

Эдийн засгийн онолын үзлээр бол хувийн эрх зүйд хамаарах уламжлалт нэр томъёонууд нь цаад утгаараа нийтийн эрх зүйн тодорхой нэг хэсэг л болж харагддаг. Учир нь баялгийг үр ашигтай хуваарилах төрийн ашиг сонирхол нь түүний тогтоосон хэм хэмжээгээр зохицуулагдаж байна. Гэм хорын эрх зүй, гэрээний эрх зүй, өмчийн эрх зүй зэрэг хувийн эрх зүйн томоохон салбарууд нь хувь хүний үйл ажиллагаанд голлох шинжтэй нөлөөлж байгаа ч агуулгаараа нийтийн шинжтэй зүйлийг л илэрхийлж гэж үздэг.

1.2. ХУУЛЬ ЗҮЙН ЗАЛРУУЛАЛТЫН ОНОЛ

Хувийн эрх зүй, тэр дундаа гэм хорын эрх зүйн эдийн засгийн бус шинжтэй хамгийн нөлөө бүхий онолын урсгал болох хууль зүйн залруулалтын онол нь гомдол гаргагчийн чухал үүрэг ролийг гарган илэрхийлж чадаагүй гэдэг үүднээс эдийн засгийн онолыг шүүмжилдэг.

Хариуцагчид торгууль ногдуулаагүй үед ч хариуцагч нь гомдол гаргагчийн өмнө үүрэг хүлээх ёстой. Үүрэг хариуцлагын харилцан хамааралт мөн чанар нь түүнийг торгуулиас ялгаж өгдөг гэж үздэг байна.

Гэм хор учруулсан этгээд ердөө л ямар нэг төлбөр төлөх тухай асуудлыг тавьснаараа эдийн засгийн детеренцийн загвар нь өөрөө өөрийнхөө үнэ цэнийг үгүй хийж байна хэмээн шүүмжилдэг.

Улмаар гэм хорын эрх зүйг дотроо нэгдүгээр болон хоёрдугаар шинжтэй үүргүүдийг агуулдаг гэж үздэг.

1. Гэм хор учруулахгүй байх үүрэг. Энэ нь зан байдлын хэм хэмжээг бий болгодог.
2. Гэм хорыг засах үүрэг. Хэрэв эхний үүргийг биелүүлээгүйгээс болж гэм хор учирсан тохиолдолд хоёр дахь энэ үүрэг бий болно.

Хоёр дахь үүрэг нь цаад утгаараа хууль зүйн зарлуулалтын зарчмаас үүдэлтэй бөгөөд гэм буруутай үйлдлээсээ болж бусдад хохирол учруулсан бол түүнийгээ арилгах, засварлах явдлыг шаарддаг байна.

1.3. ЭРХ ЗҮЙН ЭДИЙН ЗАСГИЙН ОНОЛ БА ХУУЛЬ ЗҮЙН ЗАЛРУУЛАЛТЫН ОНОЛЫН ЯЛГАА

Эдийн засгийн онолын үүднээс бүхий л хууль зүйн үүрэг хариуцлага нь үнэлэгдэх боломжтой зүйл байдаг.

Хууль зүйн зарлуулалтын онолын үүднээс гэм хорын хариуцлага нь дан ганц үнэлгээний асуудал биш юм. Өөрөөр хэлбэл үнэ өртөг шаардаж байгаа бүхэн хүмүүсийг хариуцлагатай болгодоггүй гэж тэд үздэг.

Энэ хоёр онолын урсгалын аль аль нь хувийн эрх зүй дэх **private right of action** буюу **бие даан хэрэгжүүлэх эрх**-ийг чухалчилдаггүй байна. Эдийн засгийн онолоор хариуцагчийн хохирлыг торгуулиар нөхөн төлөхийг шаарддаг бол хууль зүйн залруулалтын онолоор энэ нь үүрэг хэмээн ойлгогддог.



2. ХУВИЙН ЭРХ ЗҮЙН ГЭРЭЭНИЙ ЗАГВАР

Сэдвийн зорилго: Төр ба хувь хүн хоорондын харилцан тохиролцооны үндсэн дээр бий болсон хувийн эрх зүйн харилцаанд баримтлах зарчимтай танилцана.

Энэ чиглэлээр голлох нөлөө үзүүлсэн сэтгэгчид бол Жон Локк болон Уильям Блэкстоун нар бөгөөд хоёр сэтгэгчийн дэвшүүлсэн үзэл баримтлалаар хувийн эрх зүйн гэрээний загварыг тайлбарлах болно.

2.1. ЖОН ЛОККИЙН СЭТГЭЛГЭЭ

Хувийн эрх зүйн гэрээний загварыг нийгмийн гэрээний онолын нэг хэсэг гэдэг утгаар нь Бенжамин Зипүрски тайлбарласан байдаг. Гэм буруутай этгээдийг шийтгэх, энэхүү эрхээ төрдшилжүүлэх, төр нь эрүүгийн эрх зүйн зарчмаар ялшигтгэл оногдуулах тохиролцооны тухай Жон Локкийн үзэл санааг энэхүү гэрээний загвар хөгжих болсон үндэс суурь гэж үзэж болно. Мөн Жон Локк хувь хүмүүс өөрт нь учруулсан бусад этгээдийн гэм хорыг уучлан залруулах эрхтэй тухай ч Засаглалын тухай хоёр дахь шаштир номдоо өгүүлсэн байна.

Тэрээр хувь хүмүүс өөрт нь учирсан хохирлыг нөхөн төлүүлэх жам ёсны эрхтэй гэж үзжээ. Локк үзэхдээ нөхөн төлүүлэх эрхийг эдлэхийн тулд заавал нийгмийн харилцаанд орох ёстой гэдэг. Үүнийгээ “...хүн бүхэн аль нэгэн нийгэмлэгт орох, эсвэл түүнд нэгдэхдээ өөр төр улсад өөр хүнд хамаагүй, зөвхөн өөрөө л олж авсан тэр зүйлсээ бас өөртэйгээ хамт нийлүүлэн өгдөг. Хэн нэгэн өмчийг хамгаалж зохицуулахын тулд бусад хүмүүстэй хамт нийгэмд элсчихээд тэр нийгмийн хуулиар зохицуулагдах ёстой өөрийн хувийн өмч, өөрийн газар нь харьяат нь болж байгаа төрийнх нь хуулийн гадна байна гэж бодох аваас шууд эсрэг зүйл болно биз.” хэмээн Засаглалын тухай хоёр дахь шаштир бүтээлдээ бичсэн байна.

Үүнийг орчин үеийн эрх зүйн тогтолцоонд хувь хүний гэм буруутай этгээдийг шийтгэх эрхийг эрүүгийн эрх зүйн тогтолцоогоор, гэм хорыг уучлан залруулах эрхийг иргэний эрх зүйн тогтолцоогоор орлуулсан гэж үздэг.

Ж.Локк иргэний эрх зүй нь нөхөн төлбөрийн асуудлыг хариуцах ёстой ба ял шийтгэлийн тухай асуудал бол тусдаа зүйл гэсэн тайлбарыг хийжээ. Хэрэв төр нь иргэний эрх зүйн харилцаанд оролцож байгаа бол энэ нь хохирсон хувь хүний нэрийн өмнөөс хийж буй үйлдэл, харин эрүүгийн эрх зүйн харилцаанд оролцож буй бол энэ нь нийт нийгмийн нэрийн өмнөөс хийж буй үйлдэл хэмээн тайлбарлажээ. Бүр тодруулбал төр нь нөхөн төлбөр, ял шийтгэлийг аль алиныг нь гүйцэтгэж болно гэсэн дүгнэлтэд хүрч байна.

2.2. УИЛЬЯМ БЛЭКСТОУНЫ СЭТГЭЛГЭЭ

Түүний шүүхүүд хэрэг маргааныг хянан шийдвэрлэх замаар гэм хорыг залруулдаг гэсэн тайлбар нь Локкийн үзэлтэй үндсэндээ ижил юм. Илүү анхдагч шинжтэй нөхөн төлбөрийн хэлбэр бол тухайн хэрэг маргааны талууд өөрсдөө энэхүү ажиллагааг хийх явдал юм. Жишээ нь гэр бүлээ гаднын халдлагаас өөрөө хамгаалах, өмчлөлийн газар луу нь зөвшөөрөлгүй орж ирсэн этгээдийг хөөж гаргах гэх мэт. Блэкстоун өөртөө туслах энэ аргыг цэвэр хуулийн дагуух нөхөн төлбөрийн хэлбэр гэж үзсэн байдаг. Мөн зээл олгогч нь өгсөн зээлээ буцаан авч чадахгүй байгаа бол өртэй этгээдийн үл хөдлөх хөрөнгийг мэдэлдээ авах замаар нөхөн төлбөр авч болно гэжээ.

Харин нөхөн төлбөр гаргуулан авах хоёр дахь хэлбэр бол маргаанд оролцсон талууд шүүх дээр очиж хамтран асуудлыг шийдэх замаар хохирлоо тооцуулах боломжтой гэсэн санааг дэвшүүлсэн байдаг.

Иргэний эрх зүй дэх зөрчлийг арилгуулах арга хэмжээ нь төрийн үйл ажиллагаанд хамаарахгүй гэдгийг Блэкстоун зөв тайлбарласан ба шүүхэд хандах замаар төрийг оролцуулан асуудлыг шийдвэрлэж болно гэсэн гаргалгааг хийсэн юм.

2.3. ГЭРЭЭНИЙ ЗАГВАРЫН ҮНДСЭН АГУУЛГА

Өмнө дурдсан бүхнийг нэгтгэн дүгнэвээс ёс зүйн үүрэг хариуцлага нь хувь хүмүүсийн дунд хэлэлцээр, тохиролцооны хэлбэрийг бий болгох үндэс болдог гэсэн үг юм. Хувийн эрх зүй дэх ёс суртахууны үүрэг нь банкинд хадгаламж нээхэд банкны ажилтан, хадгаламж нээлгэх хүн хоёрын гэрээгээр тохиролцоотой адилхан гэж үздэг байна.

Хувийн эрх зүйн гэрээний загварын үндсэн агуулга нь хувь хүн бүр өөрийн гэсэн ашиг сонирхолтой, гэвч тухайн ашиг сонирхлоо хангахын тулд бусдаас ямар нэгэн байдлаар туслалцаа авах шаардлагатай байдгийг чухалчилахад оршдог. Уг туслалцааг төрийн зүгээс үзүүлж болдог гэж үздэг байна. Тодруулбал, гэм буруутай этгээдийн хийсэн үйлдлээс хохирол амссан хүн хариу хатуу арга хэмжээ авахын оронд төрөөс хохирлоо нөхөн төлүүлэх замаар зөрчигдсөн эрхээ сэргээлгэх тохиролцоог хийж болно гэсэн үг юм. Өөрөөр хэлбэл хохирогчийн гэм буруутай этгээдтэй харилцах арга барилын эрсдлийг багасгахын тулд төрийн үүрэг хариуцлагыг нэмэгдүүлэх аргыг санал болгодог байна.

Ийнхүү орчин үеийн хувийн эрх зүйн сэтгэлгээний гол онолын урсгал чиглэлүүдтэй танилцлаа. Эндээ үндэслэн хувийн эрх зүйн онлцог шинж, түүний нийтийн эрх зүйгээс ялгарах байдлыг гарган илэрхийлэх боломжтой боллоо.



Нэгдүгээрт, хамгийн гол ялгаа нь хувийн эрх зүйн ба нийтийн эрх зүйн маргаан дээр илрэн гарч байна.

Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаа нь хариуцагчийн гэм буруутай үйлдлийн эсрэг төрийн оролцоог хэрэгжүүлэхэд чиглэгддэг.

Иргэний хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаа нь хариуцагчийн гэм буруутай үйлдлийн эсрэг хувь этгээдийн оролцоог хэрэгжүүлэхэд чиглэгддэг байна. Иргэний хэрэг шийдвэрлэх үед төр зарим тохиолдолд оролцох боломжтой гэж үздэг ч энэ хэрэг маргаанд оролцож буй төрийн оролцоо нь нийтийн эрх зүйн маргаанд оролцогоос өөр шинжтэй гэж үздэг. Хувийн эрх зүйн маргаанд төр оролцохдоо зөвхөн гүйцэтгэх шинжтэй ажиллагаа явуулдаг байна.

Хоёрдугаарт, нийтийн эрх зүйн болон хувийн эрх зүйн маргааныг шийдвэрлэх процесс нь мөн ялгаатай. Бие даан хэрэгжүүлэх эрхийг зөвхөн хувь хүн эдлэх боломжтой, харин төрд тийм эрх байхгүй. Хохирогчийн сонголт тухайн эрх хэрэгжих эсэхийг шийднэ гэсэн үг юм. Харин нийтийн эрх зүйд хохирогчийн сонголт үйлчилдэггүй. Эрүүгийн хэргийг хянан шийдвэрлэх ажиллагааг явуулах нь зөвхөн төрийн эрх гэж тооцогддог байна.

Хяналтын асуулт:

1. Эдийн засгийн детеренцийн онолын агуулгыг илэрхийлнэ үү.
2. Хууль зүйн залруулалтын онолын агуулгыг илэрхийлнэ үү.
3. Хувийн эрх зүй дэх төрийн оролцооны тухай Жон Локк, Уильям Блэкстоуны үзэл санааг товч илэрхийлж тайлбарлана уу.

Ном зүй:

1. Arthur Ripstein “Equality, Responsibility and The Law” (1998)
2. William M.Landes, Richard A.Posner “The Economic Structure of Tort Law” (1987)
3. Guido Calabresi “The Costs of Accidents” (1970)
4. Steven Shavell “Economic Analysis of Accident Law” (1987)
5. Ronald Coase “The Problem of Social Cost” (1960)
6. Jules L.Coleman “Risks and Wrongs” (1992)
7. Ernest J.Weinrib “The Idea of Private Law” (1995)
8. Jeffrie G. Murphy and Jules L. Coleman. Philosophy of Law. USA. 1990.
9. Jules Coleman and Scott Shapiro. Jurisprudence and Philosophy of Law. Oxford. 2002.

XIX бүлэг

Өмчлөх эрхийн философи үндэс

Зорилго: Өмчлөх эрхийн онолын үндэс, онолын төрөл, урсгал, хувь хүн өмчийн хоорондын харилцан холбоо, хувь хүн өмчлөх эрхийг эдэлснээр түүнд бий болох ашиг тус, үүрэг хариуцлагын талаарх ойлголт болон өмчлөх эрхийг хамгаалах шаардлагыг танин мэдэх

1. ӨМЧЛӨХ ЭРХИЙН ФИЛОСОФИ ҮНДЭС

Английн эдийн засагч, философич Фридрих Хайек “Хувийн өмч бол эрх чөлөөт байдлын хамгийн чухал баталгаа юм” гэсэн нь хувийн өмч болоод эрх чөлөөний хоорондын харилцан хамаарлыг зөв тайлбарлан харуулах онолын ач холбогдолтой өгүүлбэр юм. Өмчлөх эрх нь хувь хүнийг эрх чөлөөний ач холбогдолтой үйлдэл хийхэд нь тус болдог ба дараах гурван үндэслэлээр өмчлөх эрхийн агуулгыг илэрхийлж болно.



1. Хувь хүний хариуцлага

Хувийн өмч хүнийг цаашдын амьдралдаа хариуцлагатай хандахыг шаарддаг. Хүн цаашид амьдарч, амиа тэжээхийн тулд хариуцлага хүлээх ёстойг хувийн өмч шаардаж байдаг. Хүн бол бие махбодь, оюун санаанаас бүтсэн бодгаль учраас бие махбодийн хувьд оршин тогтнохын тулд тодорхой материаллаг боломжийг өөртөө нөхцөлдүүлэх ёстой юм. Өмчтэй байх боломж нь хариуцлагыг хувь хүний мөрөн дээр тохдог. Тодорхой жишээн дээр тайлбарлавал, хэрвээ хүн нэг газар оронд амьдрахыг хүсвэл өөрийн байшинг барих, хоол идэхийг хүсвэл хүнс тарих, дулаацахыг хүсвэл өөртөө түлээ мод хагалах ёстой болдгийг хувийн өмч ойлгуулдаг билээ. Ийм учраас хүнд өмчлөх эрх заавал байх шаардлагатай юм.

Эртний грекийн сэтгэгч Аристотель хувийн өмч нь хувь хүний хариуцлагатай байдлыг хөгжүүлж байдаг тухайд дараах тайлбарыг хийжээ.

нэгдүгээрт, хүн бүр хамтын ашиг сонирхлыг бусдад найдан үлдээж, хөдөлмөрлөхөөс зайлсхийх болсон тэр цагаас хойш өөрт хамааралтай бүхэндээ нийтэд хамаатай бусад ашиг сонирхлоос илүүтэй анхаарал халамж тавих



шаардлагатай болсон нь хувийн өмч үүсэх шалтгаан болсон,

хоёрдугаарт, хэрэв хүн бүр аливааг удирдан зохицуулах өөрийн чадавхидаа найдаж амьдарвал тэнд ямар нэгэн будлиан гарахгүй бөгөөд хүний ажил төрөл, амьдрал нь илүү дэг журамтай болох юм.

гуравдугаарт, энэ утгаараа нийгэмд энх тайван байдал сайн хамгаалагдана гэсэн байна.

Иргэдийн материаллаг ашиг сонирхлын хэрэгцээг төрөөс хангаад байвал тэд өөрсдийн ирээдүйг тодорхойлох сонголтуудаа хийх ёс суртахууны эрх чөлөөгөө алддаг. Энэ нь хүний үйлдэхүй, эс үйлдэхүйгээс үл шалтгаалан хэрэгцээ шаардлагыг хангачихдаг юм гэсэн бодлыг нийгэмд төрүүлдэг байна. Платонист философич гэгддэг Ричард М.Вивер “Бодол санаа үр дагаврыг агуулдаг” номдоо: “Гишүүд нь маргааш юу хийх тухайгаа боддоггүй нийгэм бол эрүүл нийгэм биш, учир нь төр засаг нь нийгмийнхээ гишүүдийн ирээдүйг ямар байхыг бичээд өгчихдөг болохоор тэр юм. Бурхнаас заяасан нөхцөл байдлыг ойлгох чадвар, утгачлан орчуулбал алсын хараа гэдэг бол хувь хүний үнэ цэнийг өсгөх боломж юм” гэжээ.

Хүний амьдралынхаа хэрэгцээг өөрөө хангаж, хариуцлагыг үүрэх эрх чөлөө нь зөвхөн хувийн өмчтэй байх үед л хэрэгжих ажээ. Өмчлөх эрх ба хариуцлагын талаар дараа дараагийн бүлгүүдэд тодорхой авч үзэх болно.

2. Хувь хүний ёс суртахууны үүрэг

Хувь хүн бусдын өмнө хүлээсэн ёс суртахууныхаа үүргийг эрх чөлөөтэй биелүүлэх явдал хувийн өмчтэй байхад хэрэгждэг. Ёс суртахууны шинжтэй, ач холбогдолтой үйлдлүүдийг чөлөөтэй гүйцэтгэх боломж бол ёс зүйн онолын аксиом нь болж байдаг гэж өмчлөх эрхийн философи үздэг.

Энэ тухайд Аристотель хүний хувийн өмчийн эрхээ хэрхэн хэрэгжүүлж байгаад нь ёс зүйн анхаарал тавьснаар бусдыг халамжлах үзэл (altruism)-ийг бодитой хөгжүүлж болно гэж тайлбарлажээ. Тэрээр халамжлах үзлийн нөлөөгөөр нийтийн сайн сайханд хүрэх боломж бүрддэг гэж үзсэн байдаг. Бусдыг халамжлах үзлийг хожмоо А.Комте нарын сэтгэгчид бодит утгаар хөгжүүлсэн байдаг.

Эрх чөлөөний энэ нөхцөл байдал нь хүмүүсийн бусдын өмнө хийж гүйцэтгэх ёстой материаллаг үүргийг анхнаас өөртөө агуулж байдаг. Энэ нь бусдад хэрэгцээтэй байгаа зүйлээр туслах үүргээ сайн гүйцэтгэхийн тулд хүн өөрийнхөө өмчийг чөлөөтэйгээр тэдэнд шилжүүлж болдог байх ёстой гэсэн үг юм.

Хэт их өгөөмөр төр нь өмч эзэмшигчдийг ёс суртахууны хариуцлагатай болох боломжийг үгүйсгэдэг гэдгийг энд дахин дурдах хэрэгтэй болж байна. Энэ талаар Америкийн улс төрийн философич Роберт Нозик “Иргэдийн хөдөлмөрлөж олсон орлогоос татвар авна гэдэг бол хүчээр хөдөлмөрлүүлж байгаатай адил” гэсэн

тайлбарыг хийсэн билээ. Энэ нь хэт өгөөмөр төр иргэдийг өөрсдийнхөө төлөө хөдөлмөрлөх сонирхолтой байх үед нь боолчилж авдаг гэсэн үг бөгөөд тэдгээрийн хөрөнгийг хүчээр буцаан тараадаг гэсэн үг юм.

Эрх чөлөө бол ёс суртахууны хариуцлага хүлээх нөхцөлийг бүрдүүлдэг ба өмчлөх эрх нь эрх чөлөөт байдлын тэрхүү нөхцөл болж байдаг.

3. Хувь хүний хөгжил

Хувь хүний хөгжлийн материаллаг үндэс нь өмчлөх эрхтэй байх үед бий болдог. Хүмүүсийн эрхэлдэг ажлын гол онцлог бол өмчтэй харьцах харьцаа юм. Р.М. Виверын үзсэнчлэн “Өмч эзэмших гэдэг нь хүнийг бүрэн дүүрэн төгс хүн болох хүслийг бий болгодог”. Хүн ямар нэгэн үйлдэл хийхэд зайлшгүй шаардлагатай багаж хэрэгсэл, эд материалгүйгээр бичиж, зурж, барьж байгуулах зэрэг үйлдлийг хийж чадахгүй. Хувийн өмч бол хүний аливаа зүйлийг хийж бүтээх тэрхүү чадварын материаллаг илрэл болдог байна.

Хувь хүний бие даасан байдлын өмчөөр илэрхийлэгдэх материаллаг нөхцөл байдал үгүй болмогц хүний тэрхүү эрх чөлөөт байдал мөн адил үгүй болдог. Социалист эрх зүйн тогтолцооны үед хувь хүний өөрөө өөрийгөө хөгжүүлж, эрх чөлөөтэй амьдрах явдлыг бүхэлд нь үгүйсгэж байв. Учир нь хүний хийж бүтээсэн ямар ч эд зүйлсийг түүний хувийн өмч гэж тооцдоггүй үзэл суртал оршин байсан юм.

Өмчлөх эрхийг хүндэтгэж үздэггүй, зүй ёсоор хамгаалж чаддаггүй бол нийгмийн тогтолцоо ямар гажуудалтай байгааг илтгэдэг. Өөрөөр хэлбэл энэ нь хувь хүний амьдрах, оршин суух, бие даасан байхад харшилж байна гэсэн үг юм гэж өнөө цагийн эрх зүйн онолчид үзэж байна.

Адам Смитээс авахуулаад ихэнх сэтгэгчид хүн өмчлөх эрхийг эдэлснээр нийгэм цаашид илүү хурдан хөгжиж, дэвшинэ гэж үзсээр ирсэн байна.

Ийнхүү хувийн өмч нь материаллаг ертөнцөд хувь хүний өөрийгөө тодорхойлох анхдагч эрх чөлөөг илэрхийлж байдаг гэсэн дүгнэлтэд хүрч байна. Түүнчлэн хувийн өмч хүний эрх чөлөөг илэрхийлэх анхдагч хэлбэр болоод зогсохгүй эрх зүйн сэтгэлгээний түүхэн хөгжлийн үндэс суурь нь болж байна.

Хувь хүн эрхээ эдлэх явцдаа өөрийн гэсэн эд баялагтай эсэхээс үл шалтгаалан өмчлөх эрхтэй байх ёстой гэдэгт оршино. Тэр ч байтугай хувь хүн өөрийн амьдралыг хий дэмий үрсэн ч гэсэн дээрхи эрхээ эдэлж байх ёстой гэж үздэг. Хэн, юугаа үрэн таран хийх нь бусад хэн нэгний бус, түүний өөрийнх нь эрх юм гэж тайлбарладаг. Хүн өөрөө хэрхэн, яаж амьдрах байдлаа шийдэж, түүнд сонголт хийнэ гэдэг бол эрх чөлөөтэй байхын эх үндэс бөгөөд энэ нь өмчлөх эрхийн илрэн гарч буй хамгийн чухал шинж юм.



2. ӨМЧЛӨХ ЭРХИЙН ОНОЛУУД

Эрх зүйн онолчдын маргааны төвд байнга оршдог хамгийн чухал сэдэв бол жинхэнэ өмчийг юу бий болгож, бүтээдэг тухай асуудал юм. Өмчийг яаж бүтээдэг тухай онолын хоёр үндсэн ойлголт өмчлөх эрхийн онолын судалгаанд хөндөгддөг.

1. Хөдөлмөрийн онол

Хичээл зүтгэл, уйгагүй хөдөлмөрийг өмчийн эх үндэс гэж үздэг Ж.Локкийн үзэл сэтгэлгээ үүнд хамаарна.

Ж.Локк хувийн өмчийн эрхийн үндсэн тулгуур багана нь жам ёсны эрх болох тухайд байр сууриа илэрхийлж байсан. “Засаглалын тухай хоёр дахь шаштир” бүтээлдээ “бурхан дэлхий ертөнцийг хүн төрөлхтөнд нийтэд нь зориулан бүтээсэн учир хувь хүн энэ дэлхийн нэг хэсэг гэдгээ хүлээн зөвшөөрүүлэхийг шаардах хууль ёсны эрхтэй” хэмээн бичсэн байна.

Тэрбээр цааш нь “хүн төрөлхөөс өөрөө өөрийнхөө хувь заяаг захиран удирддаг учраас тэдний хөдөлмөр ч ялгаагүй түүний өмч мөн юм. Хүн хөдөлмөрлөж байгаа үед түүний энэхүү хөдөлмөр ямар нэгэн объект руу чиглэх нь тодорхой. Ийнхүү хөдөлмөрийг өөртөө шингээсэн объект нь тухайн хүний өмч болно” гэж үзсэн юм.

Хөдөлмөрөөр өмчийг бүтээх онолын сонгодог чиглэл түүхэн хөгжлийн явцад гол төлөв газрын харилцаан дээр төвлөрөн хөгжсөн байдаг. Газар эзэмшигчийн өмч бол түүнийх, учир нь тэр үүний төлөө ажилласан гэж Ж.Локк үзэж байв. Энэ нь Ж.Локкийн ажиллах хүч буюу хөдөлмөр ба өмчлөлийн хоорондын харилцан хамаарлыг тайлбарлах гэсэн санаа бөгөөд өмнө нь хэн нэгний хөдөлмөр шингээгүй объектыг л ийнхүү хувьдаа өмчлөх боломжтой гэдгийг юун түрүүнд онцолсон юм.

Хөдөлмөрөөр өмчийг бүтээх үйл ажиллагаа нь аливаа нөхцөлд хууль ёсны байх ёстой тухайд тус онолыг орчин үед хөгжүүлэгчид голлон анхаарсаар иржээ. Жишээ нь, хэсэг газрыг тойруулаад хэн нэгэн хүн хашааны шон хатгасан тохиолдолд тэрхүү газар нь түүний өмчлөлд байж чадахгүй гэж энэ онолыг хөгжүүлэгч орчин үеийн судлаачид тайлбарладаг.

Шинэ тивийг нээснээр Европоос Америк руу шилжин суурьших хөдөлгөөн эрс нэмэгдэж, урьд өмнө хэний ч хөл хүрээгүй, эсвэл тэндхийн уугуул иргэдийн эзэмшиж байсан газар нутгийг цагаачид эзлэн авсны дараа засаг захиргааны зүгээс тэдний газрыг хуулийн дагуу албан ёсны өмч болгон хэлбэржүүлэх ажлыг зохион явуулахдаа өмчийн тухай хөдөлмөрийн онолыг суурь дэвсгэрээ болгосон билээ.

Хязгаарлаж дийлэхээргүй олон тооны цагаачид Америкт газрыг зөвшөөрөлгүйгээр эзэмшиж томохаук эрх гэх мэт өөрсдийн харилцаанд нийцүүлсэн зохиомол өмчлөх эрхийг бий болгон мөрдөж байсныг ерөнхийлөгч А.Линкольн

1862 онд Эдлэн газрын тухай хуулиар хуульчлан баталгаажуулсан байна. Уг хуульд “Зөвхөн дээр нь амьдарч, хөгжүүлэхийг зөвшөөрсөн хүмүүст 160 акр газрыг үнэгүй олгоно.” гэж заасан нь хөдөлмөрийн тусламжтай хувийн өмчийг бий болгох Ж.Локкийн онол бодит амьдрал дээр хэрэгжиж буйн жишээ болсон юм.

Бусдын өмчлөлд ороогүй объектыг өөрийн болгож авах нь зүй ёсны шинжийг агуулна гэсэн сонгодог үзэл баримтлал өнөөдөр эрх зүйн онолын хөгжлийн түвшинтэй уялдан илүү боловсронгуй хэлбэрийг олж байна. Өнөөдөр өмчийн тухай хөдөлмөрийн онолын олон янзын урсгал чиглэлүүд хөгжиж байгаа ч тэдгээрийн судлан тогтоох гэж зорьдог гол асуудал бол өмчийн хууль ёсны байдал юм. Хөдөлмөрийн тусламжтайгаар өмчийг бий болгох тухай онолоор хувийн өмчийн хууль ёсны байдлыг хэрхэн хангах тухайд зөвхөн өнөөдөр авч хэлэлцэж байгаа юу гэвэл бас үгүй юм. 17-18-р зууны үеийн Европын шинэ үеийн сэтгэгчид энэхүү онолын үндэс суурийг тавихын зэрэгцээ аливаа тохиолдолд өмч хэн нэгний мэдэлд шилжих явдал хууль ёсны дагуу явагдах ёстойг онцлон тэмдэглэж байсан болно.

2. Хомсдлын онол

Энэ онол өмчийн зорилго нь хомсдлыг арилгахад оршдог, хүмүүсийн эрэлт хэрэгцээ, шаардлага нь өмчийг бүтээдэг гэж үздэг.

Энэ онол ёсоор бол хүн төрөлхтний нэн эртний түүхэнд хамаарах түүн олзворлогчдын үед тэдэнд газрыг өмч болгох сонирхол байгаагүй байна. Учир нь тэд газраар дутагдаж байгаагүй бөгөөд бараг хэрэггүй байжээ. Харин газар тариалангийн нийгэмд газрыг өмч болгон хэрэглэж эхэлсэн байна. Учир нь тэдэнд тариа боловсруулах газар хэрэгтэй байсан юм гэж үздэг.

Хомсдлын онолыг хөгжүүлэхэд томоохон хувь нэмэр оруулсан хүн бол Дэвид Хьюм юм. Тэрээр зөвхөн хомсдол бий болсон тохиолдолд л өмчийн харилцаа өөрийн утгаа агуулдаг гэсэн саналыг дэвшүүлж байлаа.

Хомсдлын тухайд Ж.Локк ч мөн байр сууриа илэрхийлсэн байдаг. “Хэдийгээр эд баялгийг бусдаас түрүүлж эзэмшихдээ өөр хэн нэгний өмчлөх эрхэд халдаагүй боловч тухайн этгээдийн ийнхүү эд баялаг өмчилж буй явдал нь цаашдаа бусад иргэдийн нийтлэг ашиг сонирхолд хохирол учруулах магадлал байж болно. Энэ нь нөөц баялгийн хязгаарлагдмал байдал, түүний нөхөн сэргээгдэх цаг хугацаа зэрэг асуудал байж болох юм” хэмээн бичжээ.

Хэрвээ ийнхүү ашиг сонирхолд нь хохирол учирсан хүмүүс байхгүй бол “нийтэд зориулсан хангалттай бөгөөд хүрэлцэхүйц эд баялаг үлдсэн” гэдэгт итгэлтэй байж болох бөгөөд үүндээ сэтгэл ханамжтай байж болно хэмээн Ж.Локк үзжээ. Дээрхи асуултад өгсөн Ж.Локкийн тайлбар энгийн бөгөөд үр ашигтай хөдөлмөр эрхлэлтийн үр дүнд нийгэмд оршин буй бусад иргэнд зориулагдсан бараа бүтээгдэхүүний тоо



хэмжээ нэмэгдэнэ гэдгийг тэмдэглэхэд оршиж байлаа.

Хомсдлын онолыг хөгжүүлэгчид бүх өмч хомсдолтой холбоотой гэж үздэг ч орчин үед хүчээ аван хөгжиж буй оюуны өмчийн хувьд энэ нь хомсдолд шууд байдлаар өртдөггүй өвөрмөц хэлбэр юм. Түүнчлэн материалаг эд баялгаас ялгаатай нь оюуны өмч хэрэглээний хувьд хэн нэгэн хүн уг өмчийн объектыг хэрэглэж байгаа нь бусад хэдэн ч хүн түүнийг хэрэглэх бололцоог хязгаарладаггүй болохыг эндээс мэдэж авч болно.

3. Анархист онол

Анархист үзэл сэтгэлгээгээр өмчийг албан ёсны болгож, өмчлөх эрх эдлэхийн тулд төрөөс заавал зөвшөөрөл авах хэрэгтэй гэж үздэг. Гэхдээ өмчийн төрлөөс шалтгаалан төрөөс зөвшөөрөл авах үйл явц харилцан адилгүй байж болно гэж тэд үздэг.

Жишээ нь, оюуны өмч бол төрөөс хүлээн зөвшөөрөгдөхийн тулд маш нухацтай гэрээ хэлэлцээр хийхийг шаарддаг, үл хөдлөх хөрөнгийн өмчлөл нь мөн адил төрийн оролцоог ихээхэн чухалчилдаг, хөдлөх эд хөрөнгө, эсвэл гартаа барьж явж, зөөвөрлөх боломжтой өмч бол харьцангуй бага оролцоотой байдаг гэж үздэг. Харин хэн нэгний бие махбодод ямар ч хяналт, шаардлагыг төрийн зүгээс тавих хэрэггүй юм гэж энэ онолоор үздэг.

Гэхдээ энэ онол социалист шинжтэй гэгдэж шүүмжлэл дагуулдаг ба эхний хоёр онолын урсгалыг бодвол харьцангуй хязгаарлагдмал хүрээнд дэмжигдэж байна.

3. ӨМЧЛӨХ ЭРХ БА ХАРИУЦЛАГА

Өмчлөх эрх нь хувь хүний оршихуйн амин чухал элемент болохын хувьд хүний бие даасан байдлыг хамгаалж байдаг. Хувь хүн гэдэг ойлголт байгаа нөхцөлд өөрийн үзэл бодлын дагуу амьдралаа зохиож, хөтөлж явуулж байхыг ёс суртахууны үүднээс шаардаж байдаг.


Өмчлөх эрхийг эдлэхгүйгээр хувь хүний гаргах ёс суртахууны шийдвэр үр дүнтэй байж чаддаггүй. Үүнээс үүдэн нийгэмд хариуцлагын тогтолцоо оршин тогтнох боломжгүй болдог байна. Хүн өөрийнхөө хүсэл зоригийн дагуу үйл ажиллагаа явуулах эсэхээ сонгох ёстой. Эртний сэтгэгчдийн үзэж байснаар хариуцлага бол хүн өөрөө өөрийгөө маш сайн халамжлах гэсэн хэрэгцээ шаардлагын үр дүн юм.

“Хариуцлагыг ухаарсан хүн ирээдүйд нөөц хэрэгтэй гэдгийг сайн мэддэг бөгөөд эд баялгийг алсаа бодож хуримтлуулдаг. Ийм хүн өөрийн мэдэлд байгаа баялгийн талаар хариуцлагагүй шийдвэр гаргадаггүй” гэж сэтгэгчид үзсэн байна.

Ийнхүү өөрийн хувийн амьдралд хариуцлагатай хандаж чаддаг болсон цагт хүмүүс ямар нэгэн зохисгүй үйлдэл хийх нь багасах юм. “Өмчийг эзэмших явдал нь улс төрийн болон хууль эрх зүйн тогтолцооны өмнө үүрэг хүлээлгэдэг. Юу гэвэл сүүлийнх нь өмчлөх эрхийг баталгаажуулдаг. Тэд иргэдийг урд нь байсан шиг тэгш, бие даасан байдалтай болгодог” гэж Харвардын их сургуулийн багш, түүхч Ричард Пайпс үзсэн байдаг. Мөн Перугийн эдийн засагч Эрнадо дэ Сото Полар “Өмчийг хуульчлах нь ядууст хийж буй буян биш. Эзэмшигчдийг нь хариуцлагатай иргэд болгох, цэглэгдсэн зах зээлийг байгуулах явдал.” гэжээ.

Түүнчлэн Р.Нозикийн “түүхийн аль ч үед өмчийг дахин хуваарилах нь хувь хүний өөрийн сонголтоор өмчлөлөө зохицуулах тэрхүү эрх чөлөөт байдалтай нийцэхгүй байдаг” гэсэн бас нэгэн тайлбар байна. Эдгээр онолчдын тайлбараас үзвэл төрийн зүгээс үзүүлж буй энэ мэт баталгаа нь хувь хүний өөрийн хэрэгцээгээ хангах, хариуцлага хүлээх байдлыг үгүй хийдэг ажээ. Өөрөөр хэлбэл хүн хэрэгцээгээ хангахын тулд өөрт хариуцлага хүлээхээ болих сөрөг нөлөөтэй юм. Энэ нь хүн өөрийн хийсэн Х үйлдлээс гарах У үр дагаврыг хариуцах ёстой гэсэн үг юм.

Эндээс дараах дүгнэлтийг хийж болно. Хүн өмчлөх эрхийг эдлэх боломжгүй байвал хариуцлагатай байх боломжгүй юм.



Хариуцлагатай байх тухай ойлголт ёс суртахууны нэр томъёонд хамаарах хэдий ч улс төрийн хувьд ёс суртахуунлаг үйл ажиллагаа явуулах боломжгүй



байдаг. Тиймээс ёс суртахуун ба улс төр хоёрын дунд үндсэн зөрчил үүсдэг гэж зарим индивидуалист онолчид үздэг. Өөрөөр хэлбэл улс төрийн үйл ажиллагаа ёс зүйн шаардлагад бүрэн нийцдэггүй гэж тэд тайлбарлажээ. Энэ нь өмчлөх эрхийг эдлүүлдэггүй нийгэмд хамгийн их зөрчил үүсгэдэг хүчин зүйлсийн нэг байсаар иржээ. Учир нь энэ бол зөвхөн нэг хүний өөрийн амьдралд хэрэгцээтэй байгаа өмчийг олж авахад нь саад учруулж байгаа үйлдэл ч бус, тухайн хүнийг хариуцлагатай байх явдлыг үгүй хийж байгаа хэрэг юм

Хүн хүрээлэн буй орчинтой (Газар, гол мөрөн, ургамал, амьтан гэх мэт.) харилцаанд орохдоо хариуцлага хүлээх ёстой боловч тэдгээр зүйлсийг хувьдаа өмчлөх эрх олгосон аливаа нэг хязгаарлалт байдаггүйгээс, өөрөөр хэлбэл ямар хэмжээ хязгаарын дотор хувьдаа өмчлөх тухай ямар нэгэн зохицуулалт байдаггүйгээс хариуцлагатай хандах тухай тодорхой ойлголтгүй байдаг ажээ.

Өмчлөх эрх эдлэхгүйгээр дээрхи байдлаар буруу зүйл хийсэн хүнийг хуулийн дагуу шийтгэх, мөн зөв зүйл хийсэн хүнийг сайшаах зэрэг зүйл орших бололцоогүй юм. Энэ бол аль ч нийгэм хувийн өмчийг шуудхан үгүйсгэж чаддаггүйн шалтгаан болдог. Ийнхүү өмчлөх эрхийг эдлээгүй цагт хүн аливаа хариуцлагыг үүрэх боломжгүй байдаг. Хувийн өмч бол нийгмийн гишүүдэд хариуцлага үүрэх боломжийг олгож буй бодит илрэл нь юм. Хариуцлага нь хувийн өмчтэй харилцан хамааралтай байдаг гэж үздэг үндэслэгчид нь сонгодог либерализмын үзэл сэтгэлгээний чухал элементүүдийн нэг билээ.

4. ӨМЧЛӨХ ЭРХИЙН ХАМГААЛАЛТ

Сэдвийн зорилго: Өмчлөх эрхийг хэрхэн яаж хамгаалдаг талаар онолын болон практикийн ойлголттой болно.

1. Өмчлөх эрх нь хүний жам ёсны, халдашгүй, негатив эрх учраас түүнд өөрийн гэсэн хамгаалалт байх ёстойг эрх зүйн судлаачид цаг ямагт сануулсаар иржээ.

Нийгмийн амьдралын өнгөрсөн хугацааны түүхээс үзвэл хувийн өмчтэй байх явдлыг дэмжиж байсан олон янзын арга замуудын жишээ байдаг. Үүнээс хамгийн чухал арга хэрэгсэл нь өмчлөх эрхийг хамгаалах хууль зүйн хамгаалалт байх ёстой гэсэн шаардлага юм. Өмчлөх эрхийг хамгаалах үйл ажиллагаа бүх үеийн туршид нийгмийг баян чинээлэг байхад нөлөөлөөр иржээ.

Өмчлөх эрх, хувийн өмч нь хувь хүний оршихуйд нөлөөлдөг чухал хүчин зүйлсийг өөртөө агуулж байдаг учраас түүнийг хамгаалах нь гарцаагүй.

Өмчлөх эрхийг хамгаалах шаардлага

- Хувь хүний эдлэх эрхүүдээс практик ач холбогдлын хувьд хамгийн чухал
- Хувийн шинж чанараар харилцан адилгүй хүн бүрийн онцлогт нийцэн хэрэгжих боломжтой
- Хувь хүний хөгжлийн илэрхийлэл болдог буюу аливааг хийж бүтээх чадварын материаллаг илрэл болдог
- Хувь хүнийг бусдын нөлөөлөлд өртөхөөс сэргийлдэг
- Хувь хүний хийх сонголтоос гарах үр дагаврыг агуулж байдаг

Өмчлөх эрхийн нэг онцлог бол эрх чөлөөний ач холбогдолтой үйлдэл хийх хүний ёс суртахууны хамгаалалт нь бусдаас хараат бус, хуулиар хамгаалагдсан байдаг явдал юм. Тодруулбал, энэ нь хэн нэгний ёс суртахууны, эсвэл хууль ёсны эрхийг бусад хэн нэгэн субъект өөрчлөхөөс сэргийлдэг хамгаалалтын тухай ойлголт билээ. Хэрэв өмчлөгч нь ямар нэгэн үйлдлийг өмчлөх эрхийнхээ хүрээнд хийх тохиолдолд бусад этгээд нь өмчлөгчийн хийж буй тэрхүү үйлдлийн үр нөлөөллийг өөрчлөх боломжгүй байх ёстой гэсэн үг.



2. Нүцгэн эрхийн тухай ойлголт. Сонголтоос үүдэх хариуцлагыг өмчлөгч этгээдэд үүрүүлэхийн тулд тухайн үйлдэл хийх боломж нь хуулиар хамгаалагдсан байх ёстойг судлаачид юун түрүүнд чухалчлан авч үздэг. Хэрэв энэ нь ямар нэгэн байдлаар хамгаалагдаагүй тохиолдолд “нүцгэн эрх чөлөө” хэмээх ойлголтыг бий болгодог хэмээн тайлбарласан байна.

“Нүцгэн эрх чөлөө” (naked liberty буюу “нүцгэн эрх чөлөө” гэсэн нэр томъёог А.Харолын “Эрхийн онолууд” бүтээлээс уншиж болно.)-г хувь этгээдийн үйлдэл хийх эрхийг хамгаалан эрх мэдэл олгож, эрх чөлөөг нөхцөлдүүлж буй “хамгаалалтын хүрээ” (protective perimeter)-гээр тодорхойлодог хэмээн Х.Л.Харт үзжээ. Тэрээр “нүцгэн эрх чөлөө”-ний хүчгүйдлийг тайлбарлахдаа дараах жишээг авч үзсэн байна. Жишээлбэл, хоёр хүн зам дагуу алхаж яваад зам дээр хэвтэж буй хэтэвчийг олж харжээ. Хэрэв хэн нэг нь нөгөөгөөсөө өрсөж түүнийг авч чадах тохиолдолд хэтэвчийг өмчлөх боломж аль алинд нь бий. Энэ хэтэвчийг өөрийн мэдэлд авах эрх чөлөөг “нүцгэн эрх чөлөө” гэж үзвэл хэн ч тухайн хэтэвчийг өөрийн болгохын тулд бусдыгаа алах, хөнөөх боломжтой байх юм. Иймд хэтэвчийг өөрийн болгох эрх чөлөө нь хариуцлагын “хамгаалалтын хүрээ”-гээр тодорхойлогдоогүй тохиолдолд үнэ цэнэгүй ажээ. Иймд “хамгаалалтын хүрээ” нь хүний салшгүй, халдашгүй үндсэн эрх чөлөөг хамгаалахад тусгайлан зориулагддаг байна. Ийнхүү өмчлөх эрх төдийгүй бусад хүний эрх ч юуны өмнө хариуцлагын “хамгаалалтын хүрээ”-гээр хамгаалагдсан эрх чөлөө болон эрх мэдлээс бүрддэг гэсэн товч дүгнэлтийг хийж болох юм.

Нүцгэн эрхийн тухай онолоор хүний өмчлөх эрхээ хэрэгжүүлэх аливаа үйлдэл нь өөрийн хамгаалалтын хүрээг бий болгодог бөгөөд Эйн Рэнд үүнийг “Хүний эрх бол нийгэм дэх хувь хүний ёс суртахууныг хамгаалан, урьдчилан сэргийлдэг. Түүний зэрэгцээгээр бас хүний зан суртахууны ёс зүйг нийгмийн эрх зүйтэй, улс төрийг ёс суртахуунтай холбож өгдөг гинж юм. Хувь хүний эрх бол нийгмийг ёс суртахууны хуульд захируулах арга хэрэгсэл” хэмээн тайлбарласан байна.

Судлаачид “Өмчлөх эрхгүйгээр бусад ямар ч эрх хангагдахгүй. Хүн өөрийн амьдралыг өөрийнхөө л хүчээр явч явах ёстой болохоор тэрхүү хүчин зүтгэлээ гаргах эрхгүй байх аваас өөрийнхөө амьдралыг тэтгэж чадахгүй.” гэж тайлбарлажээ.

3. Хуульчилсан хамгаалалт. Өмчийн онолын сонгодог төлөөлөгч Ж.Локк өмчлөх эрхийг хамгаалах, түүнийг баталгаажуулах хамгийн оновчтой сонголт бол түүнийг хуульчлах явдал бөгөөд “Хэн нэгэн өмчийг хамгаалж зохицуулахын тулд бусад хүмүүстэй хамт нийгэмд элсчихээд тэр нийгмийн хуулиар зохицуулагдах ёстой өөрийнх нь хөрөнгө, өөрийн газар нь харьяат нь болж байгаа төрийнх нь хуулийн гадна байна гэж бодох юм бол шууд эсрэг зүйл болно биз дээ. Тэгэхээр аливаа хүн өмнө нь эрх чөлөөтэй байсан өөрийн биеийг төр улсад нэгтгэж байгаа тэр

баримтаар л мөн энэ хүртэл чөлөөтэй байсан эзэмшлээ тэр төрд нэгтгэн тушаадаг байна.” хэмээн тайлбарласан билээ. Ийнхүү хүний халдашгүй эрхийн хамгаалалтыг Үндсэн хуулиар баталгаажуулдаг.

Үндсэн хууль нь төрийн эрх мэдлийг хязгаарлан тогтоож, хүний эрх, эрх чөлөөг бэхжүүлэх зорилгод үйлчилдэг учраас энэхүү суурь хамгаалалтыг хийх үндсэн баримт бичиг болдог. Хүний эдлэх эрх, эрх чөлөөг бичмэл Үндсэн хуулиар баталгаажуулах нь зайлшгүй гэдэг үзлийг дэмжигч судлаачид байхад жам ёсны шинжтэй эрхүүдийг заавал Үндсэн хуулиар баталгаажуулах шаардлагагүй гэж үздэг өөр нэг хэсэг бий. Тэд Их Британийн Үндсэн хуулийг үүний нэг жишээ болгон тайлбарлаж байна.

Судлаачид хүний эрхийг Үндсэн хуулиар зайлшгүй баталгаажуулахыг шаарддаг үзэл баримтлалын хүрээнд хэрэв жам ёсны шинжтэй эрх, эрх чөлөөний халдашгүй байдлыг хангаж, түүнд хамгаалалт тогтооё гэж бодож байвал түүнийг зайлшгүй Үндсэн хуульд тодорхойлон бэхжүүлэх ёстой гэж үздэг. Учир нь бичмэл бус хэм хэмжээ нь ямагт түүнд тайлбар хийх боломжоор арвин байдаг бөгөөд бичмэл хэм хэмжээнээс илүү хурдан өөрчлөгдөх, гуйвуулагдах аюултай хэмээдэг.

Дүгнэвэл, орчин үеийн эрх зүйт төр бүр өөрийн Үндсэн хуультай, тэрхүү Үндсэн хууль нь хүний эрх, эрх чөлөөг хамгаалах үндсэн гол хэрэглэгдэхүүн болж байна.

Өмчлөх эрхийн хамгаалалтыг өнөө цаг үед Сирусын цилиндр (Эртний Персийн эзэнт гүрний үед хамаарах энэхүү бичмэл эх сурвалж нь өнөөдөр хүний эрхийн тухай дэлхийн анхны тунхаг бичиг хэмээн нэрлэгддэг билээ. Цилиндр хэлбэртэй шавар баримал дээр бичигдсэн түүхийн ховор баримт бичгийг 1879 онд Ассирын эрдэмтэн Хормузд Рассам Вавилон дахь Мардюкийн сүмээс олсон байна. Өдгөө уг олдвор Британийн музейд хадгалагдаж буй.) гэх мэт хамгийн эртний бичмэл хуулиудиас авахуулаад НҮБ-ын Хүний эрхийн түгээмэл тунхаглалын 17-р зүйл, мөн Францын Хүний ба иргэний эрхийн тунхагийн 17-р зүйл, Хүний эрхийн тухай Европын тунхагийн 1-р протокол зэрэг олон улсын шинж чанар бүхий орчин үеийн эрх зүйн баримт бичгүүдээс харж болно.

Хяналтын асуулт:

1. Өмчлөх эрх нь ямар учраас чухал вэ?
2. Хөдөлмөрөөр өмчийг бүтээх онолын сонгодог чиглэл аль харилцаан дээр голлон анхаарч байсан бэ, яагаад?
3. Хувь хүний бие даасан байдал, өмчлөх эрх, хариуцлага гурвын харилцан хамаарлыг тодорхойлно уу?
4. Нүцгэн эрх чөлөө гэх ойлголтыг тайлбарлана уу.



Ном зүй:

1. Armen Alchian (1965), Some Economics of Property Rights II Politico.
2. G.A Cohen (1995), Self-ownership, Freedom and Equality, Cambridge: Cambridge University Press.
3. H.L.A Hart (1982), Legal Rights. Oxford: Clarendon Press.
4. John Locke (1988), Two Treatises of Government [1689]
5. Peter Laslett (ed.), Cambridge: Cambridge University Press.
6. John Rawls (1971), A Theory of Justice, Cambridge: Harvard University Press.
7. Harel Alon, Theories of Rights /The Blackwell Guide to the Philosophy of Law and Legal Theory/ (2005) Blackwell Publishing Ltd.
8. Raz, Joseph. 1986. The Morality of Freedom. Oxford: Clarendon Press
9. Hohfeld Wesley Newcomb (1919), Fundamental Legal conceptions as Applied in Judicial Reasoning, ed. Walter Wheeler Cook. New Haven. CT: Yale University Press.
10. Murray Newton Rothbard (1949), Man, Economy and State. 2004. Chapter 2. Property: The Appropriation of Raw Land.
11. Jeffrie G. Murphy and Jules L. Coleman. Philosophy of Law. USA. 1990.
12. Jules Coleman and Scott Shapiro. Jurisprudence and Philosophy of Law. Oxford. 2002.
13. Kaufmann.A. Rechtsphilosophie.1997

XX бүлэг

Гэрээний эрхийн философи үндэс

Зорилго: Энэхүү сэдвийг зорилго нь орчин үеийн гэрээний эрх зүйн сэтгэлгээний хөгжил, гэрээний мөн чанарыг танин мэдэж, оюутны гэрээний эрх зүйн философи сэтгэлгээг төлөвшүүлэхэд чиглэнэ.

1. ГЭРЭЭ БА ЭРХ ЧӨЛӨӨ

Хүний оршихуйн үндэс болсон гэрээ нь Ф.Гегелийн үзсэнээр чөлөөт хүсэл зоригор илэрдэг юм. Өөрөөр хэлбэл хүн өөрийн хүсэл зоригор илэрхийлэн хэнтэй, яаж, ямар хэлбэрээр, ямар төрлийн гэрээ байгуулах, түүгээрээ ямар хэмжээгээр үүрэг хүлээх болон эрх эдлэх нь субъектын хүсэл зориг эрх чөлөөний илэрхийлэл юм.


Гэрээний эрх чөлөө нь юуны өмнө гэрээ байгуулах эрх чөлөөг өөртөө агуулдаг бөгөөд эндээс хэнтэй байгуулах, талууд гэрээний агуулгаа чөлөөтэй сонгох зэрэг эрх чөлөө урган гардаг. Хэн ч талуудын энэ эрхийг зөрчиж болохгүй бөгөөд түүнд хүндэтгэлтэй хандах учиртай. Талуудын эрхийг хамгаалах үүднээс гэрээ байгуулах эрх чөлөөг тодорхой тохиолдолд хязгаарладаг бөгөөд эндээс гэрээний эрх чөлөөний хязгаарлалт гэх ойлголт бий болно. Тухайлбал гэрээ байгуулах субъектээ сонгох эрх чөлөөг Монгол улсын Иргэний хуулийн ИХ§189.4, ИХ§381.1 зүйлсээр хязгаарласан байдаг. Өөрөөр хэлбэл гэрээг хэнтэй байгуулах нь талуудын гэрээний эрх чөлөө боловч нийгэмд тодорхой төрлийн бүтээгдэхүүн үйлдвэрлэх, ажил үйлчилгээ эрхлэх талаар тухайн зах зээлд давамгайлж байгаа этгээд энэхүү үйл ажиллагааны хүрээнд өөрт нь хандсан этгээдтэй гэрээ байгуулах үүрэгтэй байхаар зохицуулсан байна.

Хууль зүйн үүрэг бол ёс суртахууны баталгаа юм. Иймд гэрээний үүргийг зохих ёсоор биелүүлэх хамгаалалт бол ёс суртахуун болно.

2. ЁС СУРТАХУУН БА ГЭРЭЭ

Гэрээ нь дур зорго бус харин чөлөөт хүсэл зоригийн үр дүн учраас ёс суртахуун нь гэрээтэй шууд холбогддог.


Гэрээний үүргийг талууд биелүүлж байгаа нь ёс суртахууны шинжтэй зүйл бөгөөд угаасаа гэрээний эрх зүй нь ёс суртахууны үүрэгт тулгуурладаг юм. Өөрөөр хэлбэл талуудын хооронд гэрээ байгуулагдсанаар гэрээний үүргийн зэрэгцээ ёс суртахууны үүрэг үүсдэг байна.



Гэрээний эрх зүй дэх ёс суртахууны үүргийг олон сэтгэгч, онолчид хүлээн зөвшөөрдөг төдийгүй дэмжиж байдгийн учир нь гэрээ нь чөлөөт хүсэл зоригийн илэрхийлэл байдагт оршино.

Чөлөөт хүсэл зориг бол дур зорго бус харин ёс суртахуунтай, ухамсарт хүсэл зориг юм. Ийнхүү ухамсартай хүсэл зориг учир ёс суртахуунтай салшгүй холбоотой байдаг.

Ёс суртахууны онолчдын үзлээр гэрээ нь ёс суртахууны үүргээр хэрэгжих ёстой бөгөөд харин ёс суртахууны үүргээ биелүүлээгүй тохиолдолд төрийн албадлага, гэрээний эрх зүйн хэм хэмжээ шаардагддаг. Өөрөөр хэлбэл хүн ёс суртахуунтай тул бусдад амлалт өгч гэрээ байгуулсан бол түүнд гэрээний үүргийг биелүүлэх ёстой гэхээсээ илүүтэй ёс суртахууны үүргээ биелүүлэх сэтгэлгээгээр ханддаг. Зарим тохиолдолд л тодорхой шалтгааны улмаас ёс суртахууны үүргээ биелүүлэхгүй нөхцөл байдал үүсэх үед гэрээний эрх зүй хэрэглэгддэг гэж онолчид үзэж байна.




3. ГЭРЭЭНИЙ ЕРӨНХИЙ ОНОЛЫН ОЙЛГОЛТ, АНГИЛАЛ

Гэрээний эрх зүйн философийн хүрээнд гэрээний мөн чанарыг нээн илрүүлэхэд чиглэсэн онолуудыг гэрээний ерөнхий онол гэж нэрлэдэг.

Гэрээний ерөнхий онолууд нь гэрээ гэж юу вэ?, гэрээний үүрэг нь чухам ямар шинжийг агуулдаг үүрэг вэ?, гэрээний харилцаанд эрх зүй нөлөөлөх шаардлагатай эсэхэд хариулахад чиглэгддэг.

Гэрээний ерөнхий онолын ангилал:





4. ГЭРЭЭНИЙ ЕРӨНХИЙ ОНОЛУУДЫН АГУУЛГА

Аналитик асуултын онолууд:

Онол	Онолчид	Үндсэн үзэл санаа
Амлалтын онол	Чарльз Фрейд	<p>Амлалтын онол /promis theory/ нь гэрээний үүрэг нь амлалтын үр дүнд үүсдэг, сайн дурын шинжтэй үүрэг гэж үздэг. Өөрөөр хэлбэл гэрээ бол “амлалт” гэдгийг нотлоход энэ онол чиглэгддэг.</p> <p>Энэ онолын гол үндэслэл нь гэрээний эрх зүй нь амлалтын үүргийн хэрэгжилтэнд л зориулагдах ёстой гэдэгт оршино.</p> <p>Хүмүүс ямар нэгэн зүйлийг солилцдог бөгөөд энэ нь зайлшгүй амлалттай холбоотой байдаг гэж тэмдэглэсэн байна.</p>
Итгэлийн онол	Ферьдью Л.Фүллер,	<p>Итгэлийн онол /reliance theory/ нь гэрээний үүрэг нь итгэлд тулгуурласан үүрэг гэж үздэг. Хэн нэг этгээд бусдад итгэсний үндсэн дээр түүнтэй гэрээ байгуулдаг юм. Хэн нэгэнд итгээгүй бол гэрээ байгуулагдахгүй, гэрээний үүрэг нь итгэлийн шинжтэй үүрэг юм. Өөрөөр хэлбэл гэрээний үүрэг хэн нэг хүн магадгүй бусдад итгэсэн үед үүсдэг үүрэг юм.</p> <p>Ийнхүү энэ онолоор гэрээ нь итгэлд тулгуурласан үүрэг тул бусдын итгэлийг алдах нь зүй бус зүйл бөгөөд гэрээний үүргийг хэн нэг этгээд зөрчиж болохгүй гэдэгт энэ онолын гол утга санаа оршдог. Энэ утгаараа бусдад хохирол учруулсан бол уг хохирлыг нөхөн төлөх үүрэгтэй гэж үздэг. .</p>
Эрх шилжүүлэх онол	Петер Бэнсон	<p>Эрх шилжүүлэх /Right transfer theory/ онол нь гэрээ бол ямар нэгэн эрхийг шилжүүлж байгаа үйлдэл бөгөөд ялангуяа өмчлөх эрхийг шилжүүлж байгаа үйл явц юм гэж үздэг. Энэ онолын хүрээнд авч үзвэл гэрээний мөн чанар нь амлалт, итгэл найдвар, эсвэл үр ашиг зэрэг зүйлд оршдоггүй бөгөөд гэрээ нь зөвхөн эрх шилжүүлэх шинжтэй үүрэг юм .</p> <p>Энэ онолыг хөгжүүлж буй эрх зүйн онолч бол Петер Бэнсон юм. Тэрээр гэрээний үүрэг нь эрх шилжүүлэх үүрэг бөгөөд гэрээний үүргийн биелэлт нь ёс суртахуунаар хэрэгжих ёстой гэж үздэг байна.</p>

Норматив асуултын онолууд:

Онол	Онолчид	Үндсэн үзэл санаа
Утилитари онол	Жон Стюард Милл Жереми Бентам Ричард Поснер	<p>Гэрээний утилитари онол нь улс төрийн философийн утилитари онолд тулгуурлан хөгжсөн онол бөгөөд орчин үеийн гэрээний утилитари онолын гол төлөөлөгч нь Ричард Поснер юм.</p> <p>Утилитари үзэл бодлын сонгодог илэрхийлэл нь “аль болох олон хүнд, аль болох их аз жаргал” гэсэн зарчим бөгөөд энэ онол гэрээ нь талуудад аль болох ашигтай байх ёстой гэсэн зарчим баримталдаг.</p> <p>Утилитари онол нь үр ашгийн зарчимд суурилдаг бөгөөд энэ утгаараа гэрээний шинжийг талуудад ашигтай байх талаас нь тайлбарладаг. Гэрээний үүрэг нь талуудад ашиг авчрах бөгөөд хэн нэг нь гэрээний үүргээ зөрчвөл гэрээний ашигтай байдал үгүй болох тул талууд гэрээний үүргээ заавал биелүүлэх ёстой гэж үздэг.</p> <p>Ийнхүү утилитари онолоор бол гэрээний талууд нь ашиг олох зорилгоор гэрээг байгуулдаг бөгөөд талуудын хэн нь ч бусдын итгэлийг алдаж ашиг олох, хэрэгцээгээ хангах гэсэн зорилгыг нь хөсөрдүүлж болохгүй. Өөрөөр хэлбэл талууд гэрээний үүргээ заавал биелүүлэх ёстой бөгөөд хэрэв хэн нэг нь гэрээний үүргээ зохих ёсоор биелүүлээгүй бол нөгөө талд хохирол учирч гэрээнээс хүссэн хэрэгцээгээ хангаж чадахгүй, улмаар ашиггүй байдал үүсэх болно гэж үздэг.</p> <p>Гэрээ нь талуудад ашигтай байх гэдэгт зөвхөн материаллаг ашгийн тухай ойлгож болохгүй бөгөөд гэрээ нь талуудад ашигтай байх байдал нь тэдний хэрэгцээг хангаж байгаа байдлаар илэрнэ. Өөрөөр хэлбэл гэрээний утилитари онол нь сэтгэл ханамж гэдэг зүйлээр гэрээний үр ашгийг тооцдог. Магадгүй бодит байдал дээр талуудын хэн нэг нь гэрээнээс ашиг олоогүй ч тухайн субъект өөрөө гэрээнээс сэтгэл ханамжтай үлдсэн бол гэрээ үр ашигтай болсон гэж үздэг.</p>



<p>Эрхэд тулгуурласан онол</p>	<p>Рэнди Барннет</p>	<p>Энэ онол /right based theory/ нь гэрээний үүргийн биелэлтийг хувь хүний эрхээр тайлбарладаг. Хэрвээ гэрээний үүргийг аль нэг тал нь биелүүлэхгүй бол хувь хүний эрх зөрчигдөх болно гэж үздэг бөгөөд гэрээний эрх зүй нь хуулиар хэрэгжих ёстой. Мөн түүнчлэн гэрээний эрх зүй нь хувь хүний эрх, түүнийг хамгаалах үндсэн дээр оршин тогтнодог. Гэрээний онолч Стифен Смит эрхэд тулгуурласан онолын тэрхүү эрх гэж юуг хэлж байгааг тодорхойлох нь зүйтэй гэж үзэж, өөрийн бүтээлдээ эрх гэдэг нь И.Кантын эрхийн ойлголтонд тулгуурласан гэж тэмдэглэсэн байдаг. Бие хүний ёс суртахуун, бие даасан шинж, түүний үнэмлэхүй үнэт чанар бие хүнээс өөрийн үүргийг мэдэж биелүүлэх чадварын тухай санаан дээр тулгуурлаж байдаг.</p> <p>Эрхэд тулгуурласан онол нь гэрээний үүрэг нь хувь хүний эрхийг зөрчихгүй байх гэдэгт анхаарах бөгөөд гэрээний үүргийн хууль зүйн хэрэгжилтийг чухалчилдаг. Өөрөөр хэлбэл гэрээ нь эрх зүйд үндэслэсэн буюу хуульд нийцсэн байх ёстой. Гэрээ нь хуульд нийцэж байж л талууд гэрээний үүргийг үүрэг гүйцэтгэгчээс шаардах эрх бий болно гэж үздэг учраас гэрээний ерөнхий онолын норматив асуултад хангалттай хариулдаг юм. Хэрэв талуудын хэн нэг нь гэрээний үүргээ зохих ёсоор гүйцэтгээгүй бол төрийн албадлага хэрэглэхийг чухалчлан, гэрээний талуудын эрхийг эрх зүйгээр хамгаалах, зөрчигдсөн тохиолдолд төрийн албадлага хэрэглэх нь зүй ёсны зүйл хэмээн үздэг.</p>
--------------------------------	----------------------	--

Хүсэл зоригийн онол	Жэймс Гордли	<p>Хүсэл зоригийн /will theory/ онолын агуулга нь гэрээ нь талуудын хүсэл зоригийн үр дүн буюу өөрөөр хэлбэл гэрээний үүрэг нь хүсэл зоригийн шинжтэй үүрэг гэдэгт оршино. Улмаар гэрээний эрх зүй нь талуудын хүсэл зоригийг хамгаалахад зориулагдсан.</p> <p>Энэ онол нь гэрээний хууль ёсны байх норматив шинжийг хүлээн зөвшөөрөх төдийгүй гэрээ нь угаас хуульд нийцсэн байх ёстой хэмээн үздэг. Үүрэг гүйцэтгэгч үүргээ зохих ёсоор биелүүлэхгүй байх нь үүрэг гүйцэтгүүлэгчийн хүсэл зоригийг хүсэрдүүлсэн зүйл бөгөөд энэ нь хууль зүйн хувьд заавал биелүүлэх үүргийг агуулна. Энэ утгаараа гэрээний талууд гэрээний үүргээ биелүүлээгүй бол хүч хэрэглэх буюу төрийн албадлага хэрэглэх нь зүй ёсны юм.</p> <p>Хүсэл зоригийн онол нь гэрээний үүрэг нь заавал хэрэгжих ёстой гэдгийг нотолсоор байна. Яагаад гэвэл гэрээний талууд тэрхүү гэрээгээр хүлээсэн үүргийг хүссэн бөгөөд улмаар тэр үүргийн хэмжээ хязгаарыг өөрөө сонгосон юм.</p> <p>Хүсэл зоригийн онолд дараах хоёр зүйл агуулагдах ёстой гэж үзсэн. Үүнд:</p> <ol style="list-style-type: none"> 1. Талууд нэгнийхээ хүсэл зоригт хүндэтгэлтэй хандах ёстой 2. Талуудын хувьд хүсэл зоригийн илэрхийлэл буюу амлалт нь тэдгээрийн үүргийн эх сурвалжийн шалгаан нь болсон байх ёстой. Эдгээр нь түүний хүссэн хүслийн хязгаар юм.
---------------------	--------------	---

Хяналтын асуулт:

1. Гэрээ нь ёс суртахууны үүргээр хэрэгждэг гэсэн үндэслэлийг боловсруулна уу.
2. Ф.Гегелийн авч үзсэн формаль эрх чөлөө нь гэрээний эрх чөлөөний агуулгыг илэрхийлж чадах уу?
3. Яагаад гэрээний үүрэгт хууль зүйн хэрэгжилт хэрэгтэй байдаг вэ?
4. Утилитари онолын “үр ашиг”-ийн ойлголтын агуулгын хүрээг тодорхойлно уу?
5. Зүй ёсны хувьд гэрээний үүргийн биелэлт нь ёс суртахуун болон гэрээний эрх зүйн алинд нь илүү үндэслэгдэх ёстой юу ?
6. Гэрээний ерөнхий онолуудын аль нь үүрэг гүйцэтгэгч гэрээгээр хүлээсэн үүргээ биелүүлээгүйгээс үүрэг гүйцэтгүүлэгчид хохирол учирсан бол учирсан хохиролыг арилгах ёстой гэх үндэслэлээр өөрийн онолын үндэслэлийг тайлбарладаг вэ?



Ном зүй:

1. Charles Fried(1981), Contract as Promise: A Theory of Contractual Obligation, Harvard University Press.
2. P.Benson (2001), The theory of Contract law: New essays, Cambridge University Press
3. Stephen Smith (2004) Contract theory, Oxford University Press,
4. Jeffrie Murphy, Jules Coleman (1990), Philosophy of law,
5. Grant Gilmore, L.Collins (1995), Ohio State University Press
6. В.Гэрэлт-Од, Б.Батчулуун Гэрээний эрх зүй УБ., 2006
7. Монголын төр эрх зүй. Сэтгүүл № 2 (68) 2012. 20-22 дах тал
8. Jeffrie G. Murphy and Jules L. Coleman. Philosophy of Law. USA. 1990.
9. Jules Coleman and Scott Shapiro. Jurisprudence and Philosophy of Law. Oxford. 2002.

